

ЭХ БАРИХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН СОРИЛ

СОРИЛЫН ТӨРӨЛ БА ХАРИУЛАХ ЗААВАР

- А хэлбэрийн сорил. Энэ хэлбэрийн сорилын сонголт нь А, В, С, D, E гэсэн үсгэн дугаартай байх ба хамгийн зөв нэг хариултыг сонгож, хариултын дугаарын үсгийг шууд тэмдэглэнэ.
- К хэлбэрийн /Комплекс/ сорил. Энэ хэлбэрийн сорилын сонголтууд нь 1, 2, 3, 4, 5 гэсэн тоогоор дугаарлагдсан байх ба тэдгээрээс нэг болон хэд хэдэн хариултыг сонгоод дараах түлхүүрийг ашиглан тэмдэглэнэ.
Түлхүүр: 1, 2, 3 гэсэн дугаарыг сонгосон бол A
1, 2, 3, 4 гэсэн дугаарыг сонгосон бол B
2, 4 гэсэн дугаарыг сонгосон бол C
Зөвхөн 4 гэсэн дугаарыг сонгосон бол D
1, 2, 3, 4, 5 буюу бүх дугаарыг сонгосон бол E
үсгээр тус тустэмдэглэнэ.

НЭГ.ЭХ БАРИХ ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН ЭМЧ НАРТ ЗОРИУЛСАН СОРИЛ

I. ЭХ БАРИХ

I.I. А хэлбэрийн сорил

1. Дискоординацийн үед дараахаас аль нь хийгдэхгүй эмчилгээ вэ?
A. Тайвшруулах
B. Умайн хүзүүнд новокайны хориг хийх.
C. Гөлгөр булчинг суллах
D. Өвдөлт намдаалт хийх
E. Төрөлтийг эрчимжүүлэх
3. Ургийн "дистресс" гэдэг нь:
A. Ургийн хүчилтөрөгчийн дутагдал.
B. Ургийн бүтэлт.
C. Ураг ихсийн дутмагшил.
D. Хүйн цусны эргэлт алдагдах.
E. Ургийн бүх эрхтний хэвийн үйл ажиллагаа алдагдах
4. Дараахаас аль нь уйтан аарцгийн зэргийг тогтооход ашиглах вэ?
A. Ташаа ясны урд. дээд сэртэнгүүдийн хоорондын зай
B. Гадна шулуун хэмжээ
C. Con. Diagonalis
D. Ташаа ясны дэлбээний алслагдсан зай

- Е. Жинхэнэ шулуун хэмжээ
5. Ургийн толгойн тэнхлэгийн тавилт гэсэн ойлголтыг тэмдэглэнэ үү?
- А. Суман заадас аарцгийн ууцны төвгөр умдаг хоёрын хооронд ижил зайд байрлах
- В. Суман заадас орох хэсгийн хавтгайд хөндлөн тавигдах
- С. Суман заадас орох хэсгийн хавтгайн ташуу хэмжээнд давхцан тавигдах
- D. Суман заадас умдганд ойр байрлах
- Е. Суман заадас ууцанд ойр байрлах
6. Перинаталь үе гэдэг нь:
- А. Үр хөврөл бүрэлдэн тогтносноос төрөх хүртэлх хугацаа
- В. Үр хөврөл бүрэлдэн тогтносноос жирэмсний 20 долоо хоног хүртлэх хугацаа
- С. Жирэмсний 22 долоо хоногтойгоос ураг төрж гарах хүртэлх хугацаа
- D. Жирэмсний 22 долоо хоногтойгоос төрсний дараах эхний 21 өдөр хүртлэх хугацаа
- Е. Жирэмсний 28 долоо хоногтойгоос төрсний дараа 7 өдөр хүртлэх хугацаа
7. Эмэгтэй төрөх өрөөнд хянагдаж байсан. Гэнэт бөөлжиж, хэвлийгээр хүчтэй өвдөж, арьс салст нь цайж цонхийсон, умайн хэлбэр зөв биш, эмзэглэлтэй, УЗЦ бүдэг, жигд биш, 1 хоромд 100 удаа. Үтрээний үзлэгээр: Умайн хүзүү бүрэн нээгдсэн, УОШ-ий хальс бүтэн, толгой аарцагт $2/5$ байна. урьдчилсан онош тавина уу?
- А. Ургийн шингэний бөглөрөл
- В. Умай урагдсан
- С. Тромбоэмболи
- D. Ихэс ховхролт
- Е. Эмнэл зүйн уйтан аарцаг
8. Төрөлтийн идэвхтэй үе удаашрахад авах эхний арга хэмжээ?
- А. Умай агшаах тариа
- В. Спазмолитик
- С. Амниотоми
- D. Өвдөлт намдаалт
- Е. Эпизиотоми
9. Ихэр жирэмсэн үед урагт тохиолдох хүндрэлийг нэрлэнэ үү?
- А. Илүү тээлт
- В. Ургаас урагт цус юүлэгдэх
- С. Дотоод халдвар
- D. Ургийн гаж хөгжил
- Е. Эмнэл зүйн уйтан аарцаг үүсэх
10. Кольпоцитологийн шинжилгээг дараах оношилгоонд хэргэлэнэ:
- А. Жирэмсэн үеийн эстроген дааврын ханалтыг дам аргаар тодорхойлох
- В. Үтрээний цэвэршилтийн зэргийг тогтоох

- C. Умайн хүзүүнээс бактери илрүүлэх
- D. Ургийн гаж хөгжлийг илрүүлэх
- E. Ургийн шингэн гарсан эсэхийг тодорхойлох

11. Жирэмсний эрт хугацаанд аяндаа зулбах үндсэн шалтгааныг нэрлэнэ үү:

- A. Цусны бүлгийн үл тохироо
- B. Умайн салстын үрэвсэл
- C. Умайд соривтой байх
- D. Хромосомын гажиг
- E. Умайн хүзүүний дутмагшил

12. Жирэмсний даралт ихсэлтийн үед хэрэглэхэд тохиромжгүй эмийг нэрлэнэ үү?

- A. Ангиотензин хувиргагч ферментийг саатуулагч
- B. Метил дофа
- C. β -блокатор
- D. Кальцийн сувгийн блокатор
- E. Магни сульфат

13. Аль нь ургийн гадаад орчин болдог вэ?

- A. Хорион
- B. Умай
- C. Шар уутанцар
- D. Аллантаоис
- E. Амнион

14. Ургийн үе жирэмсний аль хугацаанаас эхэлдэг болохыг нэрлэнэ үү?

- A. Эхний нэг сарын төгсгөл
- B. Хоёрдох сард
- C. Гурав дахь сарын эхээр
- D. Гурав дахь гурван сарын төгсгөлөөс
- E. Дөрвөн сарын эхээр

15. Цулцан хураагийн үед гистологи шинжилгээгээр аль шинж илрэхгүй вэ?

- A. Цэлмэнд их хэмжээний цусны судас үүсэх
- B. Ургийн эд байхгүй байх
- C. Трофобласт үржих;
- D. Цэлмэн томрох;
- E. Цэлмэн хавагнах .

16. Жирэмсний 37 долоо хоногтойд ямар нэгэн зовиургүйгээр үтрээнээс цус гарч байвал эхний ээлжинд ямар арга хэмжээ авах вэ?

- A. Цусны бүлэгнэлтийг тодорхойлно
- B. Үтрээнд толь тавьж харна
- C. Кесар сэс засалд бэлдэнэ
- D. Төрөлтийг сэдээнэ

- Е. Ургийн бүрхүүл хальсыг хагална
17. Базлалт сайн байгааг илтгэх шинжийг нэрлэнэ үү
- А. Умайн базлалт 10 хоромд 1-2 удаа базлалт 25 сек үргэлжилж байвал
 - В. Умайн базлалт 10 хоромд 3 удаа 20-25 сек үргэлжилж байвал
 - С. Умайн базлалт 10 хоромд 3 удаа 40-60 сек үргэлжилж байвал
 - D. Умайн базлалт 10 хоромд 4 удаа 80- секундээс илүү үргэлжилж байвал
 - Е. Умайн базлалт 10 хоромд 5-6 удаа 60-80 сек үргэлжилж байвал
18. Кефалогематом гэдэг нь :
- А. Зөөлөн эдийн хаван
 - В. Ясан доор цус хурах
 - С. Арьс өөхөн эдийн завсар цус хурах
 - D. Тархины хатуу хальсны доор цус хурах
 - Е. Тархины ховдолд цус хурах
19. Давтан төрөгч эмэгтэйд умайн хүзүү цагт хэдэн см нээгдвэл хэвийн гэж үзэх вэ?
- А. 1 цагт 0,2 см
 - В. 1 цагт 0,5 см
 - С. 1 цагт 0,7 см
 - D. 1 цагт 1,5 см
 - Е. 1 цагт 3 см
20. Жингийн илүүдэлтэй эмэгтэйчүүд жирэмсний хугацаанд хэдэн кг нэмэгдвэл зохистой вэ?
- А. 15-20 кг
 - В. 10-12 кг
 - С. 6-8 кг
 - D. 2-5 кг
 - Е. 2 кг хүртэл
21. Пренатал анагаах ухаан гэдэг нь:
- А. Жирэмсний бүхий л хугацаанд ураг судлал
 - В. Төрсний дараах нярайн судлал
 - С. Жирэмсний 21 долоо хоног дотор ураг судлал
 - D. Жирэмсний 39-40 долоо хоногийн дотор ураг судлал
 - Е. Жирэмсний 21-4 долоо хоногийн хугацааны ураг судлал
22. Жирэмсэн үеийн антенаталь ураг хамгаалал гэж юу вэ?
- А. Жирэмсний 21 долоо хоног дотор
 - В. Жирэмсний 21-36 долоо хоног
 - С. Жирэмсний зөвхөн 37-40 долоо хоног
 - D. Жирэмсний 22 долоо хоногоос төрөх хугацааны ураг хамгаалал
 - Е. Төрсний дараах үеийн ураг хамгаалал
23. Жирэмсэн үеийн интернатал ураг хамгаалал гэж юу вэ?
- А. Жирэмсний 21 долоо хоног дотор

- B. Жирэмсний 21-36 долоо хоног
 - C. Жирэмсний зөвхөн 37-40 долоо хоног
 - D. Төрөлтийн үйл ажиллагаа эхэлж, төрөх хүртлэх үеийн ураг хамгаалал
 - E. Төрсний дараах үеийн ураг хамгаалал
24. Жирэмсэн эхэд цагт ялгарах шээсний хэвийн дундаж хэмжээ
- A. Цагт 20 мл-ээс бага
 - B. Цагт 30 мл
 - C. Цагт 54 мл
 - D. Цагт 84 мл
 - E. Цагт 94 мл-ээс дээш
25. Жирэмсэн үед зүрх судасны тогтолцоонд үүсэх физиологийн өөрчлөлт:
- A. Зүрхний ачаалал нэмэгдэж хэмжээгээрээ томорно
 - B. Зүрхний II цэгт сулралын шуугиан сонсогдоно
 - C. Зүрхний оройд сулавтар агшилтын шуугиан 30%-д сонсондоно
 - D. Артерийн даралт 20 мм мубе болж нэмэгдэнэ
 - E. Зүрхний агшилт 100 болж түргэсэнэ
26. Умайн гурсан хойлойн фимбр хэсэгт жирэмслэлт хэдэн долоо хоног хүртэл үргэлжилж болох вэ?
- A. Жирэмсний 5-6 долоо хоног
 - B. Жирэмсний 6-7 долоо хоног
 - C. Жирэмсний 7-8 долоо хоног
 - D. Жирэмсний 8-9 долоо хоног
 - E. Жирэмсний 9-10 долоо хоног
27. Умайн гаднах жирэмслэлт үүсгэх өндөр эрсдэлд аль нь хамаарах вэ?
- A. Биений юмны мөчлөгийн алдагдал
 - B. Хламидийн халдвар
 - C. Өмнө нь гуурсан хоолойд мэс засал хийлгэж байсан
 - D. Бага аарцгийн эрхтэний үрэвэлт өвчин
 - E. Умай хэт арагш байрлалтай байх
 - E. Геюкозын уусмал
28. Жирэмсний 31-32 долоо хоногтой умайн хүзүүний нээлт 3 см, ураг бүтэлтгүй, ураг орчмын шингэний бүрхүүл бүтэн, халдваргүй, базалт 10 хоромд 1 удаа, төрөлтийг яаж шийдэх вэ?
- A. Төрөлтийг идэвхитэй удирдана
 - B. Токолитик хийнэ
 - C. Кесар мэс заслаар төрүүлнэ
 - D. Ажиглаж хянана
 - E. Антибиотик эмчилгээ хийж хянана
29. Эр бэлгийн эс хэвийн амьдрах дундаж хугацаа?
- A. 12-24 цаг

- B. 24-32 цаг
 - C. 48-72 цаг
 - D. 72-88 цаг
 - E. 100-гаас дээш цаг
30. Бүрэлдсэн эвсэл үр хэдэн хоногийн дараа умайн хөндийн салст бүрхэвчэнд сууж эхлэх вэ?
- A. 3-4 хоногт
 - B. 5-6 хоногт
 - C. 6-7 хоногт
 - D. 7-9 хоногт
 - E. 9-14 хоногт
31. Эмэгтэйн 1 мл шээсэнд нянгийн хэмжээ хэдээс бага бол хэвийн гэж үзэх вэ?
- A. Илрэх ёсгүй
 - B. 1 мл шээсэнд 10^2 нян
 - C. 1 мл шээсэнд 10^3 нян
 - D. 1 мл шээсэнд 10^4 нян
 - E. 1 мл шээсэнд 10^5 нян
32. Хэрэв эх нь 0I, эцэг нь B III бүлгийн цустай бол A II бүлгийн цустай хүүхэд төрж болох тохиолдлыг хэлнэ үү?
- A. 0%
 - B. 25%
 - C. 50%
 - D. 75%
 - E. 100%
33. Жирэмсний хэдэн долоо хоногтойгоос ураг орчмын шингэн багасаж эхлэх вэ?
- A. Жирэмсний 28 долоо хоногоос хойш
 - B. Жирэмсний 32 долоо хоногоос хойш
 - C. Жирэмсний 34 долоо хоногоос хойш
 - D. Жирэмсний 36 долоо долоо хоногтойгоос
 - E. Жирэмсний 39-40 долоо хоногтойд
34. Жирэмсний үеийн протромбины индексийн хэвийн хэмжээ:
- A. 60-80%
 - B. 80-100%
 - C. 105-110%
 - D. 110-120%
 - E. 120%-аас дээш
35. Индекс Соловьевын мөн чанар юу вэ?
- A. Төрөлтөнд бэлтгэгдсэн байдлыг үзнэ
 - B. Ясны зузаан, нимгэн байдлыг тодорхойлно
 - C. Жирэмсний хугацааг тодорхойлох

- D. Аарцгийн уйтралын зэргийг тогтоох
 - E. Аарцгийн хэмжээг үнэлэх
36. Дараахаас аль үед ганглиоблокаторыг хэрэглэх вэ?
- A. Цус алдалтын дайрлага
 - B. Жирэмсний хожуу хордлогын хүнд хэлбэр
 - C. Зүрх судасны хурц дутагдал
 - D. Судасны хана хатуурах өвчин
 - E. Үжлийн дайрлага
37. Дараах тохиолдлуудаас аль үед жирэмсэн эмэгтэйн даралт ихдэж болох вэ?
- A. Чихрийн шижин өвчин
 - B. Иценко-Кушингийн хам шинж
 - C. Мендельсоны хам шинж
 - D. Аорт-Каваль хам шинж
 - E. Уушигны сүрьеэ
38. Ургийн уушигны хөгжлийг сайжруулах зорилгоор хийх эмчилгээнд аль нь хамаарах вэ?
- A. Сульфат магни
 - B. Агчил тавиулах
 - C. Глюкокортикоид
 - D. Кальц хлорид
 - E. Даралт бууруулах эм
39. Умайн хүзүүний II зэргийн урагдал гэж тооцох
- A. 2 талдаа 1 см хүртэл урагдсан
 - B. 1 талдаа 3 см хүртэл урагдсан
 - C. Хүнхрээ хүртэл урагдсан
 - D. Умайн хүзүү язарсан
 - E. 2 талдаа хүнхрээ хүртэл урагдсан
40. Эмэгтэй резус $-/-$ цустай бол жирэмсний явцад ямар хүндрэл голлон тохиолдох вэ?
- A. Ихэс ховхорч цус алдах
 - B. Ураг амьгүй болох
 - C. Эхэд шарлалт үүсэх
 - D. Ургийн гажиг хөгжил үүсэх
 - E. Ураг орчмын шингэн багасах
41. Клементсийн сорилоор юуг тодорхойлж болохыг хэлнэ үү.
- A. Ургийн жинг урьдчилан тогтооно
 - B. Изо-серологийн үл зохицолдоог тодруулна
 - C. Ургийн бүтэлтийг илрүүлнэ
 - D. Ургийн уушигны хөгжлийн гүйцлийг тодорхойлно
 - E. Ургийн хөдөлгөөний идэвхжилийг тодорхойлно
42. Ямар хэмжээний цус алдахад цус алдалтын дайрлагын III үе үүсэх вэ?

- A. 20-30%
- B. 25-40%
- C. 40-45%
- D. 60-70%
- E. 70-80%

43. Дайрлагын индексийг тодорхойлох:

- A. Судасны цохилтыг агшилтын даралтанд харьцуулна
- B. Судасны цохилтыг сулралтын даралтанд харьцуулна
- C. Судасны цохилтыг пульсийн даралтанд харьцуулна
- D. Судасны цохилтыг чамархайн артерийн даралтыг харьцуулна
- E. Артерийн даралтаар тодорхойлно

44. Цус алдалтын дайрлагын II зэрэгтэй байхад шингэнг нэг хоромд ямар хурдаар юүлэх вэ?

- A. 30-50мл
- B. 50-70мл
- C. 70-100мл
- D. 300-350мл
- E. Ач холбогдолгүй

45. Гепариныг судсаар тарихад хичнээн хугацааны дараа цусны бүлэгнэлтийн эсрэг үйлчилгээ үзүүлж эхлэх вэ?

- A. 30 хормын дараа
- B. 15 хормын дараа
- C. Эхний 30 секундын дараа
- D. 1 цагын дараа
- E. 5 цагын дараа

46. Жирэмсний хугацаа 10-11 долоо хоног, үзлэгээр умайн хүзүүний амсар хурууны үзүүр орох төдий байгаа халдварлагдсан зулбалтын үед 6 цагийн эрчимт эмчилгээний дараа шээсний гарц 30 мл А/Д 100/60, судасны цохилт 104 мин, 38,5⁰ халуунтай байна. Цаашдын эмчилгээний чиглэлийг сонгоно уу?

- A. Антибиотик дусааж умайн хөндийг хусаж цэвэрлэх
- B. Гар соруурын аргаар зөөлөн соруулна
- C. Эмчилгээг үргэлжлүүлэн хийж 24 цаг ажиглана
- D. Эмийн аргаар зулбуулна
- E. Халдварын голомтыг авах мэс зүасал хийнэ

47. Хэт авианы шинжилгээнд “цасны хуйлирааны” шинж ямар эмгэгийн үед илрэх вэ?

- A. Ураг амьгүй болох
- B. Цулцан хураа
- C. Өсөлтгүй жирэмсэн
- D. Хорионэпителиом
- E. Ургийн шингэний халдвар

48. Жирэмсний А/Д багадалтын үед шээсээр ялгаралт нэмэгдэж цусанд багасдаг бодисыг нэрлэнэ үү?
- A. 17 оксикортикостероид
 - B. Мочевин
 - C. Шээсний хүчил
 - D. Уураг
 - E. Креатинин
49. Том жинтэй хүүхэд төрүүлдэг өгүүлэлтэй, жирэмсэн эмэгтэйд хийсэн ачаалалтай сорилоор цусны сахар өлөн үед 5,4 ммоль/л, цагийн дараа 12,5 ммоль/л, 2 цагийн дараа 8,4 ммоль/л бол юу гэж тайлбарлах вэ?
- A. Сорил хэвийн
 - B. Чихрийн шижин илэрсэн
 - C. Сорил өөрчлөлттэй
 - D. Сорилыг давтан хийх
 - E. Сорилыг инсулин 7 хоног хэрэглсэний дараа давтан хийх
50. Аарцгийн хэмжээ 25-28-31-18 бол ямар хэлбэрийн аарцагт тохирох вэ?
- A. Энгийн хавчиг аарцагт
 - B. Хавчиг-сульдаатай аарцагт
 - C. Жигд уйтарсан аарцагт
 - D. Жигд уйтарсан хавчиг аарцагт
 - E. Хэвийн хэмжээтэй аарцаг
51. Умайн хүзүүний бэлтгэлийн байдлыг үнэлэхэд аль нь гол үзүүлэлт вэ?
- A. Умайн хүзүү зөөлрөлт
 - B. Ургийн шингэн гарах
 - C. Умайн хүзүү ахар сүүл рүү ойртох
 - D. Умайн хүзүү умдаг ясруу ойртох
 - E. Умайд базлалт үүсэх
52. Жирэмсэн эмэгтэйн үтрээний наацын эсзүйн шинжилгээнд завсрын эс давамгайлсан, завь хэлбэрийн эс цөөн, ЭИ-2%, КПИ-6% байна. Хэзээ төрөхийг тодорхойлно уу?
- A. 2 долоо хоногийн дараа
 - B. 3 долоо хоногийн дараа
 - C. 4-8 долоо хоногийн дараа
 - D. 1-2 хоногийн дараа
 - E. 24 цагийн дотор
53. Аарцгийн хэмжээ 24-26-28-16-9 бол уйтан аарцгийн хэлбэрийг тодорхойлно уу?
- A. Жигд уйтарсан аарцаг
 - B. Хөндлөн уйтарсан аарцаг
 - C. Жигд уйтарсан хавтгай аарцаг
 - D. Энгийн хавтгай аарцаг

- Е. Сульдаагийн хавтгай аарцаг
54. Ургийн толгойн тэнхлэгийн тавилтыг тэмдэглэнэ үү?
- А. Суман заадас асуух нугалам, умдагнаас ижил зайд байрлах
 - В. Суман заадас орох хэсгийн хавтгайд хөндлөн тавигдах
 - С. Суман заадас орох хэсгийн хавтгайн ташуу хэмжээнд давхцан тавигдах
 - D. Суман заадас умдагнд ойр байрлах
 - Е. Суман заадас ууцанд ойр байрлах
55. Жирэмсний эрт хугацаанд ургийн ДНК–г шинжлэхийн тулд шинжилгээний материалыг ямар замаар авах вэ?
- А. Фетоскопи
 - В. Амниоцентез
 - С. Кордоцентез
 - D. Цэлмэнгийн биопси
 - Е. Ургийн эдээс биопси
56. Төрсний дараа хэд хоногт умайн ёроол умдагны дээд ирмэгт очих вэ?
- А. 4-5 дахь хоногт
 - В. 5-6 дахь хоногт
 - С. 7-8 дахь хоногт
 - D. 9-10 дахь хоногт
 - Е. 10-12 дахь хоногт
57. Умайн гаднах жирэмслэлтийг эрт хугацаанд ялган оношлохын тулд ХГД –ыг цусанд хэдий хугацааны дараа давтан тодорхойлох шаардлагатай вэ?
- А. 12-24 цагийн дараа
 - В. 24-48 цагийн дараа
 - С. 48-72 цагийн дараа
 - D. 72-108 цагийн дараа
 - Е. 7 хоногийн дараа
58. Хэт авиан шинжилгээгээр эрт үеийн пренаталь оношилгоо хийх тохиромжтой хугацаа?
- А. 6-10 долоо хоног
 - В. 11-13 долоо хоног
 - С. 14-16 долоо хоног
 - D. 16-24 долоо хоног
 - Е. 24-26 долоо хоног
59. Эх 3500,0 хүүхэд хэвийн төрүүлсэн. Хойтхийг салгах үед умай урвасан, Ихэс хаана байрлахад умай урвах эрсдэл илүү байх вэ?
- А. Ёроолд
 - В. Урд
 - С. Ард
 - D. Хажуугийн хананд

Е. Умайн доод сегментэд

60. Тулгар төрөгч эмэгтэй, жирэмсний 39 долоо хоногтой төрөх үйл ажиллагаа эхэлсэн, базлалтын хүч дунд зэрэг, ургийн байддал хэвийн, ирэх үед умайн хүзүү 3см нээлттэй, 4 цагийн дараа умайн хүзүү 4,5 см нээгдсэн байна. Цаашид авах хэмжээг тэмдэглэнэ үү
- А. Кесар хагалгаа
 - В. Окситоцины дэмжлэг
 - С. Үргэлжүүлэн хянах
 - Д. Урагт рН хэмжих
 - Е. Мизопростол 50 мг үтрээнд тавина \С\
61. Эмэгтэй Ц., 22 настай, G_{II-V} 39 долоо хоногтой, умайн базлалт 10 минутанд 3-4 удаа, 40-50 хором үргэлжилнэ. Үтрээнээс цусны хольцтой салиа гарна. Сэжиглэж байгаа оношийг тэмдэглэнэ үү ?
- А. Ихэс түрүүлэлт
 - В. Ихэс ховхролт
 - С. Умайн хүзүү нээгдэх
 - Д. Судасны гэмтэл
 - Е. Умайн хүзүүний урагдал
62. Жирэмсний 28 долоо хоногтойгоос хойш ургийн хөдөлгөөнийг хянах шаардлагатай. Хэдэн цагт 10 хүртэл хөдөлж байвал хэвийн гэж тооцох вэ?
- А. 2 цаг
 - В. 4 цаг
 - С. 6 цаг
 - Д. 10 цаг
 - Е. 12 цаг
63. Ураг орчмын шингэний индекс (УОШИ) хэдээс бага бол багадалт гэж үзэх вэ?
- А. УОШИ ≤ 2 см
 - В. УОШИ ≤ 3 см
 - С. УОШИ ≤ 4 см
 - Д. УОШИ ≤ 5 см
 - Е. УОШИ ≤ 6 см
64. Б.Е.Розенфельдийн тогтоосноор жирэмсний 3 дахь 3 сард ЭХО-оор ургийн толгойн их хөндлөн хэмжээс жирэмсний болон төрөх хугацааг хэдий хугацаагаар алдах магадлалтай вэ?
- А. Алдаагарахгүй
 - В. 5-10 хоног
 - С. 15-20 хоног
 - Д. 1-2 долоо хоног
 - Е. 3-4 долоо хоног

65. Тулгар төрөгчийн умайн хүзүү 8-9 см нээгдсэн байна, Цаашдаа ургийн толгой ямар хурдтай доошлох вэ?
- A. 0,2-0.5 см/цаг
 - B. 1 -1.2 см/цаг
 - C. 1,2 -1,5 см/цаг
 - D. 1,5 - 2.0см/цаг
 - E. 2.0-2.5 см/цаг
66. Дүлэлтийн сулрал гэдэг нь:
- A. Умайн хүзүү бүрэн нээгдээд 30 хормын дотор төрөхгүй байх
 - B. Базлалт сайн боловч умайн хүзүүний нээлт удаашрах
 - C. Умайн хүзүү бүрэн нээгдсэн атлаа дүлэхгүй байх
 - D. Умайн хүзүү бүрэн нээгдсэн боловч ургийн толгой доошлохгүй байх
 - E. Базлалт жигдрээд 8 цаг болоход төрөхгүй байх
67. Жирэмсэн үед өндгөвчний уйланхайн хэмжээ хэдэн см–ээс том бол эрсдэлтэй гэж үзэх вэ?
- A. 3 см
 - B. 5 см
 - C. 10 см
 - D. 15 см
 - E. ≥ 15 см
68. Токолитик эмийг тасралтгүйгээр хэдэн цаг хэрэглэж болох вэ?
- A. 12 цаг
 - B. 24 цаг
 - C. 48 цаг
 - D. 72 цаг
 - E. 36 цаг
69. Жирэмсний үед сулралын даралт ≥ 110 мм.мубө бол даралт бууруулах аль эмийг хэрэглэх нь илүү тохиромжтой вэ?
- A. Нифедипин
 - B. Гидролазин
 - C. Лабетолол
 - D. Фуросемид
 - E. Аспирин 100
70. Манас таталтын урьдал болон манас таталтыг эмчлэх, сонгомол эмийг нэрлэнэ үү?
- A. Диазепам
 - B. Хүхэр хүчлийн магни
 - C. Седуксин
 - D. Хлорпромазин
 - E. Нифедипин

71. Аль тавилт нь ургийн толгой шулуун хэмжээгээр төрнө:
- a. Өврийн янзтай, дагз түрүүлэлт
 - b. Арын янзтай, дагз түрүүлэлт
 - c. Толгойн оройн түрүүлэлт
 - d. Дух түрүүлэлт
 - e. Арын тэнхлэгийн бус тавилт
72. Дутуу төрөлтөнд дараах шалтгаануудаас аль нь хамгийн түгээмэл шалтгаан болох вэ?
- A. Үрэвсэл, халдвар
 - B. Ургийн гаж хөгжил
 - C. Ихэс ховхролт
 - D. Хожуу хордлого
 - E. Хоол тэжээлийн дутмагшил
73. Ихэс түрүүлэлтийн өвөрмөц шинжийг нэрлэнэ үү
- A. Ургийн хүчилтөрөгчийн архаг дутагдал
 - B. Ургийн буруу байрлал
 - C. Үтрээнээс давтан цус гарах
 - D. Архаг цус багадалт
 - E. Дутуу төрөлт
74. Тэмбүүгийн үед ихсэнд гарах өөрчлөлтийг тэмдэглэнэ үү?
- A. Ихэс хавагнана
 - B. Ихэс хатингаршина.
 - C. Ихэст өөрчлөлт үүсэхгүй
 - D. Ихэс зөөлөрч, улбайна.
 - E. Ихэс шохойжино.
75. Жирэмсний төгсгөлд эргэлдэх цусны эзлэхүүн хэдэн хувиар нэмэгдэх вэ?
- A. 10-20
 - B. 30-35
 - C. 40-45
 - D. 50-60
 - E. 60-65
76. Эмэгтэй Э., 36 настай, Gr_{VI-V}, 34 долоо хоногтой, базлалт сул, жигд хэмнэлтэй, үтрээгээр бага зэрэг цус гарна гэсэн өгүүлэмжтэй ирсэн. Үзлэгээр: ураг ташуу байрлалтай, ургийн түрүүлсэн хэсэг харьцангуй дээр байрлалтай, УЗЦ 160 удаа/хором.. Дараах эмгэгийн аль нь байх магадлалтай вэ?
- A. Судасны эмгэг
 - B. Төрөлтийн далд үе
 - C. Ихэс цагаас урьтаж ховхрох
 - D. Ихэс түрүүлэлт
 - E. HELLP хам шинж

77. Эхийн аарцгийн хэмжээ 26-28-30-18-11 байна, Аарцгийн хэлбэрийг тодорхойлно уу?
- A. Жигд уйтарсан аарцаг
 - B. Хөндлөн уйтарсан аарцаг
 - C. Жигд уйтарсан хавтгай аарцаг
 - D. Энгийн хавтгай аарцаг
 - E. Сульдаагийн үеийн хавтгай аарцаг
78. Үтрээний үзлэгээр ургийн суман заадсыг тэмтэрснээр ургийн дараах байдлыг тодорхойлно:
- A. Хөтлөх цэг
 - B. Түрүүлэлт
 - C. Тавигдалт
 - D. Байрлал
 - E. Нуруулалт
79. Өдөрт 1 хайрцаг тамхи татдаг жирэмсэн эмэгтэйд хэт авиан шинжилгээнд юуг илүү анхаарах вэ?
- A. Ураг орчмын шингэний хэмжээнд
 - B. Ургийн хэмжээнд
 - C. Ургийн гаж хөгжил байгаа эсэхэд
 - D. Ургийн хөдөлгөөний идэвхид
 - E. Умайн тонустай байгаа эсэхэд
80. Жирэмсэн эмэгтэйн 2 дахь гурван сард хэрэглэх хоолны илчлэг ямар байх шаардлагатай вэ?
- A. 2500-2700 ккал
 - B. 2800-3000 ккал
 - C. 3000-3200 ккал
 - D. 3200-3500 ккал
 - E. 3500-4000 ккал
81. Жирэмсний хожуу хордлогын үед тромбоцитопени болно. Хэдээ бага бол тромбоцитопени гэж тооцох вэ?
- A. 180000 мм³
 - B. 150000 мм³
 - C. 120000 мм³
 - D. 100000 мм³
 - E. 280000 мм³
82. Ургийн толгой дунд ташуу хэмжээгээр төрөх тохиолдлыг тэмдэглэнэ үү?
- A. Өврийн янзтай дагз түрүүлэлт
 - B. Арын янзтай дагз түрүүлэлт
 - C. Өврийн тэнхлэгийн бус тавилт
 - D. Арын тэнхлэгийн бус тавилт


- Е. Оройн түрүүлэлт
83. Умдагны доод ирмэгээс ууцны төвгөр хүртлэх зайг юу гэж нэрлэдэг вэ?
- А. Эх барихын коньюгат
 - В. Жинхэнэ коньюгат
 - С. Хажуугийн коньюгат
 - Д. Диагональ коньюгат
 - Е. Анатомын коньюгат
84. Жирэмсний 23 долоо хоногтой эхийн шээсний шинжилгээнд: сахар (+), бусад үзүүлэлтүүд хэвийн бол шалтгааныг тайлбарлана уу
- А. Эмэгтэй шижинтэй байна
 - В. Эмэгтэй шээсний замын халдвартай
 - С. Жирэмсний физиологи өөрчлөлт
 - Д. Жирэмсний хожуу хордлоготой
 - Е. Эмэгтэйд бөөрний үрэвсэл
85. Жирэмсэн үед элбэг тохиолддог цус багадлыг нэрлэнэ үү?
- А. Төмөр дутлын цус багадалт
 - В. Цусны эмгэг
 - С. Фолийн хүчлийн дутагдал
 - Д. Ходоод гэдэсний архаг үрэвсэл
 - Е. Цус бүлэгнэлтийн хямралууд
86. Ихэс ховхрох шууд бус шалтгааныг тэмдэглэнэ үү?
- А. Гэмтэл
 - В. Жирэмсний цус багадал
 - С. Жирэмсний хожуу үеийн гестоз
 - Д. Умайн хана хэт сунах
 - Е. Ихэр жирэмслэлт
87. Жирэмсний физиологийн цус багадалт үүсэх шалтгааныг тэмдэглэнэ үү
- А. Төмрийн хэрэгцээ нэмэгдэх
 - В. Цусны задрал
 - С. Ургийн цусны эргэлт нэмэгдэснээс
 - Д. Цусны шингэрлээс
 - Е. Дүрст элемент буурсанаас
88. Цус багадалтгүй жирэмсэн үед хоногт хэдэн мг төмөр хэрэглэх шаардлагатай вэ?
- А. 20-30 мг
 - В. 30-60 мг
 - С. 60-90 мг
 - Д. 90-100 мг
 - Е. 100-200 мг
89. Доорхи байдлуудаас уялдаа холбоогүй тохиолдлыг тэмдэглэнэ үү?
- А. Жирэмсэн үед илэрсэн шинж тэмдэггүй бактериурийг заавал эмчлэнэ.

- В. Пиелонефрит сэдрэх нь дутуу төрөх шалтгаан болдог.
 - С. Жирэмсний эхний хугацаанд шээсэнд шинж тэмдэггүй бактериури илрээгүй бол цаашид шинээр үүсэх магадлал бага.
 - Д. Жирэмслэлт нь шинж тэмдэггүй бактериури үүсэх эрсдлийг нэмэгдүүлнэ.
 - Е. Нийгэм эдийн засгийн хөгжил доогуур жирэмсэн эмэгтэйд шинж тэмдэггүй бактериури илүүтэй тохиолддог.
- 90-91. Эмэгтэй Э., 29 настай, 4200.0 хүү төрүүлээд, их хэмжээтэй цус алдаж, зохих арга хэмжээ авсны дараа цус тогтож даралт тогтворжсон. Дараа өдөр нь цусанд Hb - 7.5 г/л болсон байв.
90. Цаашид энэ эмэгтэйд тохиолдож болох хүндрэлийг тэмдэглэнэ үү?
- А. Гемахроматоз
 - В. Штейн –Леванталийн хам шинж
 - С. Шиханы хам шинж
 - Д. Симондосын хам шинж
 - Е. Кушингийн хам шинж
91. Дээрх эмгэг хамгийн эртдээ ямар хугацаанд илрэх вэ?
- А. Төрсний дараа 6 цагт
 - В. Долоо хоногт
 - С. Төрсний дараа 1-3 сар
 - Д. 6 сарын дараа
 - Е. 1жилийн дараа
92. Хөхөнд сүү орох механизмыг тайлбарлана уу?
- А. Окситоцины дэмжлэгтэйгээр
 - В. Эстроген дааврын нөлөөгөөр
 - С. Өнчин тархинаас пролактин ялгаралт нэмэгдсэнээс
 - Д. Өнчин тархинаас допамины ялгаралт нэмэгдсэнээс
 - Е. ЛТ сэдээгч дааварын ялгаралт нэмэгдсэнээс
93. Төрснөөс хойш 7 хоногийн дараа үтрээнээс цус гараад байна гэж эмчид хандсан байна. Хэвийн үед хэд хоногийн дараа цуслаг шавхарга дуусдаг вэ?
- А. 3-4 хоног
 - В. 5-6 хоног
 - С. 7-9 хоног
 - Д. 10-12 хоног
 - Е. 14 хоног
- 94-95. мэгтэй Ж., 21 настай тулгар төрөгч, 39 долоо хоногтой жирэмсэн, үе үе базалж өвдөнө гэнэ, үтрээгээр үзэхэд долоо хоногийн өмнө үзсэнээс өөрчлөгдөөгүй, ургийн толгой 5/4, шингэн салиархаг ялгадастай байв.
94. Эмэгтэй төрөлтийн ямар үед байна вэ?
- А. Төрөлтөнд бэлтгэгдэх үе
 - В. Дунших үе

- C. Төрөлтийн далд үе
 - D. Төрөлтийн далд үеийн удаашрал
 - E. Хэвийн жирэмсний явц
95. Эмэгтэйд ямар арга хэмжээ авах вэ?
- A. Гэрт нь буцааж өөрийгөө хянахыг зөвлөнө
 - B. Өвдөлт намдаалт хийж хянана
 - C. Мизопростолоор төрөх замыг бэлдэнэ
 - D. Тербуталин хэрэглэнэ
 - E. Умайн хүзүүнд фолийн катетер тавина
96. Эмэгтэй Н., 18 настай, тулгар төрөгч, төрөх үйл ажиллагаа эхлээд 12 цаг болж байна. Ургийн зүрхний цохилт 134 удаа/мин, базлалт хүчтэй, ураг орчмын шингэн гарч, эхийг дүлж эхлэхэд үтрээний үзлэг хийв. Ураг орчмын шингэн гарсан, Хүүхдийн нүүр түрүүлсэн ооч умдагны дор тэмтрэгдэнэ. Төрөлтийг яаж удирдах вэ?
- A. Яаралтай кесар мэс засал хийж төрүүлнэ
 - B. Төрөлтийг төрөх замаар хүлээж төрүүлнэ
 - C. Гадна эргүүлэг хийнэ
 - D. Умайн хүзүү бүрэн нээгдмэгц эх барихын сонгомол эргүүлэг хийж төрүүлнэ
 - E. Төрөх үед гараар нүүр түрүүлэлтийг толгойн орой түрүүлэлт болгож засна
97. Жирэмсний хожуу хугацаанд зулбах гол шалтгааныг нэрлэнэ үү?
- A. Хромсомын гажиг
 - B. Умайн хүзүүний дутмагшил
 - C. Вирусийн халдвар
 - D. Тернерийн хам шинж
 - E. Шижин
98. Амниоцентезтэй хамааралтай зөв мэдээллийг нэрлэнэ үү
- A. Кариотип тодорхойлно
 - B. DNA тодорхойлно
 - C. Энзим тодорхойлно
 - D. Ургийн өсөлтийг тодорхойлно
 - E. Жирэмсний 20-24 долоо хоногтойд хийнэ
99. Жирэмсний хугацааг эхний 3 сард тогтооход хэт авиан шинжилгээ болон сүүлийн биений юмны хоорондох зөрөө ямар байх вэ?
- A. Зөрөөгүй байна
 - B. 3-5 хоног
 - C. 7 хоног
 - D. 2 долоо хоног
 - E. 3 долоо хоног

100. Ихэс төвөөрөө түрүүлэх үед илрэх онцлог шинж?
- A. Үтрээгээр хар хүрэн нөцтэй цус гарна
 - B. Хэвлийгээр өвдөлт илэрнэ
 - C. Жирэмсний 2 дахь гурван сараас эхлэн цус гарах шинж илэрнэ
 - D. Ургийн буруу байрлал тохиолдоно
 - E. Умайн базлалт зогсоно

101. Эмэгтэй С., сүүлийн сарын тэмдгээр, жирэмсний 12 долоо хоногтой, тулгар төрөгч, үтрээнээс цусархаг ялгадас гарна гэсэн зовуурьтай эмчид ханджээ. Үтрээний үзлэгээр умай 4-5 сартай жирэмсний хиртэй том, зөөлөн, умайн хүзүү хурууны үзүүр орох төдий нээлттэй, цусархаг ялгадастай. Харин ЭХО-д ургийн зүрхний цохилт харагдахгүй, дараах зураглал ажиглагдана. Онош тавина уу?



- A. Өсөлтгүй жирэмсэн
 - B. Гематометри
 - C. Умайн хоргүй хавдар
 - D. Цулцан хураа
 - E. Адениомиоз
102. Төрсний дараах цус алдалтын үед хэрэглэгдэхгүй эмийн бэлдмэлийг тэмдэглэнэ үү ?
- A. Метилэргометрин
 - B. Простогландин F2 α
 - C. Тербуталин
 - D. Мизопростол
 - E. Простогландин E2
103. Жирэмсний 37 долоо хоногтойд өвдөлтгүй үтрээнээс цус гарлаа гэж ирсэн бол дараахаас аль арга хэмжээг авах вэ?
- A. Төрөлтийг яаралтай кесар мэс засалаар төрүүлнэ
 - B. Эмнэлэгт хэвтүүлж хэвтрийн дэглэмд байлгана
 - C. Үтрээнд ариун толь тавьж харна
 - D. Цусны бүлэгнэлтийн байдлыг тодорхойлно
 - E. Ургийн бүрхүүл хальсыг хагална
104. Жирэмсний илүү тээлтийг оношлохын тулд эхний ээлжинд:
- A. Хэт авиан шинжилгээ хийнэ
 - B. Жирэмсний хугацааг тодорхойлно

- C. Ургийн зүрхний цохилтыг тоолно
 - D. Стресс сорил тавина
 - E. Ургийн усыг шинжилнэ
105. Мизопростол нь ямар төрлийн бэлдмэл вэ?
- A. Синтетик окситоцин
 - B. Простогландин F2 α
 - C. Простогландин E1
 - D. Простогландин E2
 - E. Ru-486 pill
106. Эмнэл зүйн уйтан аарцгийг илрүүлэх аргад аль нь хамаарах вэ?
- A. Асуумж авах
 - B. Хэт авиан шинжилгээ хийж ургийг урьдчилсан жинг тодорхойлох
 - C. Диагональ коньюгатыг хэмжих
 - D. Жинхэнэ коньюгатыг хэмжих
 - E. Генкель - Вастены шинж
107. Зуршсан зулбалтын үед зайлшгүй хийгдэх шинжилгээг нэрлэнэ үү
- A. Гэр бүлийн хосыг шинжилнэ
 - B. Вирус илрүүлэх шинжилгээ хийнэ
 - C. Ихсийн эдийн бүтцийг шинжилнэ
 - D. Өндгөвчийн үйл ажиллагааг шинжилнэ
 - E. Өвөрмөц шинжилгээ шаардлагагүй
108. Аль нь диаганаль коньюгат вэ ?
- A. Умдагны доод ирмэгээс ууцны төвгөр хүртлэх хэмжээ
 - B. Умдагны гадна ирмэгээс ууцны төвгөр хүртлэх хэмжээ
 - C. Умдагны гадна дээд ирмэгээс ууцны 5-р нугаламын хоорондох зай
 - D. Умдагны дотор доод ирмэгээс Михайлсийн ромбын төв хүртэлх зай
 - E. Умдагны гадна дээд ирмэгээс Михайлсийн ромбын төв хүртэлх зай
109. Ургийн толгой аарцгийн өргөн хэсгийн хавтгайд байхад суман заадас ямар байдалд байх вэ?
- A. Хөндлөн хэмжээнд
 - B. Аль нэгэн ташуу хэмжээнд
 - C. Шулуун хэмжээнд
 - D. Умдагтай ойрхон байна
 - E. Ахар сүүлэнд ойрхон байрлана
110. Өврийн янзтай, дагз түрүүлэлтийн үед ургийн толгой хэмжээгээр төрөх вэ?
- A. Босоо
 - B. Бага ташуу
 - C. Дунд ташуу
 - D. Их ташуу
 - E. Шулуун

111. Жирэмсний эрт үед дараах байдлуудаас аль нь ургийн гаж хөгжил үүсэх эрсдэлийг нэмэгдүүлэх вэ?
- A. Хоногт 15-20 удаа бөөлжих
 - B. Бөөлтийн эсэрг эм бэлдмэл хэрэглэх
 - C. Толгой хүчтэй өвдөх
 - D. Удаан хугацаагаар халуурах
 - E. Биеийн жингээ 10%-иас дээш хэмжээгээр алдах
112. Эмэгтэй А., 24 настай, тулгар төрөгч, жирэмсний 3 сартай эмчид үзүүлэхэд АД 120/80 мм МУБӨ байсан ба давтан үзлэгээр жирэмсний 18 долоо хоногтойд, эхийн артерийн даралт 160/100 мм . МУБӨ, хавангүй шээсний шинжилгээ хэвийн бол оОнош тавина уу?
- A. Жирэмсний даралт ихсэлт
 - B. Жирэмсний хожуу гестозийн хөнгөн хэлбэр
 - C. Жирэмсний хожуу гестозийн хүнд хэлбэр
 - D. Артерийн даралт ихсэх эмгэг
 - E. Жирэмсний хавсарсан хордлого
113. Ихсийн хурц дутагдалд хүргэх шалтгааныг тэмдэглэнэ үү?
- A. Тулгарсан дутуу төрөлт
 - B. Тамхи таталт
 - C. Жирэмсний хожуу үеийн гестоз
 - D. Ихсийн ховхрол
 - E. Мэрэгжлийн хортой нөхцөл
114. Жирэмсний хожуу гестозийн эмгэг жамын эмчилгээг нэрлэнэ үү?
- A. Судасны агчил тавиулах эмчилгээ
 - B. Артерийн даралт буулгах
 - C. Сийвэн нөхөх эмчилгээ
 - D. Хаван хөөх эмчилгээ
 - E. Таталтаас сэргийлэх эмчилгээ
115. Аарцгийн ёроолын дотор давхаргын булчинг тэмдэглэнэ үү?
- A. *M.piriformes*
 - B. *M.ishiococcygeus*
 - C. *M.levator ani*
 - D. *M.ishiocavernosus*
 - E. *M.transversus perinei profundus*
116. Жирэмсэн эмэгтэйн цусанд пролактины хэмжээ хэд хүртэл нэмэгддэг вэ?
- A. 8-25 нг / мл
 - B. 30-45 нг / мл
 - C. 50-70нг / мл
 - D. 75-90 нг / мл нг / мл
 - E. 100 нг / мл

117. Дауны хам шинжтэй хүүхэд төрөх магадлал 35-39 насанд
- A. 1/40-1/45
 - B. 1/50-1/60
 - C. 1/100-1/150
 - D. 1/350-1/400
 - E. 1/500
118. Ургийн хромсомыг шинжлэхэд хамааралгүй аргыг тэмдэглэнэ үү?
- A. Фетоскопи
 - B. Амниоцинтез
 - C. Кордоцинтез
 - D. Цэлмэнгийн биопси авах
 - E. Ургийн эдээс биопси авах
119. Эмэгтэй С., 32 настай, 3 удаа жирэмсэлж, нэг удаа төрсөн. Энэ удаа умайн гаднах жирэмсэн гэж оношлогдоод метотрексат хийлгэсэн. 5 хоногийн дараа хэвлийн доод хэсгээр бага зэрэг өвдөлттэй, даралт судасны цохилт хэвийн, ямар тусламж үзүүлэх вэ?
- A. Яаралтай мэс засал
 - B. Метотрексатын давтан тун тарих
 - C. Үргэлжүүлэн хянах
 - D. Фолийн хүчил уулгах
 - E. Антибиотик эмчилгээ хийнэ
120. Эмэгтэй Н., жирэмсний 39 долоо хоногтой, базалж өвдөнө гэсэн зовуурьтай, амаржих газарт ирсэн, Үзэхэд ургийн байрлал байрлал дагуу, түрүүлсэн хэсэг толгой, аарцгийн орох хэсгийн дээр хөдөлгөөнтэй, УЗЦ 100 удаа/мин. Үтрээний үзлэгээр умайн хүзүү төрөлтөнд бэлтгэлгүй байв. Эхний ээлжинд ямар арга хэмжээ авах вэ?
- A. Эхийн судасны цохилтыг тоолно
 - B. Ургийн рН тодохойлно
 - C. Эхийн судсаар атропин хийнэ
 - D. Яаралтай кесар хагалгаа хийнэ
 - E. Тербуталин хийнэ
121. Ургийн цусны рН хэд бол хүнд хэлбэрийн ацидоз үүссэн гэж тооцох вэ?
- A. <7,10
 - B. 7,20-7,10
 - C. 7,25-7,20
 - D. 7,30-7,25
 - E. 7,35-7,30
122. Өндгөвчийн уйланхай хөл дээр мушгирах, уйланхайн бүрхүүл хагарах хүндрэл, жирэмсний ямар хугацаанд илүү тохиолдох вэ?
- A. 12-24 долоо хоног

- B. 12 долоо хоног дотор
 - C. 24-32 долоо хоног
 - D. 32-36 долоо хоног
 - E. Төрөх үед
123. Окситоциноор төрөлт сэдээхэд, умай хэт их базалвал дараахаас аль эмчилгээг сонгох нь зөв бэ?
- A. Дуслыг зогсоож, сальбутамол
 - B. Дуслыг зогсоож, дротаверин
 - C. Дуслыг зогсоож, баралгин
 - D. Дуслыг зогсоож, дитилин
 - E. Окситоцины тунг багасган, магни сульфат булчинд тарина.
- 124-125. Эмэгтэй У., 40 настай, давтан төрөгч, жирэмсний 30 долоо хоногтой, урьд нь 3500.0 хүү, хэвийн төрүүлсэн. Энэ жирэмсний явцад ямар нэгэн хүндрэл байгаагүй. Тамхи татдаггүй. Жирэмсний хугацаанд биеийн жин 10 кг нэмэгдсэн. А/Д хэвийн. Умайн ёроолын өндөр 25 см байна.
124. Алинаас бусад нь умайн ёроолын өндөр, жирэмсний хугацаатай тохирохгүй бага байх шалтгаан болохыг нэрлэнэ үү?
- A. Ургийн шингэн бага байх
 - B. Умайд лейомиомтой байх
 - C. Ургийн өсөлт баригдах хам шинжийн жигд хэлбэр
 - D. Ургийн өсөлт баригдах хам шинжийн жигд биш хэлбэр
 - E. Ураг хөндлөн байрлалтай байх
125. Аль нь ургийн хөгжил саатах хамшинжийн жигд хэлбэр үүсэх шалтгаанд хамаарахгүй вэ?
- A. Хоол тэжээлийн дутагдал
 - B. Хромосомын гаж хөгжил
 - C. Ургийн дотоод халдвар
 - D. Эрхтэн тогтолцооны эмгэг
 - E. Төрөлхийн гаж хөгжил
126. Дараах шинжилгээнүүдээс хромосомын гажгийг илрүүлэхэд хамааралгүйг нэрлэнэ үү
- A. Амниоцентез
 - B. Хориоцентез
 - C. Ургийн хүйн судасны Допплер
 - D. Кордоцентез
 - E. Даавар шинжилгээ
127. Эмэгтэй Ж., 33 настай, жирэмсэнд аль вирусийн давтан халдвар урагт эрсдэл багатай байдаг вэ?
- A. В бүлгийн Коксакивирус
 - B. Улаануудын вирус

- C. Салхин цэцгийн вирус
 - D. Бүслүүр үлдийн вирус
 - E. Хомхойн вирус 2 –р тип
128. Жирэмсний ямар хугацаанд ХГД даавар хамгийн дээд хэмжээнд хүрдэг вэ?
- A. 5-6 долоо хоногтойд
 - B. 8-10 долоо хоногтойд
 - C. 14-16 долоо хоногтойд
 - D. 26-28 долоо хоногтойд
 - E. 35-36 долоо хоногтойд
129. Кордоцентез – гэдэг нь:
- A. Умайн артериас цус авч шинжлэх
 - B. Үтрээгээр ураг орчмын шингэн авч шинжлэх
 - C. Цэлмэнгийн хорионоос соруулж авч шинжлэх
 - D. Үтрээн арын хүнхрээгээр хатгалт хийж шинжлэх
 - E. Ургийн хүйн судаснаас цус авч шинжлэх
130. Илүү тээлтийн үед тохиолдох хүндрэлүүдийг нэрлэнэ үү
1. Төрөх үйл ажиллагааны хоёрдогч сулрал
 2. Эмнэл зүйн уйтан аарцаг
 3. Ургийн хүчилтөрөгчийн дутмагшил
 4. Төрөх замын зөөлөн эдийн гэмтэл
 5. Ураг орчмын шингэн эрт гарах
131. Ихсийн шилжилт жирэмсний ямар хугацаанд зогсох вэ?
- A. 16-18 долоо хоногтойд
 - B. 20-25 долоо хоногтойд
 - C. 32-35 долоо хоногтойд
 - D. 38 долоо хоногтойд
 - E. 40 долоо хоногтойд
132. Зуршсан зулбалтын үед урьдчилан сэргийлэх эмчилгээг хэзээнээс хийж эхлэх нь зөв бэ?
- A. Аяндаа зулбасны дараа 3 сар өнгөрмөгц
 - B. 6 сарын дараа
 - C. Андаа зулбасны дараа шууд
 - D. Жирэмсэн болохыг төлөвлөж байгаа үед
 - E. Дараагийн жирэмсэн болох хүртэл хугацаанд байнга
133. Хярзангийн урагдлын 3-р зэрэгт хамаарахыг нэрлэнэ үү
- A. Зөвхөн үтрээний хана урагдах
 - B. Хярзан орчмын арьс, үтрээний хананы булчин
 - C. Хярзан орчмын арьс, үтрээний хананы булчин болон шулуун гэдэсний хунигч булчин

- D. Хярзан орчмын арьс, үтрээний хананы булчин, хэлүүний орчим болон шулуун гэдэсний хунигч булчин
- E. Хярзан орчмын арьс, үтрээний хананы булчин болон шулуун гэдэсний хана гэмтэх
134. Ихэр жирэмсний үед, ураг амьгүй болох эрсдэл аль тохиололд илүү вэ?
- A. Дихорион, диамнион
- B. Дихорион, моноамнион
- C. Монохорион, моноамнион
- D. Монохорион, диамнион
- E. Диамнион, монохорион
135. Эмэгтэй Ц., 38 настай, Gr VI-V, 39-40 долоо хоногтой, базлана, үтрээнээс цус гарна гэсэн зовуурьтай. Умайн ёроолын өндөр 36 см, ургийн байрлал ташуу, ургийн түрүүлсэн хэсэг харьцангуй дээр, УЗЦ 1 хоромд 160 удаа байна. Таамаглаж буй оношийг тэмдэглэнэ үү?
- A. Хүй түрүүлэлт
- B. Төрөх үйл ажиллгаа эхэлж байгаа
- C. HELLP хам шинж
- D. Ихэс ховхролт
- E. Ихэс түрүүлэлт E
136. Төрсний дараах цус тогтох хамгийн гол механизмыг тэмдэглэнэ үү?
1. Умайн булчингийн багц агшилт
 2. К амин дэмийн солилцоо идэвхижинэ
 3. Умайн булчингийн завсрын судасууд агших
 4. Умайн судасны даралт буурах
 5. Ихэс байрлаж байсан хэсэгт цусан хангамж буурах
137. Эмэгтэй М., 25 настай, тулгар төрөгч, жирэмсний 38 долоо хоногтой, нойронд муу гэсэн зовуурьтай, хяналтын эмчид ханджээ. Үзлэгээр А/Д 140/100 мм МУБӨ, шээсэнд (+)1 уурагтай, хөлөөр нилээд хавантай байна. Эмэгтэйд ямар арга хэмжээ авах вэ?
- A. Эмнэлэгт хэвтүүлнэ.
- B. Хэвтрийн дэглэмд байхыг зөвлөнө.
- C. Хэт авиан шинжилгээгээр хянана.
- D. Хаван буулгах эм өгч хянана
- E. Нойрны эм зөвлөнө.
138. Ихэс ховхрох шууд бус гол шалтгааныг тэмдэглэнэ үү?
- A. Гэмтэл
- B. Жирэмсний цус багадал
- C. Жирэмсний хожуу үеийн гестоз
- D. Хүй хүзүүгээ ороосон байх
- E. Ихэр жирэмслэлт

139. Эмэгтэй Н., 32 настай, 3 дахь төрөлт, жирэмсний 32 долоо хоногтой. Ургийн жин байх ёстой хэмжээнээс бага, эмэгтэй өдөрт нэг хайрцаг тамхи татдаг. Дараах шинжилгээний алийг нь хийх шаардлагатай вэ?
- A. Эстриол
 - B. Прогестерон
 - C. Пролактин
 - D. Андроген
 - E. ХГ
140. Мэс ажилбарын дараа, ямар зорилгоор умайн хөндийг гараар шалгадаг вэ?
- A. Ихсийн үлдэгдлийг гаргах
 - B. Умайн хананы бүтэн байдлыг шалгах
 - C. Цус алдалтаас урьдчилан сэргийлэх
 - D. Умайн агшилтыг сайжруулах
 - E. Умайн хүзүүний урагдлыг оношлох
141. Альнаас бусад нь умайн урагдлын ангилалд хамаарах вэ?
- A. Урагдлын хэмжээ
 - B. Эмнэл зүйн явц
 - C. Гэмтлийн байдал
 - D. Байрлал
 - E. Алдаж буй цусны хэмжээ
142. Дутуу төрөлт үүсэхэд хамааралгүй шалтгааныг нэрлэнэ үү?
- A. 30-аас дээш насны тулгар төрөгч
 - B. Өдөрт 10-түүнээс олон тамхи татах
 - C. Умайд бүтцийн өөрчлөлт илэрсэн
 - D. 4 ба түүнээс олон төрсөн
 - E. Ихэр жирэмсэн
143. Эмэгтэй С., 24 настай, тулгар төрөгч. Жирэмсний хожуу хордлоготой, цагийн өмнө ураг орчмын зунгагтай гарсан, базлалт 3 хормын зайтай, дунд зэргийн хүчтэй. КТГ-ийн шинжилгээнд базлалт бүрийн дараа хожуу удаашрал илэрнэ. Урагт дараах өөрчлөлтийн аль нь үүсэх вэ?
- A. Ургийн цусанд сүүн хүчлийн агууламж багасна.
 - B. Хүчилшилт үүсснэ
 - C. Нүүрсхүчлийн хэмжээ нэмэгдэнэ,
 - D. Цусанд бикорбанатын хэмжээ буурна,
 - E. Урагт шүлтшилт үүснэ
144. Хорионбиопсийн шинжилгээг жирэмсний хэдэн долоо хоногтойд хийх вэ ?
- A. 9-11
 - B. 11-13
 - C. 13-15
 - D. 15-16

Е. 16-22 А

145. Дауны хам шинжийн үед жирэмсэний 18-22 долоо хоногтойд ХГД хэд дахин ихсэх вэ ?
- А. 0,5-аас 1 дахин
 - В. 1-2 дахин
 - С. 2-3 дахин
 - Д. 3-4 дахин
 - Е. 5-6 дахин
146. Үр хэврөлийн гаднах эрхтэнд аль нь хамааралгүй вэ?
- А. Хорион
 - В. Умай
 - С. Шар хүүдий
 - Д. Аллантаис
 - Е. Ургийн бүрхүүл хальс
147. Үр хэврөлийн үе хэзээ дуусдаг болохыг тэмдэглэнэ үү?
- А. Жирэмсний эхний сарын төгсгөлд
 - В. Жирэмсний хоёр сар хагаст
 - С. Жирэмсний 3 сарын эхэнд
 - Д. Жирэмсний 3 сарын төгсгөлд
 - Е. Жирэмсний 4 сарын эхэнд
148. Умайн доод сегмент жирэмсний хэдэн сартайгаас үүсдэг болохыг тэмдэглэнэ үү?
- А. 16 долоо хоногтойгоос
 - В. 18 долоо хоногтойгоос
 - С. 20 хоногтойгоос
 - Д. 22 хоногтойгоос
 - Е. 24 хоногтойгоос
149. Жирэмсэн эмэгтэйн нэг удаагийн цусны шинжилгээнд сахарын хэмжээ нэмэгдсэн бол ямар арга хэмжээ авах вэ?
- А. Өдөрт 2000 ккал илчлэгтэй хоол, хүнс хэрэглэхийг зөвлөнө
 - В. Ачаалалтай сорил хийнэ.
 - С. Шээсэнд сахар тодорхойлно.
 - Д. Хоол идснээс хойш 2 цагийн дараа цусанд сахар тодорхойлох
 - Е. Биеийн жингийн нэмэгдэлтэнд хяналт тавина.
150. Дауны хам шинжийг илрүүлэхэд шилэн хүзүүний арын тунгалгийн зайг тодорхойлох нь биохимийн шинжилгээ хийхээс юугаараа давуутай болохыг нэрлэнэ үү?
- А. Үтрээний мэдрүүлээр тодорхойлно
 - В. Олон дахин үзэж шинжлэх хянах боломжтой
 - С. Ихэр жирэмсэн үед илүү ач холбогдолтой

- D. Жирэмсний хугацаа хамаарахгүй
E. Үйлчлүүлэгчдэд тохитой таатай
151. Эрт үеийн амниоцинтэз нь, хорион биопсийн шинжилгээнээс юугаараа давуу болохыг нэрлэнэ үү
- A. Жирэмсний эрт хугацаанд хийгддэг
 - B. Өвдөлтгүй байдаг
 - C. Жирэмсний 2 дахь гурван сард зулбах эрсдэл багатай
 - D. Хорион биопси нь дунд 3 сард илүү эрсдэлтэй
 - E. Хорион биопси жирэмсний эрт хугацаанд илүү эрсдэлтэй
152. Эмэгтэй В., жирэмсний 18 долоо хоногтой, гэнэт баруун цавь орчим хүчтэй хатгуулж өвдөнө, хөдлөхөд илүү хүчтэй өвдөнө гэсэн зовуурьтай ирсэн. Шинжилгээнд өөрчлөлтгүй. Өвдөлт юутай холбоотой байж болох вэ?
- A. Дугуй холбоосын өвдөлт
 - B. Мухар олгойн үрэвсэл
 - C. Дутуу төрөхийг завдсан
 - D. Бөөрний чулуу
 - E. Шээсний өгсөх замын халдвар
153. Дараах эмгэгүүдээс аль ихсийн дутмагшилд хүргэх вэ?
- 1. Жирэмсний хожуу гестоз
 - 2. Бөөрний эмгэг
 - 3. АД ихсэх эмгэг
 - 4. Жирэмсэн үеийн цус багадалт
 - 5. Таргалалт
154. Шээсний дүрст элементүүдийг тодорхойлох шинжилгээний аргыг нэрлэнэ үү?
- 1. Ничефоренко-ийн аргаар шинжлэх
 - 2. Каковского-Аддиса -ын аргаар шинжлэх
 - 3. Амбурже-ийн аргаар шинэжлэх
 - 4. Шээсний ерөнхий шинжилгээ
 - 5. Шээсний бактериологи шинжилгээ
155. Дараахаас аль нь ихсийн хоригийг давж чадахгүй вэ?.
- A. Гентамицин
 - B. Глюкоз
 - C. Седуксин
 - D. Гепарин
 - E. Окситоцин
156. Жирэмслэлт бамбайн хордлогот бахтай хавсарсан үед ямар хүндрэл элбэг тохиолдох вэ?
- A. Дутуу төрөлт
 - B. Хордлогот бах хурцдах
 - C. Жирэмсний тасралтгүй бөөлжилт

- D. Хожуу гестоз
 - E. Төрөлт удаашрах
157. Өмнө нь дутуу төрж байсан эмэгтэйд, дахин дутуу төрөхөөс урьдчилан сэргийлж дараах эмчилгээнээс алийг нь хийх вэ?
- A. Жирэмсний 32 долоо хоног хүртэл токолитик бага тунгаар хэрэглэнэ.
 - B. Дутуу төрөхийг давдаж байгаа үед Магне В6 жирэмсний туршид хэрэглэнэ.
 - C. Зовуурьгүй бол хяналт тавьж ажиглана.
 - D. Жирэмсний 37 долоо хоногоос өмнө 17 α гидроксипрогестерон 250 мг – аар, булчинд, 7 хоног тутамд тарина.
 - E. Умай тонустай үед, 17 α гидроксипрогестерон өдөрт 1 удаа, 7 хоног хэрэглэнэ.
158. Ямар байдлыг ургийн толгой тавигдсан гэж үзэх вэ?
- A. Ургийн толгой аарцгийн хөндийд байрласан
 - B. Түрүүлсэн хэсэг суудал ясны түвшинд байрласан
 - C. Ургийн толгойн их хөндлөн хэмжээ бага аарцгийн орох хэсэгт байрласан
 - D. Суман заадас хөндлөн хэмжээнд байрласан бол
 - E. Ургийн толгой бөхийсөн бол
159. Эх барихын цус алдалтын үед хэрэглэх уян зүүний хэмжээг сонгоно уу?
- A. 16G
 - B. 18G
 - C. 20G
 - D. 21G
 - E. 22G
160. Альнаас бусад нь судасны дотор ханыг гэмтээгч хүчин зүйлд хамаарах вэ?
- A. Хавдар үжлийн хүчин зүйл/TNF /
 - B. Цитокин IL1,6,8
 - C. Простоциклин
 - D. Лейкотриенууд
 - E. Ялтас эсийг идэвхижүүлэгч/PAF/
161. Партограммд ургийн толгойн тавилтыг “-2” гэж тэмдэглэсэн байна. Энэ нь ургийн толгой хаана байгааг илэрхийлж байна вэ?
- A. Орох хэсгээс 1/3 доошилсон
 - B. Орох хэсгээс 2/3 доошилсон
 - C. Аарцгийн хөндий
 - D. Хөндийн шугамнаас 1/3 доошилсон
 - E. Толгой хязсанд тулсан
162. Цус багадаалттай жирэмсэнд төмөрийн бэлдмэлийг эмчилгээний тунгаар ууж байгаа үед хэд хоногийн дараа сийвэнгийн ферритин хэвийн болох вэ?
- A. 7 хоногийн дараа

- B. 10 хоногийн дараа
- C. 5 хоногийн дараа
- D. 21 хоногийн дараа
- E. 2-3 долоо хоногийн дараа

163. Магни сульфатын цохилтын тунг заана уу?

- A. 4,0 хуурай бодис
- B. 8,0 гр хуурай бодис
- C. 10,0 хуурай бодис
- D. 12,0 хуурай бодис
- E. 14,0 хуурай бодис

164. Магни сульфатын тун хэтэрсэн үед ямар эмийн бодисыг тарих вэ?

- A. Димедрол
- B. 0.9%-200 мл натри хлоридын уусмал
- C. 7.4%-100 мл кали хлорид
- D. 10%-10 мл кальци глюконат
- E. Дексаметазон

165. Жирэмсний хугацаа 34 долоо хоногтой. Толгой өвдөж шилэн хүзүүгээр хөшнө, нүдний уг руу хатгана, хавагнана гэсэн зовиуртай эмнэлэгт ирж үзүүлэхэд үзлэгт цусны даралт баруун гарт 170/110, зүүн гарт 160/110; судасны цохилт 1 минутанд 86 удаа, шилбэ хавантай байв. Гидралазиныг судсаар ямар тунгаар хийх вэ?

- A. 5 мг
- B. 10мг
- C. 12,5 мг
- D. 15 мг
- E. 20 мг

166. Төрөгч 32 настай, жирэмсний 38-39 долоо хоногтой, 2 дахь төрөлт. 22.00 цагт эмнэлэгт ирэхэд умайн базлалт 10 минутад 2 удаа 20 секунд, гадуур үзлэгээр ургийн толгой 5/5 тэмтрэгдэнэ, УЗЦ 130 удаа/мин тод жигд сонсогдоно, умайн хүзүүний нээлт 4 см, ургийн шингэн бүтэн байв. 4 цагийн дараа 02.00 цагт үзэхэд умайн базлалт 10 минутад 2 удаа 25 секунд үргэлжилж, гадуур үзлэгээр ургийн толгойг тэмтрэхэд 5/5, УЗЦ 130/мин удаа тод жигд, умайн хүзүүний нээлт 6 см, ургийн шингэн бүтэн байлаа.

167. Төрөлтийн ямар эмгэг байж болох вэ?

- A. Төрөлтийн I үе, идэвхтэй шат
- B. Төрөлтийн саатал
- C. Толгой аарцгийн үл тохироо
- D. Төрөлтийн идэвхитэй үеийн сулрал
- E. Төрөлтийн I үе, далд шатны удаашрал

168. Энэ тохиолдолд ямар арга хэмжээ авбал зохих вэ?

- A. Дахин 4 цаг базлалт эрчимжихийг хүлээнэ

- B. Эхийг унтуулж амраана
 - C. Окситоцинд мэдрэг байдлыг үзэж судсаар дусааж эхэлнэ
 - D. Мэс заслаар төрүүлнэ
 - E. Мизопростол хэрэглэнэ
169. Төрөгч эмэгтэйн умайн хүзүү бүрэн нээгдсэн боловч толгой бага аарцгийн орох хэсгийн дээр тэмтрэгдэнэ. Базлалт 10 минутанд 4 удаа, 35-40 сек үргэлжилж байгаа тохиолдолд төрөлтийн ямар эмгэг байж болох вэ?
- A. Төрөх хүчний II сулрал
 - B. Төрөлтийн II үе
 - C. Төрөлтийн саатал
 - D. Төрөх үйл ажиллагааны хэт эрчимжилт
 - E. Төрөх хүчний I сулрал
170. Төрөөд 1 цагийн дараа умайд иллэгээр нөжтэй цус нэлээд хэмжээтэй гарлаа. Үзлэгт цусны даралт 90/70, 90/60; судасны цохилт 92 удаа, нийт алдсан цусыг хэмжихэд 1000 мл байлаа. Дайрлагын индексийг яаж тооцоолох вэ?
- A. Судасны цохилтын тоог сулралын даралтанд харьцуулна
 - B. Судасны цохилтын тоог агшилтын даралтанд харьцуулна
 - C. Судасны цохилтын тоог дундаж даралтанд харьцуулна
 - D. Агшилтын даралтыг судасны цохилтын тоонд харьцуулна
 - E. Сулралын даралтыг судасны цохилтын тоонд харьцуулна
171. Хэдээс дээш бол дайрлагын индексийг хэвийн биш гэж үзэх вэ?
- A. 1
 - B. 1.5
 - C. 0.5
 - D. 1-2
 - E. 2
172. Төрөөд 5 хоносэн эх 38.5 хүрч халуурсан, умайн ёроол хүйснээс 3 хуруу доош тэмтрэгдэнэ, шавхарга ягаан, үнэртэй байлаа. Та ямар эмгэгийг таамаглах вэ?
- A. Давсагны үрэвсэл
 - B. Үжил халдвар
 - C. Бөөрний тэвшинцрийн үрэвсэл
 - D. Умайн салстын үрэвсэл
 - E. Мастит
173. Зүрх судасны эмгэгтэй төрсөн эхийг хэдэн цагийн турш хэвтрийн дэглэмд байлгах вэ?
- A. 24 цаг
 - B. 72 цаг
 - C. 12 цаг
 - D. 48 цаг
 - E. 24 цаг

174. Жирэмсний эрт хугацаанд ургийн ДНК–г шинжилгээг ямар аргаар авах вэ?
- A. Фетоскопи
 - B. Амниоцентез
 - C. Кордоцентез
 - D. Цэлмэнгийн биопси
 - E. Ургийн эдээс биопси
175. Дараахаас аль нь умай урагдах эрсдэлтэй вэ?
- A. Аденомиоз
 - B. Диэтилэстриолын нөлөө
 - C. Умайн хүзүүний хортой хавдар
 - D. Фиброма
 - E. Эндометриома
176. Эмэгтэй 35 настай 2 дахь жирэмсэн, 8 долоо хоногтой, өмнө нь 4000,0 хүүхэд төрүүлсэн ураг орчмын шингэний ихдэлтэй. Дараах шинжилгээндээс алийг нь хийх шаардлагтай вэ?
- A. Гурвал сорил
 - B. АФП
 - C. Глюкозын ачаалалтай сорил
 - D. Генетик амниоцентез
 - E. ЭХО
177. Аль эмгэг нь илүү тээлт үүсгэхэд хамааралтай вэ?
- A. Менингомиелоцеле
 - B. Нугасны эвэрхий
 - C. Тархигүй ураг
 - D. Омфалоцеле
 - E. Тернейн хам шинж
178. Умайн гаднах жирэмслэлтийг оношлоход сийвэнд ХГД –ыг хэдий хугацааны дараа давтан тодорхойлох вэ?
- A. 12-24 цагийн дараа
 - B. 24-36 цагийн дараа
 - C. 48-72 цагийн дараа
 - D. 72-108 цагийн дараа
 - E. 7 хоногийн дараа
179. Мизопростол нь ямар төрлийн бэлдмэл вэ?
- A. Синтетик окситоцин
 - B. Простогландин F2 α
 - C. Простогландин E1
 - D. Простогландин E2
 - E. Ru-486 pill
180. Хорион биопсийн шинжилгээг жирэмсний хэдэн долоо хоногтойд хийх вэ ?

- A. 9-11
- B. 11-13
- C. 13-15
- D. 15-16
- E. 16-22

181. Аль нь одоо дутуу төрөх эрсдэл байгааг илэрхийлэх вэ?

- A. Ургийн фибронектин илэрсэн
- B. Өмнө нь дутуу төрж байсан өгүүлэмжтэй
- C. Умайн хүзүүний урт <25 мм байх
- D. Ахимаг насны тулгар төрөгч
- E. Эрхтэн тогтолцооны эмгэгтэй байх

182. Төрөлтийн 1-р үеийн идэвхитэй шатанд умайн дотоод даралт хэдэн мубө байх вэ?

- A. 20-30 мм. МУБӨ
- B. 35-50 мм. МУБӨ
- C. 50-70 мм. МУБӨ
- D. 80-100 мм. МУБӨ
- E. 100-150 мм. МУБӨ

183. Ургийн биофизикийн үзүүлэлтийг тодорхойлоход ургийн хөдөлгөөн хэд бол 2 оноо өгөх вэ?

- A. 5 хоромд 1 удаа хөдлөх
- B. 10 хоромд 1 удаа хөдөлж байвал
- C. 20 хоромд 1-2 удаа
- D. 30 хоромд 3- аас дээш удаа
- E. 30 хоромд 6- аас дээш удаа

184. Прогестин нь урагт ямар гаж хөгжил үүсгэх эрсдэлтэй вэ?

- A. Хондрадисплази
- B. Мэдрэлийн тогтолцооны гажиг
- C. Хуруугүй төрөх
- D. Гипоспади
- E. Сэтэрхий уруул

185. Дараахаас аль нь жирэмсний 16 долоо хоногоос өмнө урагт халдвар дамжих эрсдэл багатай вэ?

- A. Цитомигаловирус
- B. Токсоплазмоз
- C. Бүслүүр үлд
- D. Тэмбүү
- E. Улаанууд

186. Хадуур эс цус багадалтын оношилгоонд даараахаас аль нь илүү мэдээлэл сайтай вэ?

- A. Цусанд АФП тодорхойлно
 - B. Хорионбиопси
 - C. Эхийн хромосомыг шинжлэх
 - D. Амниоцентез
 - E. Тодорхой цаг хугацаанд хэт авиан шинжилгээ хийнэ
187. Сийвэнд чөлөөт эстриол буурахад хамааралгүй эмгэгийг нэрлэнэ үү ?
- A. Резүс сөрөг цустай байх
 - B. Преэклампси
 - C. Ургийн өсөлт аарах
 - D. Эхийн бөөрний эмгэг
 - E. Жирэмсэн хамааралт даралт исэлт
188. Доорхи хүндрэлүүдээс үед ийн аль нь үтрээний нянгийн вагинозод хамааралгүй болохыг нэрлэнэ үү
- A. Дутуу төрөлт
 - B. Хорионамнионит
 - C. Төрсний дараах эндометрит
 - D. Эндометриоз
 - E. Үргүйдэл
189. Эмэгтэй Ц., 22 настай, G_{II}-I 39 долоо хоногтой, умайн базлалт 10 минутанд 3-4 удаа, 40-50 хором үргэлжилнэ. Үтрээнээс цусны хольцтой салиа гарна. Юу байж болох вэ?
- A. Ихэс түрүүлэлт
 - B. Ихэс ховхролт
 - C. Умайн хүзүү нээгдэх
 - D. Судасны гэмтэл
 - E. Умайн хүзүүний урагдал
190. Дауны хам шинжтэй бол жирэмсэний 18-22 долоо хоногтойд ХГД хэд дахин ихсэх вэ ?
- A. 0,5-аас 1 дахин
 - B. 1-2 дахин
 - C. 2-3 дахин
 - D. 3-4 дахин
 - E. 5-6 дахин
191. Шар биеийн дааврын үндсэн зохицуулагчийг нэрлэнэ үү?
- A. Пролактин
 - B. ИТӨФ
 - C. ФСД
 - D. Ингибин
 - E. ЛД

192. Дутуу төрөлтийн үед ихсийн дараах өөрчлөлтүүдээс хамгийн түгээмэл тохиолдохыг нэрлэ?
- A. Хурц хориоамнионит
 - B. Цэлмэнгийн архаг үрэвсэл
 - C. Судасжилтийн эмгэг
 - D. Цэлмэнгийн хаван
 - E. Холимог
193. Эмэгтэй 47 настай, IVF эмчилгээний тусламжтайгаар жирэмсэлсэн. Хэт авиан шинжилгээнд 7 долоо хоногтой 3 ихэр ураг оношлогдсон. Түүний нэг ургийн хүзүүний арын тунгалаг зай 5 мм хэмжигдсэн. Дараах эмгэгийн аль нь тохиолдох магадлал ихтэй вэ?
- A. Мэдрэлийн гуурсны гажиг
 - B. Урагт зүрхний гажиг
 - C. Ургийн хүзүүний арын тунгалаг зай тээлтийн 20 долоо хоног хүртэл их байж болно
 - D. Бусад урагт ургийн хүзүүний арын тунгалаг зай үзэж хромосомын гажиг үүсэх эрсдлийг харьцуулна
 - E. Урагт Тернер хам шинж үүссэн байх магадлал өндөр
194. Дараахаас ахондроплази өвчний онцлогийг аль нь илтгэж байна вэ?
- A. Аутоссом рецессив байдлаар удамшдаг
 - B. Нийт тохиолдлуудаас 50%-ийн шинэ мутаци эзэлж байна.
 - C. Кесар хагалгаа цөөхөн тохиолддог
 - D. Өвчтэй бол нөхөн үржихүйн нас хүртлээ амьдрах нь ховор
 - E. Нурууны гажиг нь хүйн дарагдалд нөлөөлдөг
195. Жирэмсний 3 дах гурван сард 13-р хромосомд транслокаци болсон бол хромосомын кариотип хэвийн байх магадлал хэдэн хувь вэ?
- A. 2%
 - B. 10%
 - C. 25%
 - D. 50%
 - E. 100%
196. Э., 24 настай, жирэмсний 17 долоо хоногтой. Цусны сийвэнд АФП-ны түвшин 6.0 MOM бол дараагийн шатанд эхлээд авах авах арга хэмжээг нэрлэнэ үү?
- A. АФП-ыг давтан хэмжих
 - B. Хэт авиан шинжилгээ
 - C. Амниоцентез
 - D. Амниографи
 - E. Жирэмснийг таслахыг зөвлөнө

197. Д., 41 настай, 10 жилийн өмнө Даунтай хүүхэд төрүүлсэн. Тэрээр одоо тээж буй хүүхдийнхээ хромосомын кариотипыг тодорхойлж мэдэхээр ирсэн. Доорх хариултаас аль нь кариотипийг хурдан тодорхойлох боломжтой вэ?
- A. Амниоцентез
 - B. Кордоцентез
 - C. Хорионы цэлмэнгийн шинжилгээ (CVS)
 - D. Хэтавиан Допплер шинжилгээ
 - E. Уйланхайт гигромыг соруулах
198. Л., 39 настай, жирэмсний эхний хагасын пренатал оношлогоонд хамрагдахаар ирсэн. Амниоцентез эрт үед хийх нь хорионы цэлмэнгийн шинжилгээнээс юугаар давуу вэ?
- A. Амниоцентезийг жирэмсний эрт хугацаанд хийдэг
 - B. Амниоцентезийн шинжилгээ өвдөлт багатай
 - C. Хоёрдугаар хагасын оношлогоо нь өвчтөн жирэмслэлтийг таслуулахаар шийдсэн тохиолдолд жирэмслэлтийг аюулгүй төгсгөх боломжтой болгоно.
 - D. Хорионы цэлмэнгийн шинжилгээ нь жирэмсний хоёрдугаар хагасын амниоцентезийн шинжилгээтэй харьцуулахад хүндрэл их тохиолддог
 - E. Хорионы цэлмэнгийн шинжилгээ нь амниоцентезтэй харьцуулахад хүндрэл ихтэй
199. Доорхи вакцинуудаас алийг нь жирэмсэн эмэгтэйд хийж болохгүй вэ?
- A. Галзуу
 - B. Татран
 - C. Балнад
 - D. Гепатит В
 - E. Улаан бурхан
200. Дараахаас эмүүдээс алийг нь удаан хэрэглэхэд төрөлхийн микроцефали, зүрхний гажиг, өсөлтийн удаашрал зэрэг олон өвчин хавсарсан гажигтай хүүхэд төрөх эрсдэлтэй вэ ?
- A. Хлорамфеникол
 - B. Барбитурат
 - C. Мансууруулах бодис
 - D. Метадон
 - E. Этилийн спирт
201. Хүй ихсийн хальсанд бэхлэгдэх нь ямар эрсдлийг нэмэгдүүлэх вэ?
- A. Ургийн бүрхүүл хальс урьтаж хагарах
 - B. Ураг төрөхөөс өмнө цусгүй болох
 - C. Хүйн гогцоо мушгирах
 - D. Ургийн хөгжлийн гажиг
 - E. Умайн бүтцийн эмгэг

202. 42 настай анхны жирэмсэн, 34 долоо хоногтойдоо хяналтын эмч дээр ирсэн. Тэр сүүлийн үед хэвлийн арьсан дээр одлог тууралт ихээр гарах болсон нь түүний санааг зовоож байгаа. Энэ талаар зөвөлгөө авахаар эмчид ирсэн Та юу гэж зөвлөх вэ?
- A. Энэ нь аюултай өвчин биш гэхдээ судасны эмч дээр очиж мэс заслын аргаар авхуулж болно
 - B. Түүнд элэгний хүнд өвчтэй байж болох талаар хэлж элэгний үйл ажиллагааны сорил хийлгэх талаар зөвлөнө
 - C. Арьсны эмчид үзүүлж шинжилгээ өгөх талаар хэлнэ
 - D. Энэ нь жирэмсэнтэй холбоотой хэвийн үзэгдэл төрсний дараа өөрөө аяндаа арилна гэж тайлбарлана
 - E. Судас хагарсанаас үүсэх тул хэвлийн даралты бууруулахын тулд даруулга хэрэглэх
203. 32 настай, 20 долоо хоногтой жирэмсэн яаралтай тусламжийн тасагт 24 цагийн өмнөөс хэвлийгээр хүчтэй өвдөнө, дотор муухай оргиж бөөлжинө гэсэн зовууртай ирсэн. Сүүлийн жирэмсэн өгзөг түрүүлэлт гэсэн оношоор кесар мэс заслаар төрсөн. Өмнөх орой нь хэт халуун ногоотой хурц хоол идсэн. Эх барихын ямар нэгэн хүндрэл байгаагүй. Үзлэгээр биеийн халуун $37,7^{\circ}$, А/Д, судасны цохилт хэвийн. Хэвлийгээр бага зэрэг эмзэглэлтэй, гэдэсний хөдөлгөөн багассан. Гүнзгий тэмтрэлтээр булчингийн чангаралгүй. Цаган эс 13,000, эрсдсийн хэмжээ хэвийн. Энэ өвчтөнд ямар арга хэмжээ авах вэ?
- A. Асуумж бодит үзлэгээс үзэхэд жирэмсэн үед түгээмэл тохиолдох өтгөн хаталтын шинжтэй байгаа учир бүхэл үрийн хоол идэхийг зөвлөнө, клизм тавина
 - B. Мухайр олгойн үрэвсэл үрэвсэл тул яаралтай мэс засалд орно
 - C. Өмнөх орой идсэн хурц хоолтой холбоотой учир ходоодны үрэвсэл дарах эм уулгана
 - D. Хэвлийн рентген шинжилгээ хийлгэнэ
 - E. Жирэмсний хэт бөөлжилт гэж үзэн судсаар бөөлжилтийн эсрэг эмчилгээ хийнэ
204. А., 37 настай, G3,P2, одоо 10 долоо хоногтой эмчид ирсэн. Тэр Грейвсийн өвчтэй, бамбайн хордлогын эмчилгээнд пропилтиоурацил эмчилгээ хийлгэж байсан. Одоогоор дааврын хэмжээ хэвийн байгаа, жирэмслэхэд тохиолдож болох хүндрэлийн талаар санаа зовж байна. Эмэгтэйд өгөх зөвөлгөө аль нь зөв бэ ?
- A. Лейкопени болох учир эмээ уухаа зогсоох хэрэгтэй
 - B. Пропилтиоурацил хэрэглэсэн үед дааврын хэмжээ хэвийн эхэс төрсөн нярай бамбайн томролтой, эмнэл зүйн хувьд бамбайн дутагдалтай төрж болно
 - C. Пропилтиоурацил ихсээр нэвтрэхгүй

- D. Бамбайн хордлоготой эмэгтэйд тохирсон эмчилгээ хийсэн ч хожуу хордлого үүсэх эрсдэл нэмэгддэг
- E. Грейвсийн өвчтэй жирэмсэн эмэгтэйд эмчилгээ хийсэн ч бамбайн дайрлага илүүтэй тохиолдоно
- 205-206.Т., 32 настай, анхны жирэмсэн, 14 долоо хоногтой хяналтанд орсон, 4 долоо хоногийн өмнө өгсөн шинжилгээнд ялтас эс 60,000, бусад үзүүлэлтүүд хэвийн. Энэ удаад үзлэгээр АД 120/70 мм МУБӨ, шээсэнд бага зэрэг уурагтай, ямар нэгэн зовуургүй. Зөвхөн пренатал витамин ууж байгаа. Асуумжаас жирэмслэхээс өмнө хааяа буйл болон хамраас бага зэрэг цус гарамтгай, арьс нь амархан хөхөрдөг гэжээ
205. Эмэгтэйд ямар онош тавих боломжтой вэ?
- A. Аллоиммуны тромбоцитопени
 - B. Жирэмсний тромбоцитопени
 - C. Иммуны тромбоцитопенический пурпуры
 - D. HELLP хам шинж
 - E. Жирэмсний даралт ихсэлт
206. Ялтас эсийн цөөрлийн үед ямар эмчилгээ хийх вэ?
- A. Эмчилгээ шаардлагагүй
 - B. Пренатал витаминьг зогсооно
 - C. Кортикостеройд уулгана
 - D. Судсаар иммуноглобулин тарина
 - E. Дэлүү авна
207. Умайн хүзүүг төрөлтөнд бэлтгэх зорилгоор простогландин E2-ыг ямар аргаар хэрэглэх вэ?
- A. Судсаар
 - B. Үтрээнд
 - C. Булчинд тарьж
 - D. Хэлэн доор шимж
 - E. Шулуун гэдсээр
208. Эпидурал мэдээ алдуулалт төрөлтийн идэвхитэй үеийг хэдэн хормоор удаашруулах вэ?
- A. 30 хором
 - B. 60 хором
 - C. 90 хором
 - D. 120 хором
 - E. 180 хором
209. Ургийн шингэний бүрхүүлийг хөндийрүүлэх ажилбарын үед үүсэх өөрчлөлтийг нэрлэнэ үү
- A. Хорионамнионит
 - B. Түргэн төрөлт

- C. Эмэгтэйд таагүй байдал үүсгэх
 - D. Ургийн шингэний бүрхүүл урьдаж хагарах
 - E. Өгсөх замын халдвар
210. Умай хүзүү зөөлрөх үйл явц жирэмсний хэдий хугацаанаас эхэлдэг вэ?
- A. Жирэмсний эхний 3 сараас
 - B. Жирэмсний 20 долоо хоногтойгоос
 - C. Жирэмсний 28 долоо хоногтойгоос
 - D. Жирэмсний 32 долоо хоногтойгоос
 - E. Жирэмсний 36 долоо хоногтойгоос
211. Төрсний дараах сэтгэл гутралтай холбоотой үнэн мэдээлэлийг нэрлэнэ үү
- A. Өмнөх өгүүлэмжтэй байх нь эрсдэлт хүчин зүйл биш
 - B. Төрөлт тойрны урьдчилан сэргийлэлтэнд сэтгэцийн эмчийн хяналт чухал ач холбогдолтой
 - C. Залуу, олон төрсөн эмэгтэйчүүд илүү эрсдэл өндөртэй
 - D. Өөрөө аяндаа арилах ба дээд тал нь 3 сар үргэлжилнэ
 - E. Ойролцоогоор 10-12%-д тохиолдоно
212. А., 37 настай, жирэмслэлт 3, төрөлт 2. Одоогийн жирэмслэлт 10 долоо хоногтой. Тэрээр Грейвсийн өвчтэй, пропилтиоурацил хийлгэж байгаа. Одоогоор дааврын хэмжээ хэвийн, жирэмсэн үед тохиолдож болох хүндрэлийн талаар санаа зовж байна. Эмэгтэйд өгөх зөвөлгөө аль нь зөв бэ ?
- A. Лейкопени болох учир эмээ уухаа зогсоох хэрэгтэй
 - B. Пропилтиоурацил хэрэглэсэн үед нярай бамбайн дутагдалтай төрж болно
 - C. Пропилтиоурацил нь ихсээр нэвтрэхгүй
 - D. Бамбайн хордлогын үед эмчилгээ хийсэн ч хожуу хордлого үүсэх эрсдэл нэмэгддэг
 - E. Грейвсийн өвчтэй жирэмсэн эмэгтэйд эмчилгээ хийсэн ч бамбайн дайрлага илүүтэй тохиолдоно
213. Прогестин хэрэглэхэд ургийн ямар гаж хөгжил үүсэх эрсдэлтэй вэ?
- A. Хондрадисплази
 - B. Мэдрэлийн тогтолцооны гажиг
 - C. Хуруугүй төрөх
 - D. Гипоспади
 - E. Сэтэрхий уруул
214. Хэт авиан Допплер шинжилгээнд сулралын төгсгөл байхгүй эсвэл урвуу байх нь перинаталь эндэгдэлд хүргэх хувь?
- A. 5-8%
 - B. 10-20%
 - C. 20-25%
 - D. 25-30%
 - E. 30-35%

215. Хэт авиан Допплер шинжилгээнд эсэргүүцлийн индекс >0.6 байх нь урагт ямар нөлөөтэй вэ?
- A. Хэвийн үзүүлэлт
 - B. Урагт архаг бүтэлт байгааг илэрхийлнэ
 - C. Ургийн тавилан муу байгааг илтгэнэ
 - D. Ургийн жин бага байгааг илтгэнэ
 - E. Урагт цус багадалт байгааг илэрийлнэ
216. Т., 18 настай, 15 долоо хоногтой жирэмсэн, шээсний бактериологи шинжилгээнд бактериури илэрсэн. Дараах мэдээлэлүүдийн зөвийг тэмдэглэнэ үү?
- A. Жирэмсэн эмэгтэйчүүдэд 30% хүртэл тохиолдоно
 - B. Давтан төрөчдөд илүү тохиолдоно
 - C. Эмчилгээний дараа 15%-д шээсний замын халдвар сэдрэх эрсдэлтэй
 - D. Бактериурийн үед жирэмсэн эмэгтэйд 10%-д нь шээсний замын хурц халдвар үүснэ
 - E. Шинж тэмдэглэггүй бактериуртэй эмэгтэйчүүдийн 1%-д шээсний замын төрөлхийн гажиг тохиолдоно
217. Хүйн судасны жинхэнэ зангилаа нь ургийн дараах хүндрэлийн алиных нь эрсдэлийг нэмэгдүүлдэг вэ?
- A. Амьгүй төрөлт
 - B. Тархины саажилт
 - C. Ургийн тархинд цус харвах
 - D. Хромосомын гаж хөгжил
 - E. Урагт цус багадах
218. Хязангийн шарх халдварлагдсан тохиолдолд хэзээ дахин оёдол тавьж болох вэ?
- A. Задарснаас хойш 24 цагийн дараа
 - B. Эдэд сайжрал ажиглагдсан үед
 - C. Өвчтөн 24 цагийн турш халуураагүй бол
 - D. Шарх халдваргүй, ягаан грануляцийн эдээр бүрхэгдсэн үед
 - E. Жилийн дараа
219. Амниоредукци хийхэд ойролцоогоор нэг удаад хэдэн мл шингэнийг ямар хугацаанд авах нь зөв бэ?
- A. 200-300 мл шингэнийг 5-8 хормын хугацаанд
 - B. 300-500 мл шингэнийг 10-15 хормын хугацаанд
 - C. 500-800 мл шингэнийг 15-20 хормын хугацаанд
 - D. 1000-1500 мл шингэнийг 30 хормын хугацаанд
 - E. 1500 -2000 мл шингэнийг 1 цагийн хугацаанд

220. Гүнийн венийн тромбозтой жирэмсэн эмэгтэйд бага молекул жинтэй гепарин хэрэглэж байгаа. Төрөх эсвэл кесар мэс засалд орохоос хэдэн цагийн өмнө эмчилгээг зогсоох шаардлагатай вэ?
- A. 1 сарын өмнө
 - B. 14 хоногийн өмнө
 - C. 7 хоногийн өмнө 24 цагийн өмнө
 - D. 24 цагийн өмнө
 - E. Зогсоох шаардлагагүй үргэлжүүлнэ
- 221-222. 32 настай анхны жирэмсэн, 14 долоо хоногтойд ээлжит хяналтандаа ирсэн. Анхны шинжилгээнд ялтас эсийн тоо 60,000, бусад үзүүлэлтүүд хэвийн. Шээсэнд бага зэрэг уураг илэрсэн. АД 120/70 ммМУБӨ, пренатал аминдэмээс өөр эм уугаагүй. Асуумжид: жирэмслэхээс өмнө хааяа буйл болон хамраас цус гардаг байсан Арьс амархан хөхөрдөг.
221. Эмэгдэйд дараах эмгэгүүдээс тохирохыг нь тэмдэглэнэ үү
- A. Харь дархлалын тромбббцитопени
 - B. Жирэмсний тромбоцитопени
 - C. Дархлалын тромбоцитопенический пурпур
 - D. HELLP хам шинж
 - E. Жирэмснээр сэдээгдэсэн АД ихсэлт
222. Ялтас эсийн цөөрлийг хэрхэн эмчлэх вэ?
- A. Эмчлэх шаардалаггүй
 - B. Амин дэмийг зогсооно
 - C. Кортикостеройд уулгана
 - D. Судсаар иммуноглобулин хийнэ
 - E. Дэлүү авах мэс засал хийнэ
223. Жирэмсний эрт үед ХАШ-нд “Лямбда” шинж илэрвэл юу гэж таамаглах вэ?
- A. Диохорион Диамнион ихэр
 - B. Монохорион Моноамнион ихэр
 - C. Монохорион Диамнион ихэр
 - D. Монозигот ихэр
 - E. Ургаас урагт цус юүлэгдэх хам шинж
224. Ихэр жирэмсний нийт тохиолдлын 25%-д нь үхэлд хүргэдэг хэлбэрийг нэрлэнэ үү
- A. Дихорион Диамнион
 - B. Монохорион Моноамнион
 - C. Монохорион Диамнион
 - D. Ургаас урагт цус юүлэгдэх хам шинж
 - E. Монозигот ихэр
225. HELLP хам шинжийн Mississippi ангилалаар ялтас эсийн тоо хэд бол 2-р зэрэгт хамаарах вэ?

- A. <50.000
 - B. 50.000-70000
 - C. >50.000-<100.000
 - D. 100.000-120.000
 - E. <150.000
226. Төмөр 1 мл цусанд хэдэн мг агуулагдах вэ?
- A. 0,5 мг
 - B. 1 мг
 - C. 2 мг
 - D. 3 мг
 - E. 4 мг
227. Биений юмны мөчлөгийн үед 25-30 мл цус алдахад хичнээн мг элементал Төмөр алдагдах вэ?
- A. 3-5 мг
 - B. 5-8 мг
 - C. 8-12 мг
 - D. 12-15 мг
 - E. 15-20 мг
228. Жирэмсэн үед хоногт хэдэн мг Иод шаардлагатай вэ?
- A. 40-50 мг
 - B. 50-100 мг
 - C. 100-150 мг
 - D. 150-200 мг
 - E. 200-250 мг
229. Амнионтестээр үтрээний рН хэд бол ураг орчмын шингэн гарсан гэж үзэх вэ?
- A. 4-4,5
 - B. 4,5-5,0
 - C. 5,0-5,5
 - D. 5,5-6,0
 - E. 6,5-7,5
230. Ургийн толгой бага аарцгийн орох хэсэгт шулуун хэмжээнд тавигдах нь ямар хэлбэрийн аарцгийн үед ихэвчлэн тохиолддог болохыг нэрлэнэ үү
- A. Жигд уйтарсан аарцаг
 - B. Жигд уйтарсан хавтгай аарцаг
 - C. Хавтгай аарцаг
 - D. Сульдаагийн үеийн хавтгай аарцаг
 - E. Хөндлөн уйтарсан аарцаг
231. Хэвийн жирэмсний 20-40 долоо хоногтойд хэт авиан Допплер шинжилгээнд хүйн артерийн агшилт сулралын харьцаа хэд хүртэл хэвийн гэж үзэх вэ?

- A. 2.1
 - B. 2.5
 - C. 3.0
 - D. 3,5
 - E. 3,9
232. Хэт авиан Допплер шинжилгээгээр жирэмсний 3 дах гурван сард умайн артерийн агшилт сулралын харьцаа хэдээс дээш бол хэвийн биш гэж үзэх вэ?
- A. >1.0
 - B. >2,0
 - C. >3.0
 - D. >4.0
 - E. >5.0
233. Үтрээний үзлэгээр ургийн их зулайн урд ирмэг, хөмсөгний төвгөр, нүдний ухархайн дээд нум тэмтрэгдэнэ. Ургийн түрүүлэлтийг тэмдэглэнэ үү?
- A. Нүүр түрүүлэлт
 - B. Дух түрүүлэлт
 - C. Арын янзтай дагз түрүүлэлт
 - D. Арын янзтай нүүр түрүүлэлт
 - E. Оройн түрүүлэлт
234. Эхээс хүүхдэд ХДХВ-ийн халдвар дамжих магадлал хэдийд хамгийн өндөр байдаг вэ?
- A. Хүүхэд эхийн хэвлийд байх үед
 - B. Хөхүүл үед
 - C. Нярай үед
 - D. Төрөх үед
 - E. 1-5 насанд
235. Үтрээгээр хэвийн төрсний дараах эхний 15-20 хоромд зүрхний шахалт хэрхэн өөрчлөгддөг вэ?
- A. 20-30% буурна
 - B. 30-50% буурна
 - C. Өөрчлөлт бага илэрнэ
 - D. 0-50% нэмэглэнэ
 - E. 60-80% нэмэглэнэ
236. Прогестерон даавар шар биеээс ихсээс ялгарч эхлэх шилжилт хэзээ явагддаг вэ?
- A. 6-7 долоо хоног
 - B. 7-9 долоо хоног
 - C. 9-10 долоо хоног
 - D. 10-12 долоо хоног
 - E. 12-14 долоо хоног

237. Жирэмсний 30 долоо хоног хүртлэх дутуу төрөлтийн шалтгаанд хориоамнионит хэдэн хувийг эзлэх вэ?
- A. 10%
 - B. 20%
 - C. 30%
 - D. 40%
 - E. 50%
- 238-239. 16 настай, биений юмгүйдэлтэй, биеийн өндөр 145 см, жин 53 кг, БЖИ 25,2, хөхний хөгжил Теннерийн 2-р үе шат, үтрээ бэлгийн уруулын хөгжил хэвийн ээж нь охиноо үеийнхнээсээ намхан гэж сэтгэл нь зовдог
238. Охинд дараах эмгэгүүдийн аль нь байж болох вэ?
- A. Тернерийн хам шинж
 - B. Төрөлхийн бөөрний дээд булчирхайн гиперплази
 - C. Андроген мэдрэг бус хам шинж
 - D. Анорексийн хамааралтай биений юмгүйдэл
 - E. Криптоменоррея
239. Охинд хийгдэх хамгийн чухал шинжилгээг нэрлэнэ үү
- A. ЭХО
 - B. ЛД,ФСД, тестостерон
 - C. Бамбайн үйл ажиллагаа
 - D. Хромосомын шинжилгээ
 - E. Андроген, эстроген даавар
240. Хамгийн эхний шатны тохиромжтой эмчилгээг нэрлэнэ үү
- A. L-тироксин
 - B. Жирэмслэхээс хамгаалах дааврын хавсарсан бэлдмэл
 - C. Прогестерон эмчилгээ 3 сар
 - D. Преднизолон
 - E. Эстроген орлуулах даавар
241. Эндометриозын эмчилгээг 2 сар хийсний дараа нүүр халуу оргих, үтрээ хуурайших, бэлгийн дур хүсэл буурах шинж илэрсэн. Дараах эмүүдийн аль нь ийм байдал үүсгэх вэ?
- A. Андрогены бэлдмэл
 - B. Гонадотропины релизинг дааврын агонист
 - C. Жирэмслэхээс хамгаалах дааврын хавсарсан бэлдмэл
 - D. Прогестаген
 - E. Стероид бус үрэвслийн эм
242. Жирэмсэн үедээ хурц пиелонефритээр өвдсөн эмэгтэйд эмнэлгээс гарсны дараа антибиотик эмчилгээг хэд хоног үргэлжлүүлэх хэрэгтэй вэ?
- a. 3-5 хоног
 - b. 5-7 хоног

- c. 7-14 хоног
 - d. 14-21 хоног
 - e. Уухаар антибиотик эмчилгээг үргэлжлүүлэх шаардлагагүй
243. Жирэмсний төгсгөлд үтрээний цитологи шинжилгээгээр ямар эс давамгайлах вэ?
- A. Гадаргуугийн эс
 - B. Завсрын эс
 - C. Суурь эс
 - D. Суурийн хажуугийн эс
 - E. Суурь ба суурийн хажуугийн эс
244. Хориокарцинома уушгинд үсэрхийлэх гадна өөр аль эрхтэнд илүү үсэрхийлдэг вэ?
- A. Умайн хүзүү
 - B. Үтрээ
 - C. Төв мэдрэлийн тогтолцоо
 - D. Яс
 - E. Элэг
245. Жирэмсэн эмэгтэйн сийвэнгийн эзэлхүүн хэзээнээс нэмэгдэж эхлэх вэ?
- A. 6-8 долоо хоногтойгоос
 - B. 10-12 долоо хоногтойгоос
 - C. 15-20 долоо хоногтойгоос
 - D. 21-24 долоо хоногтойгоос
 - E. 25-28 долоо хоногтойгоос
246. Дараах таталтын эмнүүдээс дангаар нь хэрэглэхэд аль нь ургийн төрөлхийн хөгжлийн гажиг үүсгэх хамгийн их эрсдэлтэй вэ ?
- A. Фенотойн
 - B. Вальпроевын хүчил
 - C. Фенобарбитал
 - D. Габапентин
 - E. Карбомезапин
247. Ургийн шингэн хэзээнээс ургийн бөөрнөөс ялгарч эхэлдэг ?
- A. 8 долоо хоног
 - B. 12 долоо хоног
 - C. 14 долоо хоног
 - D. 18 долоо хоног
 - E. 22 долоо хоног
248. Хэт авиан шинжилгээгээр нэг карманд байх ургийн шингэний хэмжээ 11 см бол ихдэлийн зэргийг нэрлэнэ үү?
- A. Хэвийн
 - B. Ургийн шингэний бага зэргийн ихдэл

- C. Ургийн шингэний дунд зэргийн ихдэл
- D. Ургийн шингэний хүнд зэргийн ихдэл
- E. Ургийн шингэний хэт ихдэл

248-249. Ж., 47 настай, үр шилжүүлэн суулгаж жирэмсэлсэн. ЭХО-д 7 долоо хоногтойд 3 ихэр ураг оношлогдсон. Түүний нэг ургийн хүзүүний арын тунгалаг зай 5 мм хэмжигдсэн.

249. Дараах эмгэгийн аль нь тохиолдох магадлал ихтэй вэ?

- A. Мэдрэлийн гуурсны гажиг
- B. Урагт зүрхний гажиг
- C. Ургийн хүзүүний арын тунгалаг зай тээлтийн 20 долоо хоног хүртэл ихсэж болно.
- D. Бусад урагт ургийн хүзүүний арын тунгалаг зай үзэж хромосомын гажиг үүсэх эрсдлийг харьцуулна
- E. Хэрэв урагт ануплоид илэрвэл хамгийн магадлалтай нь Тернер хам шинж юм.

250. Дараах өгөгдлүүдээс ахондроплази өвчний онцлогийг аль нь илтгэж байна вэ?

- A. Аутоссом рецессив байдлаар удамшина
- B. Нийт тохиолдлын 50%-ийг шинэ мутаци эзэлнэ.
- C. Кесар мэс засал хийх нь цөөн тохиолддог
- D. Нөхөн үржихүйн нас хүртэл амьдрах нь ховор
- E. Нурууны гажиг нь хүйн дарагдалд нөлөөлдөг

251. Хэт авиан шинжилгээгээр “Лемон” ба “Банан”-ы шинж илэрсэн бол ямар эмгэгийг таамаглах вэ?

- A. Дауны хам шинж
- B. Талассеми
- C. Тархины саажил
- D. Клайнфильтерийн хам шинж
- E. Spina bifida

252. Гипертиреозтой жирэмсэн эмэгтэйд профилтиоурацил эмчилгээ хийгдэж байгаа бол TSH ба T4 –ийг хэвийн түвшинд ортол ямар хугацаанд хянах вэ?

- A. Долоо хоногт 1 удаа
- B. 2 долоо хоног тутам
- C. 3 долоо хоног тутам
- D. 4 долоо хоног тутам
- E. 3 сард нэг удаа

253. Жирэмсний шар бие хэдэн долоо хоног хүртэл жирэмсний үйл явцад чухал нөлөө үзүүлэх вэ?

- A. <7 хоног

- B. 7-9 долоо хоног
- C. > 9 долоо
- D. >10 долоо хоног
- E. > 11 долоо хоног

254-257. Жирэмсний хяналтанд 17 настай охин анх 16 долоо хоногтойд үзүүлсэн. Шээсний бактериологи шинжилгээ хийхэд 1мл шээсэнд >100.000 бактери илэрсэн.

254. Дараах эмгэгүүдээс аль нь байж болох вэ?

- A. Цистит
- B. Пиелонефрит
- C. Дивертикулит
- D. Шинж тэмдэггүй бактериури
- E. Гломерулонефрит

255. Дээрхи байдал нь жирэмсний ойролцоогоор хэдэн хувьд тохиолддог вэ?

- A. 10%
- B. 20%
- C. 30%
- D. 40%
- E. 50%

256. Тухайн эмэгтэйд ямар эмчилгээ хийх нь тохиромжтой вэ?

- A. Ампициллин
- B. Цифрофлаксацин
- C. Нитрафурантоин
- D. Септрин
- E. 5 нок

257. Дээрхи байдал дахих эрсдэл хэдэн хувь бэ?

- A. 10%
- B. 20%
- C. 30%
- D. 40%
- E. 50%

258. Ялтас эсийн тоо >450,000 илүү болохыг тромбоцитоз гэх ба жирэмсэн үед >1,000.000 бол та ямар эмгэг гэж таамаглах вэ?

- A. Үсэрхийлсэн хавдар
- B. Төмөр дутагдлын цус багадлын хүндрэл
- C. Халдвар
- D. Эссенциал тромбоцитоз
- E. Үсэрхийлсэн хавдар

259. Жирэмсэн эмэгтэйн арьс гэрэлд мэдрэг, улайдаг. Иймд сиситемийн чонон хөрвөсний шинжилгээ өгөх шаардлагатай болсон. Энэ эмгэгийн үед олон янзын

эсрэг биеүүдийг тодорхойлж оношилдог. Эдгээрэс антинуклеар эсрэг бие нь оношилгооны хэр зэрэг мэдрэг болохыг нэрлэнэ үү

- A. >50%
- B. >60%
- C. >70%
- D. >80%
- E. >90%

260. Өндгөвчийн уйланхай хөл дээр мушгирах, уйланхайн бүрхүүл хагарах хүндрэл, жирэмсний ямар хугацаанд илүү тохиолдох вэ?

- A. 12-24 долоо хоног
- B. 12 долоо хоног дотор
- C. 24-32 долоо хоног
- D. 32-36 долоо хоног
- E. Төрөх үед

261. Эмэгтэй Ж., 33 настай, жирэмсэн үедээ халдвартай байжээ. Аль вирусийн давтан халдвар урагт эрсдэл багатай байдаг вэ?

- A. В бүлгийн Коксакивирус
- B. Улаануудын вирус
- C. Салхин цэцэгийн вирус
- D. Бүслүүр үлдийн вирус
- E. Хомхойн вирус 2 –р тип

262. Ургийн эмгэг сэжиглэгдэж байгаа тохиолдолд хорионбиопсийн шинжилгээг жирэмсний хэдэн долоо хоногтойд хийх вэ ?

- A. 9-11
- B. 11-13
- C. 13-15
- D. 15-16
- E. 16-22

263. Төрөлтийн үед хуурамч дүлэлт илрэх нь юуг илтгэх вэ?

- A. Эмнэл зүйн уйтан аарцгийн шинж
- B. Суудлын мэдрэлийн цочирсны шинж
- C. Умайн хүзүүний дээд уруул дарагдсаны шинж
- D. Дискоординаци болсны шинж
- E. Түргэн төрөлтийн эхний шинж

264. Төрөлт саатсан үед умайн дээд болон доод хэсэг хүчтэй агшихад ямар эмнэл зүйн шинж илэрч болх вэ?

- A. Гегарын шинж
- B. Бандлын кольцо
- C. Цус гарах
- D. Чадвикийн шинж

- Е. Гентерийн шинж
265. Төрсний дараа зүрхний зүүн ховдолд гарсан өөрчлөлт ямар хугацаанд хэвийн байдалдаа эргэн орох вэ?
- А. Эхний 10 хоногт
 - В. 2-4 долоо хоногт
 - С. 10-12 долоо хоногт
 - Д. 12-16 долоо хоногт
 - Е. 16-24 долоо хоногт
266. Эмэгтэй 22 настай, анхны жирэмсэн, 14 долоо хоногтой, муу хянагдсан чихрийн шижингийн 1-р хэлбэртэй. Шинжилгээгээр креатинины хэмжээ 3,5 мг/дл байгаа нь бөөрний талаас ямар асуудалтай байж болох вэ?
- А. Жирэмсэн үеийн хэвийний дээд хязгаарт байна
 - В. Жирэмсэн үед байх хэмжээнээс бага байна
 - С. Бөөрний хөнгөн зэргийн дутагдалтай байна
 - Д. Бөөрний дунд зэргийн дутагдалтай байна
 - Е. Хүнд зэргийн бөөрний дутагдалтай байна
267. Дараах халдваруудаас аль нь жирэмсний цэс зогсонгилийн эрсдлийг нэмэгдүүлэх вэ?
- А. Гепатит В
 - В. Гепатит С
 - С. Цитомегаловирус
 - Д. ХДХВ
 - Е. Салхинцэццэгийн вирус
268. Тэмбүүгийн үед ихсэнд гарах өөрчлөлтийг тэмдэглэнэ үү?
- А. Ихэс хавагнана.
 - В. Ихэс хатингаршина.
 - С. Ихэсд өөрчлөлт гарахгүй.
 - Д. Ихэс зөөлөрч, улбайна.
 - Е. Ихэс шохойжино.
269. Хүйн судасны жинхэнэ зангилаа нь дараах ургийн хүндрэлүүдээс алиных нь эрсдлийг нэмэгдүүлдэг вэ?
- А. Амьгүй төрөлт
 - В. Тархины саажилт
 - С. Ургийн тархинд цус харвах
 - Д. Хромосомын гаж хөгжил
 - Е. Ургийн шингэний эмгэг
270. Дараах Нөхөн Үржихүйн технологийн аль нь ургийн гаж хөгжил илүү үүсгэдэг болохыг нэрлэнэ үү
- А. Хөлдөөсөн үр хөврөл шилжүүлэн суулгах

- B. Өндгөвчийг хориальны гонадотропин релизинг дааврын аганистоор сэдээсэн
 - C. Өндгөвчийг хориальны гонадотропин релизинг дааврын антогонистоор сэдээсэн
 - D. Хуруу шилэнд үр тогтоосон
 - E. Цитоплазмд эр бэлгийн эс тарьсан
271. Жирэмсний 28 долоо хоногтой умайн хүзүүнд ургийн фибронектинийг шинжилэхэд сөрөг гарах нь юуг илэрхийлэх вэ?
- A. 24-48 цагийн дотор төрнө.
 - B. 1 долоо хоногийн дотор төрнө
 - C. 1 долоо хоногийн дараа төрөхгүй
 - D. 14 хоногийн дотор төрнө
 - E. 14 хоногийн дараа төрөхгүй
272. 32 настай, 32 долоо хоногтой жирэмсэн. ЭХО-д УОШ-ний эзлэхүүн 32см бол дараах байдлуудаас аль нь үүссэн байж болох вэ?
- A. Ургийн 12 нугалаа гэдэсний атрези
 - B. Ургийн бөөрний эмгэг
 - C. Резус мэдрэгшил үүссэн
 - D. HELLP хамшинж
 - E. Тромбоцитопенийн пурпура
273. Дараах халдваруудаас аль нь жирэмсний элгэн доторхи цэс зогсонгишлийн эрсдлийг нэмэгдүүлдэг вэ?
- A. Гепатит В
 - B. Гепатит С
 - C. Цитомегаловирус
 - D. ХДХВ
 - E. Салхин цэцгийн вирус
274. 36 настай, Gr II-I 24 долоо хоногтой, сарын өмнөөс эхлэн ядарч сульдаж эхэлсэн. Шинжилгээнд: Hb 8.0 гр/дл, цагаан эс 2000 /мл, ялтас эс 20,000 мл байв. Дараах хүндрэлүүдээс аль нь тохиолдсон байж болох вэ?
- A. Төмөр дутлын цус багадалт
 - B. HELLP хам шинж
 - C. Манас таталын урьдлын хүнд хэлбэр
 - D. Хурц лейкеми
 - E. Жирэмсэн үеийн ялтас эсийн цөөрөл
275. Төрөх дөхсөн үед ихэс/ургийн жингийн харьцаа хэд хүртэл байх вэ?
- A. 1/4
 - B. 1/5
 - C. 1/6
 - D. 1/7

Е. 1/8

276. Цус алдалт хэдээс дээш хувь бол оновчтой эзэлхүүний сэхээн амьдруулалт шаардлагатай вэ?
- А. >5-10%
 - В. >10-15%
 - С. >15-20%
 - Д. >20-25%
 - Е. > 30-40%
277. Эмэгтэй амьд донороос бөөр шилжүүлэн суулгасан бол хэдий хугацааны дараа жирэмсэлж болно гэж зөвлөх вэ?
- А. 6 сарын дараа
 - В. 1 жилийн дараа
 - С. 1 жил 6 сарын дараа
 - Д. 2 жилийн дараа
 - Е. 3 жилийн дараа
278. Дутуу нярайн тархины саажилт үүссэхээс сэргийлэхэд дараах эмүүдээс алийг хэрэглэдэг вэ?
- А. Бетаметазон
 - В. К аминдэм
 - С. Индометацин
 - Д. Магни сульфат
 - Е. Тербуталин
279. Дутуу төрөлтийн кальцийн сувгийн хориглогчийг ямар эмийн бодисуудтай хэрэглэж болохгүй вэ?
- А. Ветта агонист
 - В. Стероид бус үрэвслийн эм
 - С. Магни сульфат
 - Д. Кортикостероид
 - Е. Цефалоспорины бүлгийн антибиотик
280. Их хэмжээний цус сэлбэлтийн үед бүлэн үүсэхээс сэргийлэх зорилгоор шинэ хөлдөөсөн сийвэн ямар тунгаар хийх вэ?
- А. 4 нэгж тутамд 10-12мл/кг
 - В. 4 нэгж тутамд 12-15мл/кг
 - С. 4 нэгж тутамд 15-18мл/кг
 - Д. 6 нэгж тутамд 12-15мл/кг
 - Е. 8 нэгж тутамд 15-18мл/кг
281. Ихсийн хурц дутагдлын үндсэн шалтгаан юу болох вэ?
- А. Тулгарсан дутуу төрөлт
 - В. Тамхи таталт
 - С. Жирэмсний хүнд хэлбэрийн хожуу хордлого

- D. Ихсийн ховхрол
 - E. Мэрэгжлийн хортой нөхцөл
282. Билирубиний хэмжээ хэдээс дээш байхад арьсанд шарлалт үүсдэг вэ?
- A. >6,8 ммоль/л
 - B. >13 ммоль/л
 - C. >18 ммоль/л
 - D. >20 ммоль/л
 - E. >35 ммоль/л
283. Алговерийн индексийн хэвийн үзүүлэлтийг тодорхойлно уу.
- A. 0.5-0.54
 - B. 0.5-0.74
 - C. 1,0-1,4
 - D. 1,5-2,0
 - E. 2- 2.5
284. Өвчтөн 25- настай. Жирэмслэлт 1, үр хөндөлт хийлгэсний дараа умайн хөндийг хусаж цэвэрлэсэн шинжилгээнд трофобластын хавдар оношлогдсон. Анхдагч эмчилгээг юугаар эхлэх вэ?
- A. Таксол
 - B. Цисплатин
 - C. Доксорубцин
 - D. Гемситабин
 - E. Дактиномецин
285. Анти Д титр хэд бол урагт гидропс үүсэх эрсдлийн дээд хязгаар гэж үзэх вэ?
- A. 1:8
 - B. 1:16
 - C. 1:32
 - D. 1:64
 - E. 1:72
286. Резус үл тохироо үүссэн үед ургийн цус задралыг Лилейгийн муруйг ашиглаж ургийн тавиланг тодорхойлдог. Хэрэв муруйн 3-р бүсэд байвал ямар арга хэмжээ авах вэ?
- A. Эхийн титрийг 14 хоног тутам шалгана
 - B. Анмиоцентезыг 10-14 хоноод хийнэ
 - C. ХАШ-ээр 7 хоног бүр ургийн шингэнийг тодорхойлно
 - D. Ургаас цусны шинжилгээ авна
 - E. Цус задрал бага байгааг илтгэх тул онцгой хяналтанд байлгана
287. Ургийн цус багадалтын үед тархины уднд артерийн агшилтын дээд хурд хэдээс их бол урагт цус багадлт илэрхий үүссэн гэж үзэх вэ?
- A. > 0.5 МоМ
 - B. >1,0 МоМ

- C. >1,5 MoM
 - D. >2,0 MoM
 - E. > 2,5 MoM
288. Үр хөврөлийн хөгжлийн хэдэн долоо хоног хүртэл амбисексуал үе байдаг вэ?
- A. 4д/х
 - B. 6д/х
 - C. 8д/х
 - D. 10д/х
 - E. 12д/х
289. Цээж гэрэлд харах стандарт шинжилгээг ямар хугацаанд давтан хийх вэ?
- A. 7-10 хоног
 - B. 10 -14 хоног
 - C. 14-21 хоног
 - D. 1 сар
 - E. 2 сар
290. Цөс зогсонгишлын үед дараах шинжүүдээс аль нь түрүүлж илрэх вэ?
- A. Арьс загатнах
 - B. Арьс шарлах
 - C. Цөсний хүчил нэмэгдэх
 - D. Шээсний өнгө өөрчлөгдөх
 - E. Баас өөрчлөгдөх
291. Элэгний циррозтой эмэгтэйд үүдэн венийн судас хэдэн мм -ээс өргөссөн бол жирэмслэлт тээлгэхийг хориглох вэ?
- A. 2 мм
 - B. 3 мм
 - C. 4 мм
 - D. 5 мм
 - E. 6 мм
292. Жирэмсэн үед сийвэнд креатинин хэд байвал бөөрний үйл ажиллагааны алдагдлын хүнд зэрэг гэж үзэх вэ?
- A. < 1.5 мг/дл
 - B. >1,5 мг/дл
 - C. >2,5 мг/дл
 - D. >3 мг/дл
 - E. >4 мг/дл
293. HELLP хам шинжийн үед дараах хүндрэлүүдээс аль нь хамгийн элбэг тохиолдох вэ?
- A. Цус бүлэгнэлтийн алдагдал
 - B. Бөөрний дутагдал
 - C. Уушги хавьагнах

- D. Ихэс ховхрох
- E. Элэгний дутагдал


294. Кесар мэс заслаар төрөх бөл ялтас эс ямар хэмжээтэй бол ялтас эсийн өтгөрүүлэг хийх вэ?

- A. 20,000 мк/л
- B. 30000 мк/л
- C. 40,000 мк/л
- D. 50000 мк/л
- E. 80,000 мк/л

295. Анти D эсрэгбие үүсээгүй бол иммуноглобулины хэдэн мкг урьдчилан сэргийлэх тунг хэрэглэх вэ?

- A. 150
- B. 200
- C. 250
- D. 300
- E. 350

296. 39 настай, Ж4 Т2, 37 д/х-той өвдөж ирсэн. Умайн хүзүү 2 цагт 4см-ээс 5 см бол нэмэгдсэн. Ургийн урьдчилсан жин 3500,0 эхийн аарцагтай тохирсон. Ургийн бичлэгийг доор харуулав. Дараагийн шатанд юу хийх вэ?



- A. Кесар мэс засал
- B. Төрөлтийг хүлээж удирдана
- C. Ургийн шингэний бүрхүүлийг хагалах
- D. Ургийн хуйхны шинжилгээ
- E. Тербуталин

297. 36 настай Ж2Т1, 24 д/х-той. Сүүлийн нэг сар ядарч сульдана гэсэн зовуурьтай байсан. Шинжилгээнд гемогобин 8.0 гр/дл, цагаан эс 2.0^9 /л, ялтас эс 20,000 мк/л. Ямар эмгэг байж болох вэ?
- A. Төмөр дутагдлын цус багадалтын хүнд зэрэг
 - B. HELLP хам шинж
 - C. Манас таталтын урьдлын хүнд хэлбэр
 - D. Хурц лейкеми
 - E. Идиопатический тромбоцитопени
298. 31 настай Ж3Т2, 34 д/х-той, бие өвдөнө дотор муухай оргино гэсэн зовуурьтай ирсэн. Ирэх үед АД 110/82, ургийн зүрхний бичлэг хэвийн. Гемоглобин 9.0 гр/дл, лейкоцит 8000 /mL, ялтас эс 84000 мк/л, ALT - 500 IU/L, AST 550 IU/L, билирубин 2.5 мг/дл. Дараахаас эмгэгүүдээс аль нь байж болох?
- A. Хурц лейкоз
 - B. HELLP syndrome
 - C. C вирусын хурц гепатит
 - D. МТУ-ын хүнд хэлбэр
 - E. Вирусын халдвар
299. 28 настай, хүүхдэд нь тагнай цоорхой төрсөн. Бусад байдал нь хэвийн. Эмэгтэй эмчээс удамшлын шалтгаан нөлөөлдөг үү гэж асуусан. Дараахаас аль нь дээрх байдалд нөлөөлөх вэ?
- A. Аутосом доминант
 - B. Аутосом рецессив
 - C. X- хэлхээ доминант
 - D. X- I хэлхээ рецессив
 - E. Олон хүчин зүйлийн нөлөөтэй
300. 28 настай, Ж1Т0, 16 д/х- той шинжилгээнд Сийвэнд АФП 2.9 МоМ болж нэмэгдсэн. Зорилтот хугацаанд ХАШ -д мэдрэлийн гуурсны гажгийн шинж илрээгүй, асуумжаар эрсдэлт хүчин зүйлс байхгүй. Шалтгаан тодорхойгүй АФП нэмэгдсэн нь цаашид дараахаас алийг үүсгэх өндөр эрсдэлтэй вэ?
- A. Амьгүй төрөх эрсдэл нэмэгдэнэ
 - B. Жирэмсний чихрийн шиижин
 - C. Ихэс түрүүлэлт
 - D. Цулцан хураа
 - E. Дауны хам шинж
301. Лактат >2 ммол/л бол ямар арга хэмжээ авах вэ?
- A. Хэвийн гэж үзэн дахин шинжлэх шаардлагагүй
 - B. 2-4 дагийн дараа дахин шинжилнэ
 - C. 24 цагийн дараа дахин шинжилнэ
 - D. Эдэд перфузи буурсан гэж үзэн яаралтай эрчимт эмчилгээг эхэлнэ

- Е. Шингэнийг 30 кг/мл бодож сэлбэнэ
302. D dimer хэдээс бага бол ГВТ -ийг үгүйсгэх вэ?
- A. <150 нг/мл
 - B. <200 нг/мл
 - C. <300 нг/мл
 - D. <400 нг/мл
 - E. <500 нг/мл
303. Хорт бодис жирэмсний аль хугацаанд тератоген үйлчлэл үзүүлэх вэ?
- A. 1-11 хоног
 - B. 11-17 дахь хоног
 - C. 57-64 дэх хоног
 - D. 64-101 дэх хоног
 - E. Альч хугацаанд
304. Ананцефали жирэмсний ямар хугацаанд үүсэх вэ?
- A. 28 хоног
 - B. 6 долоо хоног
 - C. 8 долоо хоног
 - D. 10 долоо хоног
 - E. 12 долоо хоног
305. Хүйн венийн эсэргүүцэл нэмэгдэх нь дараахаас алинтай нь хамааралтай вэ?
- A. Ургийн дунд зэргийн бүтэлт
 - B. Ургийн хүнд зэргийн бүтэлт
 - C. Нярайн бүтэлт
 - D. Мэдрэлийн цочрол
 - E. Ургийн гидропс

I.II. К. Сорил

1. Нярайг дулаан алдахаас сэргийлэх аргуудыг нэрлэнэ үү?
 1. Хуурайшуулах
 2. Малгай өмсгөх
 3. Арьс арьсаар шүргэлцүүлэх
 4. Хөхөөр хооллох
 5. Дулаан өлгийдэх
2. Бөгс түрүүлэлтийн үед тохиолдох хүндрэлийг нэрлэнэ үү?
 1. Перинаталь өвчлөл, эндэгдэл нэмэгдэх
 2. Дутуу төрөлт нэмэгдэх
 3. Ургийн хүй унжих
 4. Төрөлтийн үйл ажиллагаа удаашрах
 5. Төрсний дараах цус алдалт
3. Эмэгтэй 3., жирэмсний 30 долоо хоногтой базалж өвдөнө, үтрээнээс цусархаг ялгадас гарна гэсэн зовуурьтай эмнэлэгт ирсэн. Үзлэгээр: Базлалт 10

- хормын зайтай, умайн хүзүү зөөлөрсөн, 3 см нээлттэй ургийн усны бүрхүүл бүтэн байлаа. Ямар арга хэмжээ авах вэ?
1. Магни сульфат судсаар тарих
 2. Шээсэнд бактериологи шинжилгээ хийх
 3. Хэт авиан шинжилгээгээр ургийн жинг тооцох
 4. Цусны бүлэгнэлтийг тодорхойлох
 5. Умайн хүзүүнд оёдол тавих
4. Жирэмсэн үед эх тамхи татах нь жирэмсний явц болон урагт хэрхэн нөлөөлөх вэ?
1. Гемоглобин үүсэх болон төмрийн солилцоог идэвхгүйжүүлнэ.
 2. Жин багатай хүүхэд төрнө.
 3. Ихсийн цусан хангамж муудна.
 4. Ургийн өсөлт баригдах
 5. Эхийн цусанд нүүрс хүчлийн хий нэмэгдэнэ
5. Ураг орчмын шингэн юунаас үүсэх вэ?
1. Ургийн цусны сийвэнгээс
 2. Ургийн бүрхүүл хальснаас
 3. Ургийн шээснээс
 4. Эхийн цусны сийвэнгээс
 5. Ургийн арьсны ялгарлаас
6. Прогестерон даавар жирэмсний явцад ямар үүрэгтэй вэ?
1. Ургийн хэвийн өсөлтийг хангах
 2. Умайн булчинг сулруулах
 3. Умайн салстын шүүрлийг хангах
 4. Умайн холбоосуудыг сулруулах
 5. Хөхний булчирхайн хөгжлийг дэмжих
7. Эмнэл зүйн уйтан аарцгийг оношлох аргуудыг тэмдэглэнэ үү:
1. Ургийн байдлаар
 2. Эмнэл зүйн илрэлээр
 3. Умайн базлалтын хүчээр
 4. Вастены шинжээр
 5. Эхийн аарцгийн хэмжээгээр
8. Умайн базлалтыг үнэлэх шинжийг нэрлэнэ үү
1. Контракци
 2. Ретракци
 3. Дистракци
 4. Базлалтын хүч
 5. Умайн хүзүүний нээгдэлт
9. Хязан сэтлэх заалтыг нэрлэнэ үү?
1. Мөр гаргахад төвөгтэй

2. Өндөр хярзантай
 3. Ургийн бүтэлт
 4. Урьд нь хярзан сэргээх мэс засал хийлгэсэн
 5. Өмнө нь аарцгийн ёроолын буулчинд мэс засал хийлгэсэн
10. Төрсний дараах цус алдалтанд нөлөөлөх хүчин зүйлсийг тэмдэглэнэ үү?
1. Ихэр жирэмсэн
 2. Төрөлт удаан үргэлжилсэн
 3. Ургийн ус их байх
 4. Тромбоцитын тоо цөөрөх
 5. Ургийн хөндлөн байрлал
11. Төрөхөд бэлтгэгдэж байгааг ямар үзүүлэлтээр үнэлэх вэ?
1. Үтрээний эсийн шинжилгээ
 2. Умайн хүзүүний байдал
 3. Окситоциний сорил
 4. Braxton Hicks базлалт
 5. Умайн ёроолын өндөр
12. Ихэр жирэмсний талаархи ойлголтонд хамаарагдахыг дурьдана уу?
1. Туранхай, намхан чацтай эмэгтэйд илүү тохиолдоно.
 2. Хоёр өндөгний ихэр илүүтэй тохиолдоно.
 3. 4-6 дахь өдөрт үр хөврөл хуваагдалд орвол нэг цэлмэн, нэг амнион бүрхүүлтэй байх нь олонтой.
 4. Ихэр жирэмсэн үүсэхэд эхийн нас хамааралтай.
 5. Хоёр ургийн хоорондын жингийн зөрөө дунджаар 800-1000 гр байж болно
13. Жирэмсний хожуу гестозын эмчилгээний зорилго:
1. Шээсээр уураг алдалтыг бууруулах
 2. Цусны эргэлтийн сайжруулах
 3. Хүчил суурийн байдлыг тэнцвэржүүлэх
 4. Таталтаас сэргийлэх
 5. Даралтыг тогтворжуулах
14. Ихэс ховхроход илрэх эмнэл зүйн шинж нь:
1. Ургийн хямрал
 2. Хэвлийн өвдөлт
 3. Умайн булчингийн чангаралт
 4. Үе үе давтагдах цус алдалт
 5. Умайн хүзүү нээгдэхэд үед тохиолдоно
15. Кардиотокографийн шинжилгээгээр дараах үзүүлэлтүүдийг үнэлнэ.
1. Ургийн зүрхний агшилтын давтамж
 2. УЗЦ түргэсэл
 3. УЗЦ удаашрал

4. Агшилтын давтамжийн хэлбэлзэл
 5. Ургийн зүрхний хэм алдагдлал
16. Жирэмсний хожуу гестозын эмнэл зүйн шинжийг нэрлэнэ үү?
1. А/Д ихсэлт
 2. Шингэн баригдах
 3. Ургийн хөгжил баригдах
 4. Шээсний гарц багасах
 5. Шөрмөсний рефлекс нэмэгдэх
17. Зуршсан зулбалтын үндсэн шалтгааныг нэрлэнэ үү?
1. Салаа умай
 2. Дааврын өөрчлөлт
 3. Хромсомын эмгэг
 4. Умайн хүзүүний дутмагшил
 5. Умайн гялтангийн доороос түрж ургасан хоргүй хавдар
18. Ямар нярайг имж аргаар асрахад тохиромжтой вэ?
1. 30 долоо хоногоос хойш хугацаанд төрсөн
 2. Төрөх үеийн биеийн жин $\geq 1,1$ кг
 3. Биеийн ерөнхий байдал нь тогтвортой байгаа
 4. Өрөөний хэм хүйтэн байгаа үед
 5. Хүүхэд хөхөө хөхөж чадахгүй байгаа үед
19. Жирэмсний тээлтийн 37 долоо хоногт+5 хоногтойд 1850 гр жинтэй төрсөн нярай доорхи ангиллын алинд нь хамрагдах вэ?
1. Гүйцэд нярай
 2. Ургийн хөгжлийн сааталтай
 3. Бага жинтэй нярай
 4. Дутуу нярай
 5. Илүү тээлттэй нярай
20. Нярайн сэргийлэх арга хэмжээнд аль нь хамаарах вэ?
1. Нүд нь азот мөнгөний уусмал дусаах
 2. К аминдэм тарих
 3. Дархлаажуулалт
 4. Усанд оруулах
 5. Дулаан байлгах
21. Эмнэл зүйн уйтан аарцаг үүсэх шалтгааныг нэрлэнэ үү?
1. Илүү тээлт
 2. Дух түрүүлэлт
 3. Арын, тэнхлэгийн бус тавилт
 4. Оройн түрүүлэлт
 5. Өврийн янзтай, нүүр түрүүлэлт
22. Магни сульфатын тун хэтэрсэн үед илрэх шинжийг нэрлэнэ үү?

1. Уушги хавагнах
 2. Амьсгалын дутагдал
 3. Гипергликеми
 4. Булчингийн саажилт
 5. Цусанд кали буурах
23. Ихэс түрүүлэлтэнд хамаарагдана:
1. Ихэс, умайн хүзүүний дотор хөөмийг бүрэн таглаж байрлах
 2. Ихэс, умайн хүзүүний дотор хөөмийг хагас таглаж байрлах
 3. Ихэс, умайн хүзүүний дотор хөөмийн ирмэгээр байрлах
 4. Ихэс умайн доод хэсэгт байрлах
 5. Ихэс умайн ар хананд, умайн хүзүүний дотор хөөмийнөөс 3 см-т байрлах
24. Жирэмсний хожуу хордлогын хүнд хэдбэрийн үед илрэх эмнэл зүйн шинжийг нэрлэнэ үү?
1. Ходоодны орчим өвдөх
 2. Толгой өвдөх
 3. Элэгний энзим нэмэгдэх
 4. Нүдний хараа өөрчлөгдөх
 5. Тромбоцитын тоо цөөрөх
25. Эмэгтэй А., 21 настай, тулгар төрөгч, Gr- 34 долоо хоногтой, зовуурьгүй, АД 130/90 мм МУБӨ, шээсэнд уураггүй ямар тусламж үзүүлэх вэ?
1. Хэвтрийн дэглэм
 2. Магни сульфат тарина
 3. Метил-дофа
 4. Хяналтыг сайжруулна
 5. Гидролазин
26. Цэлмэнгийн дааврын онцлог шинжийг нэрлэнэ үү?
1. Лангерхансын эсээс үүсдэг
 2. Ихсийн трофобластаас үүсдэг
 3. ЛД –н үүргийг гүйцэтгэнэ
 4. Шар биеийн үүргийг гүйцэтгэнэ
 5. Эстриолын ялгаралтыг идэвхижүүлнэ
27. Төрсний дараах умайн салстын үрэвсэл үүсэх шалтгааныг нэрлэнэ үү?
1. Ургийн шингэн эрт гарах
 2. Шавхарга хуримтлагдах
 3. Умайн хөндийг гараар шалгах
 4. Үтрээний үзлэг олон дахин хийх
 5. Төрөх замын шархны үрэвсэл
28. Жирэмсний хожуу гестоз үүсэх эмгэг жамыг тайлбарлана уу?
1. Исэлдэлтийн стресс

2. Тромбоцитын тоо цөөрөх
 3. Тромбаксаны ихсэлт
 4. Простоциклин ихсэлт
 5. Гематокрит бууралт
29. Умайн урагдалд хүргэх шалтгааныг нэрлэнэ үү?
1. Умайд хуучин сорвитой байх
 2. Төрөлтийг хүчилж явуулах
 3. Төрөлтийн саатал үүсэх
 4. Үтрээний сорвижилт өөрчлөлт
 5. Хэт залуу насандаа төрөх
30. Жирэмсэн эмэгтэйн бөөрөнд гарах физиологийн өөрчлөлтийг нэрлэнэ үү?
1. Шээлгүүр өргөсөнө
 2. Шээсний зогсонгишил үүснэ
 3. Шинж тэмдэггүй бактериури илэрнэ
 4. Бөөр усжих шинж илэрнэ
 5. Микрогематури
31. Ихэс ховхроход хүргэх шалтгааныг нэрлэнэ үү?
1. Даралт ихсэлт
 2. Бөөрний эмгэг
 3. Тромбоцитопени
 4. Ураг амьгүй болох
 5. Резус үл тохироо
32. Ихэр жирэмсэн үед тохиолдох хүндрэлийг нэрлэнэ үү?
1. Ургийн гаж хөгжил
 2. Ургийн өсөлт баригдах
 3. Аяндаа зулбалт
 4. Дутуу төрөлт
 5. Ихэс түрүүлэлт
33. Илүү тээлт үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлийг нэрлэнэ үү?
1. Анхны төрөгч
 2. Урьд нь илүү тээж байсан
 3. Ураг тархигүй байх
 4. Эмэгтэй хүйсний урагтай байхад
 5. Ихсийн сульфатазын хэмжээ өндөр байх
34. Жирэмсний 20 долоо хоногоос өмнө хүнд хэлбэрийн манас таталт үүсэх шалтгааныг нэрлэнэ үү?
1. Архаг даралт ихсэлт
 2. Бөөрний аягацрын архаг үрэвсэлтэй байсан
 3. Чихрийн шижин жирэмсэнтэй хавсарсан
 4. Цулцан хураа

5. Бодисын солилцооны эмгэг
35. Сурфактант ямар үүрэг гүйцэтгэдэг вэ?
1. Уушгины дотор хананы таталцалыг ихэсгэнэ.
 2. Цулцангийн дотор хананы гадаргуугын таталцалыг багасгана.
 3. Артерийн судасны агшилт үүсгэнэ.
 4. Цулцангууд хоорондоо наалдахаас сэргийлнэ.
 5. Уушигны агааржилтыг бууруулна.
36. Имж аасаргааны ач холбогдлыг дурьдана уу.
1. Нярайг дулаан байлгах
 2. Хөхний сүүний гарц нэмэгдэх
 3. Эх үрсийн холбоог бэхжүүлэх
 4. Эмнэлгийн дотоод халдварыг бууруулах
 5. Хүүхдийн сэтгэц, хөдөлгөөний ерөнхий хөгжил сайжрах
37. Нярайн бүтэлт үүсгэх шалтгааныг дурьдана уу.
1. Эх төмөр дутагдлын цус багадалттай байх
 2. Ихсийн эмгэг
 3. Эх гуурсан хоолойн багтраатай байх
 4. Эхэд унтуулгын бодис хэрэглэх
 5. Эх барихын ажилбар хийгдэх
38. Илүү тээлтийг үед кольпоцитологи шинжилгээнд илрэх үзүүлэлтүүд:
1. Өнгөц эс 40-80%
 2. Завсрын эс цөөн
 3. Завь хэлбэрийн эс байхгүй
 4. КПИ – 40% хүртэл
 5. Эозинофмл индекс 20% хүртэл нэмэгдсэн
39. Жирэмсэн өсвөр насны охидод тохиолдох хүндрэлийг нэрлэнэ үү?
1. Манас таталтын урьдал
 2. Ураг амьгүй болох
 3. Умайн үйл ажиллагааны хямрал
 4. Ургийн удамшлын гаж хөгжил
 5. Илүү тээлт
40. Манас таталтын урьдлаас үүсэх үр дагавруудыг сонгоно уу?
1. Түүдгэнцрийн шүүлт буурах
 2. Шээсний гарц багасна.
 3. Ихсийн цусны эргэлт багасна.
 4. Цусанд шээсний хүчил нэмэгдэнэ.
 5. Эргэлдэх цусны хэмжээ нэмэгдэнэ.
41. Жирэмсэн эмэгтэйн АД 140/100 мм МУБӨ шээсэнд 1+ уурагтай бол та ямар арга хэмжээ авах вэ?
1. АД өөрөө хянах аргад сургана

2. Жирэмсний хяналтыг сайжруулна
 3. Ургийг хянана
 4. Магни сульфат цохилтын тунгаар хэрэглэнэ
 5. Хаван хөөх эм хэрэглэнэ
42. Зуршсан зулбалт үүсэх шалтгаан
1. Умайн гаж хөгжил
 2. Умайн фибромиома
 3. Шар биеийн дутагдал
 4. Бамбай булчирхайн дутагдал
 5. Фолийн хүчил дутагдах
43. Жирэмсэн үед бөөрөнд гарах өөрчлөлт
1. Түүдгэнцрийн шүүлт 50% нэмэгдэнэ.
 2. Альдостерон ялгаралт нэмэгдэнэ.
 3. Шээсэнд бактери илрэх
 4. Прогестерон даавар шээлгүүрийг өргөсгөнө.
 5. Бөөрний тэвшинцэрт шээсний хуримтлал үүснэ
44. ХГД –ын үйлчлэлийг тодорхойлно уу?
1. ФСД,ЛТ даавартай төстөй үйлчлэл үзүүлнэ.
 2. Жирэмснийг оношлоход хэрэглэнэ.
 3. Прогестерон дааврын ялгаралтыг дэмжинэ.
 4. Эстроген дааврын ялгаралтыг идэвхижүүлнэ.
 5. Жирэмсэн үед ургийн хөгжлийг илэрхийлэх гол үзүүлэлт болно.
45. Манас таталтын урьдлын хүнд хэлбэрийн үед илрэх эмнэл зүйн шинжийг нэрлэнэ үү?
1. Толгой хүчтэй өвдөнө
 2. Ходоод орчим өвдөнө
 3. Хоногийн шээсний хэмжээ багасна
 4. Арьс шарлана
 5. Цусан дахь креатинин нэмэгдэнэ
46. Жирэмсний хожуу хордлогын үед тохиолдох хүндрэлүүд
1. Бөөрний дутагдал
 2. Төрсний дараах цус алдалт
 3. Ургийн хөгжил баригдах хам шинж
 4. Уушги хавагнах
 5. Энцефалопати
47. Магни сульфатын тун хэтрэх үед илрэх шинжийг нэрлэнэ үү?
1. Амьсгал цөөрөх, зогсох
 2. Шээсний гарц багасах
 3. Шөрмөсний рефлекс сулрах
 4. Даралт хэт багасах

5. Зүрхний үйл ажиллагаа алдагдах
48. Дутуу төрөлтөнд хүргэх шалтгааныг нэрлэнэ үү?
1. Урьд нь дутуу төрж байсан
 2. Өдөрт >10 тамхи татдаг
 3. Умайн бүтцийн өөрчлөлт
 4. Ихэр жирэмсэн
 5. 4- өөс дээш удаа төрсөн
49. Эмэгтэй Л., 21 настай, тулгар төрөгч ураг орчмын шингэн гарсан, умайн хүзүү 5 см нээлттэй, УЗЦ удааширсан тул кесар мэс засал хийхээр шийдсэн байна. Мэс заслаас өмнө ямар бэлтгэл хийх вэ? арга хэмжээ авах вэ?
1. Эмэгтэйг зүүн хажуугаар хэвтүүлнэ.
 2. Судсаар шингэн сэлбэнэ.
 3. Хүчилтөрөгчийн маскаар амьсгалуулна.
 4. Актовегин судсаар тарина
 5. Тербуталин хэрэглэнэ.
50. Дараах тохиолдлуудын алинд нь кесар хагалгаа хийх вэ?
1. Урьд нь кесар хагалгаа хийлгэж байсан өгүүлэмжтэй
 2. Эх барихын хавчуур тавих оролдлого амжилтгүй болсон
 3. Ургийн бүтэлт
 4. Өврийн янзтай, нүүр түрүүлэлт
 5. Өмнөх төрөлтөнд умайн хүзүүнд оёдол тавиулсан
51. Жирэмсэн эмэгтэйн хооллолтонд өгөх зөв мэдээлэлийг нэрлэнэ үү?
1. Хоолны давсыг хязгаарлана.
 2. Өдөрт 1200 мг кальц хэрэглэнэ.
 3. Хоногийн хоолны илчлэг 3000-3500 ккал байна Өдөрт 400- 800 мг фолийн хүчил хэрэглэнэ.
 4. Жирэмсний 36 долоо хоног хүртэл магни В6 хэрэглэнэ.
52. Төрсний дараах эрт үеийн цус алдалт үүсгэх шалтгааныг нэрлэнэ үү?
1. Умайд миомын зангилаатай байх
 2. 4000 гр жинтэй хүүхэд төрүүлсэн
 3. Бамбайн эмгэгтэй
 4. Олон төрсөн эмэгтэй
 5. Ураг орчмын шингэн эрт гарсан
53. Жирэмсний эрт үеийн гестозод хамрагдах эмнэл зүйн хэлбэрүүдийг сонгоно уу?
1. Бөөлжилт
 2. Шүлс гоожилт
 3. Шарлалт
 4. Гуурсан хоолойн багтраа
 5. Арьсны үрэвсэл

54. Жирэмсний эхний 3 сард чанд авиан шинжилгээгээр ямар хүндрэлүүдийг оношлох вэ?
1. Өсөлтгүй жирэмслэлт
 2. Тулгарсан зулбалт
 3. Цулцан хураа
 4. Халдварлагдсан зулбалт
 5. Ургийн хөгжил баригдах хам шинж
55. Ихэс түрүүлэлтийг ихэвчлэн юу дагалддаг вэ?
1. Ихсийн нягт бэхлэлт
 2. Ихсийн шигдэж ургах
 3. Цус багадалт
 4. Ургийн буруу байрлал
 5. Ургийн архаг бүтэлт
56. Хэвийн байрласан ихэс хугацаанаас өмнө ховхрох үеийн эмнэл зүйн шинж
1. Ургийн хямрал
 2. Хэвлийгээр хүчтэй өвдөх
 3. Умайн булчингийн чангарал
 4. Даралт буурах
 5. Судасны цохилт олшрох
57. Умайн гаднах жирэмсэн үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг нэрлэнэ үү?
1. Гуурсан хоолойд мэс засал хийлгэх
 2. Үргүйдэл
 3. Урд нь умайн гаднах жирэмсэн болж байсан
 4. Умайд ерөндөгтэй
 5. Дааврын хавсарсан бэлдмэл хэрэглэж байсан
58. Ихэс түрүүлэх шалтгааныг нэрлэнэ үү?
1. Умайн салст бүрхүүлийн хатингаршил
 2. Үр хөндөлт
 3. Умайн булчингийн хоргүй хавдар
 4. Бэлэг эрхтний дутуу хөгжил
 5. Бага аарцгийн хөндийн цусны зогсонгишил
59. Төрсний дараах цус алдалтанд хүргэх эрсдэлт хүчин зүйлсийг тэмдэглэнэ үү?
1. Умайн хана хэт сунасан
 2. Жирэмсний хүнд хэлбэрийн гестоз
 3. Түргэн төрөлт
 4. Өвчингүй төрүүлэх аргыг буруу хэрэглэх
 5. Мэдрэл, шингэний зохицуулалтын хямрал
60. Жирэмсэн үед умайг хэвийн байрлалд байлгахад гол үүрэгтэй холбоосыг нэрлэнэ үү?
1. Lig. suspensorium

2. Lig. Teres uteri
 3. Lig. Sacrospinale
 4. Lig. Sacrouterina
 5. Lig. Ovaripropundum
61. Эх барихын практикт плазмофорезийн эмчилгээ хийх заалтыг тэмдэглэнэ үү?
1. Үжил халдвар
 2. Экзотоксиний хордлого
 3. Анафилаксийн дайрлага
 4. Зүрхний хурц дутагдал
 5. Амьсгалын хурц дутагдал
62. А-аминдэм жирэмсэн эмэгтэйн бие махбодод ямар нөлөө үзүүлдэг вэ?
1. Ургийн харааны нөсөө үүсч бий болоход нөлөөлнө.
 2. Ургийн өсөлтийн хэвийн нөхцлийг хангана.
 3. Ихэс үүсэх явцыг идэвхжүүлнэ.
 4. Жирэмсэн эхийн дархлаажилтанд эерэгээр нөлөөлнө.
 5. Жирэмсэн эхийг сүрьеэгийн халдвар авахаас сэргийлнэ.
63. Төмөр жирэмсэн эхэд ямар ач холбогдолтой болохыг нэрлэнэ үү?
1. Гемоглобин үүсэхэд оролцоно.
 2. Жирэмсэн эхийн дархлалыг сайжруулж идэвхжүүлнэ.
 3. Ургийн мэдрэлийн гуурс үүсэх, түүний хэвийн хөгжлийг хангана.
 4. Ургийн зүрхний гажиг үүсэхээс сэргийлнэ.
 5. Ихэс ховхролтоос сэргийлнэ.
64. Кальцийн эх, урагт үзүүлэх нөлөөг нэрлэнэ үү?
1. Ургийн шүд ба ясжилтанд эерэг нөлөө үзүүлнэ.
 2. Ургийн мэдрэлийн тогтолцоо хөгжихөд нөлөөлнө.
 3. Ургийн зүрхний хэвийн үйл ажиллагааг хангана.
 4. Ургийн бөөрний эмгэг үүсэхээс сэргийлнэ.
 5. Умайн булчингийн хөгжилд нөлөөлнө .
65. Жирэмсэн эмэгтэйд магни ямар ач холбогдолтой болохыг нэрлэнэ үү?
1. Мэдрэл булчингийн дамжуулах процессыг зохицуулахад оролцоно.
 2. Ясжилтийн солилцоонд эерэг нөлөө үзүүлнэ
 3. Ферментүүдийг идэвхжүүлэх үйл ажиллагаанд оролцоно
 4. Жирэмсэн эхийн стрессийг багасгах нөлөө үзүүлнэ
 5. Жирэмсэн эхэд цус багадалт үүсэх эрсдлийг бууруулна
66. Жирэмсэн эмэгтэйд зэс дутагдахад ямар эмгэг үүсч болохыг заана уу?
1. Жирэмсний хожуу хордлого үүснэ.
 2. Төмрийн шимэгдэлт алдагдана.
 3. Ургийн бөөрний үйл ажиллагаа алдагдана.
 4. Ургийн тархины хэвийн өсөлт алдагдана.
 5. Хүйн гаж хөгжил үүсэх эрсдэл нэмэгдэнэ.

67. Жирэмсэн эхэд В-аминдэм ямар нөлөө үзүүлэх вэ?
1. Эрт үеийн гестоз үүсэхээс сэргийлнэ.
 2. Жирэмсэн эмэгтэйн арьсны уян хатан чанарт нөлөөлнө.
 3. Мэдрэлийн гуурсны гажиг үүсэхээс сэргийлнэ.
 4. Зүрхний булчингийн агших үйл ажиллагааг идэвхжүүлэнэ.
 5. Цус төлжүүлэх үйлчилгээ үзүүлнэ.
68. Жирэмсэн эхэд Д аминдэмийн үйлчилгээг нэрлэнэ үү ?
1. Фосфор, кальцийн тэнцвэрийг хангана
 2. Ургийн араг ясны хөгжилд нөлөөлнө
 3. Нярайд рахит үүсэхээс урьдчилан сэргийлнэ
 4. Ургийн амьсгалын тогтолцооны хөгжилд нөлөөлнө
 5. Урагт уруул, тагнайн сэтэрхий үүсэхээс сэргийлнэ
69. Жирэмсэн эмэгтэйд В₁₂-аминдэм ямар нөлөө үзүүлэх вэ?
1. Цусанд гемоглобин үүсэхэд оролцоно
 2. Фолийн хүчлийн зохицуулгад оролцоно
 3. Уургийн солилцоонд оролцоно.
 4. Нүүрс, усны солилцоог зохицуулна.
 5. Өөх тосны солилцоог зохицуулна. E
70. Ямар үед Альфа фетопротейны түвшин өндөр байж болох вэ?
1. Ихэр жирэмсэн
 2. Өсөлтгүй жирэмсэн
 3. Ургийн хүйн эвэрхий
 4. Синдром Тернера
 5. Ургийн өсөлт баригдах
71. Ураг орчмын шингэн бага байхад ямар гаж хөгжил илүүтэй тохиолдох вэ?
1. Анэнцефали
 2. Гидроцефали
 3. Омфалоцеле
 4. Шээс ялгаруулах замын гажиг
 5. Уушгины гипоплазия
72. Хэт авиан шинжилгээнд ихэс зузаан бол ямар эмгэгийг сэжиглэх вэ?
1. Тамхи таталт
 2. Чихрийн шижин
 3. Гаж хөгжил
 4. Тэмбүү
 5. ХДХВ-ийн халдвар
73. Тамхи татах нь жирэмслэлтэнд яаж нөлөөлөх вэ?
1. Дутуу төрөлт
 2. Ураг орчмын шингэн эрт гарах
 3. Ихэс ховхрох

4. Ургийн гаж хөгжил
 5. Ургийн шингэн ихдэх
74. Цусанд Альфафетопротейн бага байх нь урагт ямар эмгэг байгааг илтгэх вэ?
1. Омфалоцеле
 2. Дауны хам шинж
 3. Ихэс ховхролт
 4. Трисоми
 5. Ураг амьгүй болох эрсдэлтэй
75. Чихрийн шижинтэй дараах тохиолдолд жирэмслэлтийг үргэлжүүлэхэд аль нь эрсдэл өндөртэй вэ?
1. Гэр бүлийн хүмүүс хоёулаа шижинтэй
 2. Шижин, сүрьеетэй хавсарсан
 3. Шижингийн хүнд хэлбэртэй
 4. Шижин, ревматизмтай хавсарсан
 5. Глюкозын хэмжээ цусанд >8 ммол/л
76. Умайн булчингийн агшилтыг сулруулах эмийн бодисуудыг тэмдэглэнэ үү?
1. Сульфат магни
 2. Ритодрин
 3. Тербуталин
 4. Этанол
 5. Индометацин
77. Ураг орчмын шингэн гараад удсан, окситоцин хийж байна, Умайн хүзүүний нээлт 6 см, УЗЦ удааширсан, базлат 90 сек –д нэг удаа бол эхлээд авах арга хэмжээг нэрлэнэ үү?
1. Эхийг унтуулна
 2. Окситоциныг зогсооно
 3. Кесар хагалгаа
 4. Тербуталин тарина
 5. Умайн дотор даралтыг хэмжинэ
78. Дутуу төрөлтөнд хүргэж болох эрсдлийг нэрлэнэ үү?
1. Өдөрт 10 түүнээс олон ширхэг тамхи татдаг
 2. Ихэр жирэмсэн
 3. Жирэмсний явцад бөөрний тэвшинцрийн үрэвсэл сэдэрсэн
 4. Умайн бүтцийн өөрчлөлт оношлогдсон
 5. Олон төрсөн
79. ЭМС-ын 190-р тушаалд зааснаар “Эхийн амь насанд заналхийлсэн ноцтой хүндрэл:
1. Манас таталт
 2. Цус алдалтын болон бусад дайрлага
 3. Умайн урагдал, умайн урвал

4. Умайн гадуурхи жирэмсэн
 5. Зүрх судасны эмгэг жирэмсэнтэй хавсрах
80. Жирэмсний хүндрэл, эхийн өвчлөл эндэгдлийг шинжих дараах аргууд байдаг
1. Олон нийтэд суурилсан эхийн эндэгдлийн судалгаа
 2. Байгуулгад суурилсан эхийн эндэгдлийн судалгаа
 3. Эхийн эндэгдлийн итгэмжит лавлагаа
 4. Эхийн ноцтой хүндрэлийн судалгаа
 5. Эмнэлзүйн шалгалт
81. Эхийн эндэгдэл, өвчлөлийн тандалт хийх үндсэн мөчлөгүүдийг сонгоно уу?
1. Тохиолдлыг тодорхойлох
 2. Мэдээ цуглуулах
 3. Үр дүнд анализ хийх
 4. Зөвлөмж гаргах
 5. Үнэлгээ хийх
82. Эхийн эндэгдлийн итгэмжит лавлагааны арга нь:
1. Их британи улсын туршлага
 2. Эхийн эндэгдлийг тайлан
 3. Нэр, хаягийг нууцалж хийдэг арга
 4. Малайзи улсын туршлага
 5. Жил тутамд хийж тайлан бичихэд ашиглана
83. Ноцтой хүндрэлийг судлахын давуу тал
1. Тооцож бүртгэхэд хялбар байдаг
 2. Эхийн эндэгдлийг бодвол илүү олон тохиолддог
 3. Эх өөрөө болсон явдал түүхийг ярих боломжтой
 4. Тусламж үзүүлэгч нарыг заналхийлэх буруутгах нь бага байдаг
 5. Нэр, хаягийг нууцалсан байдагаараа илүү
84. Жирэмсний хүндрэл, эхийн өвчлөл эндэгдлийг шинжих аргын онцлог нь:
1. Эх яагаад эндэв гэдгийг тогтоох
 2. Хувь хүн болон байгууллагад занал хийхгүй байх
 3. Эх яавал эндэхгүй, хүндрэхгүй байх байсан гэдгийг тогтоох
 4. Эхийн эндэгдлийн тоо хэрхэн нэмэгдэж, буурч байгааг үнэлэх
 5. Хаана илүү их эхийн хүндрэл, эндэгдэл гарч буйг илрүүлэх
85. Мөр тээглэх үеийн тусламжид хамаарахыг нэрлэнэ үү?
1. Хярзан сэтлэх
 2. Мак Робертсийн гардан туслах арга
 3. Завенеллийн гардан тусламж
 4. Гар чөлөөлөх сонгомол арга
 5. Кесар мэс засал хийнэ
86. Амниоцентез хийхэд дараах зарчмыг баримтлана.
1. Жирэмсний 15-20 долоо хоног хамгийн тохиромжтой хугацаа.

2. 18-22G хэмжээний зүү ашиглана.
 3. УОШ-ээс 10-20мл-ийг соруулан авна.
 4. Хэт авиан шинжилгээний хяналтан дор хийнэ.
 5. Арын хүнхрээгээг хатгалт хийнэ .
87. Ихэр жирэмсэн үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг нэрлэнэ үү?
1. Эхийн талыг удамших магадлал эцгийн талаас илүү
 2. Том биетэй өндөр эмэгтэйчүүд
 3. Гонадотропин сэдээлт хийсний үр дүнд жирэмсэлсэн
 4. Кломифены сэдээлт хийлгэсний үр дүнд жирэмсэлсэн
 5. Залуу эхчүүдэд ихэр жирэмслэлт илүү тохиолдоно
88. Нярайн сэхээн амьдруулалтын хамгийн үр дүнтэй алхмыг тэмдэглэнэ үү?.
1. Хүүхдийг цочроох
 2. Амьсгалын дээд замаас соруулах
 3. Зүрхэнд шууд бус иллэг хийх
 4. Уушгийг амьсгалуулах
 5. Эмийн бодис хэрэглэх
89. Бетамиметикийг дутуу төрөхөөр завдах үед умайн агчил тавиулахаар хэрэглэдэг. Эх ямар өвчтэй үед хэрэглэж болохгүй вэ?
1. Зүрхний хэм алдагдалтай
 2. Бамбай булчирхайн эмгэгтэй
 3. Чихрийн шижинтэй
 4. Уушгины хатгалгаатай
 5. Умайд сорвитой
90. Мизопростол хэрэглэж болохгүй эсрэг заалтыг тэмдэглэнэ үү?
1. Ураг хэт том
 2. Олон төрсөн эх, умайд олон төрлийн ажилбар хийлгэсэн
 3. Үтрээнээс цус гарч байгаа
 4. КТГ-н шинжилгээгээр ургийн дистресстэй
 5. Ихэр жирэмсэн
91. Мизопростол хэрэглэх нийтлэг шаардлага:
1. Ураг жирэмсний 38 долоо хоногоос илүү хугацаагаар тээгдсэн байх
 2. Ургийн байрлал түрүүлсэн хэсгийг бүрэн тогтоосон
 3. Үтрээнээс цус гараагүй
 4. Ургийн өгзөг түрүүлсэн
 5. Ураг бүтэлттэй
92. Ямар тохиолдлыг вакуум таталт амжилтгүй боллоо гэж үзэх вэ?
1. Таталт хийснээс хойш 30 хором болоход ураг төрөхгүй байх
 2. Хамгийн дээд хасах даралтаар, зөв чиглэлээр татаж байхад аяга толгойноос 2 удаа мултарсан
 3. 3 удаагийн таталтаар ургийн толгой доошлоогүй

4. Ургийн толгойд хавдар үүссэн
 5. Таталтын үед базлалтын хүч нэмэгдвэл
93. Вакуумын аягыг ургийн толгойн ямар хэсэгт тавих вэ?
1. Бага зулайгаас урагш 3 см зайд
 2. Ургийн толгойн суман заадсын дагуу дунд шугамаар
 3. Аяганы төв нь толгойн хөтлөх цэг дээр
 4. Аягыг аль болох урагш байрлуулах
 5. Вакуум аяганы төв нь бөхийх цэгээс 3 см урагш байрлуулна.
94. HELLP хам шинжийн үед илрэх шинжийг нэрлэнэ үү ?
1. Элэгний үйл ажиллагаа алдагдана
 2. Цусны бүлэгнэх тонгтолцоо алдагдана
 3. Бөөрний үйл ажиллагаа алдагдана
 4. Зүрхний үйл ажиллагаа алдагдана .
 5. Тархи мэдрэлийн үйл ажиллагаа алдагдана
95. Дутуу тээлтэй ургийн шингэн цагаас урьдаж гарах үед үзүүлэх тусламж:
1. 6-8 цаг хүлээгээд төрөлт эхлэхгүй бол мизопростолоор сэдээнэ
 2. Ариун толины үзлэг хийнэ
 3. Үтрээний үзлэг хийж умайн хүзүүний байдлыг үнэлнэ
 4. Антибиотик 7 хоног хэрэглэнэ
 5. Төрөлтийг яаралтай шийднэ
96. Жирэмсэн үед умай урагдах шалтгааныг нэрлэнэ үү?
1. Эмнэл зүйн уйтан аарцаг
 2. Бүтцийн уйтан аарцаг
 3. Том ураг
 4. Кесар мэс заслын сорви
 5. Ургийн буруу байрлал
97. Эпидураль мэдээ алдуулалтын хүндрэлийг тэмдэглэнэ үү?
1. Даралт буурах
 2. Ихсийн цусны эргэлт хямрах
 3. Цусны эргэлт удаашрана
 4. Хураагуур судсанд цус тогтонгошино.
 5. Зүрхний шахалт нэмэгдэнэ.
98. Умайн гаднах жирэмсэн үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг тэмдэглэнэ үү?
1. Хламидын халдвар
 2. Зулбаж, үр хөндүүлж байсан
 3. Гуурсан хоолойд мэс засал хийлгэж байсан
 4. Цулцан хураагаар өвчилж байсан
 5. Дааврын хавсарсан бэлдмэл удаан хэрэглэсэн
99. Ихэс эмгэгээр бэхлэгдэх шалтгааныг нэрлэнэ үү?
1. Ихэс түрүүлэлт

2. Умайн үрэвсэл
 3. Өмнө нь умайд кесар хагалгаа хийлгэж байсан
 4. Умайг хусаж цэвэрлүүлж байсан
 5. Дауны хам шинжтэй хүүхэд төрүлж бхайсан
137. Насжилт холбоотой эстроген багадлын суурин дээр липидийн солилцоо болон зүрх судасны тогтолцооны үйл ажиллагааны түвшинд гарч болох өөрчлөлт нь:
 1. БНЛ –ийн хэмжээ ихэснэ
 2. Захын судасны эсэргүүцэл ихэсч судас нарийсна
 3. триглицеридүүдийн түвшин ихэснэ
 4. Зүрхний ишеми үүсэх эрсдэл буурна
 5. Нийт холестеролын хэмжээ буурна
140. Цэвэршилтийн явцад Куперманы үзүүлэлтээр дүгнэх хам шинжүүд:
 1. Мэдрэл-ургал мэдрэлийн хямралууд
 2. Бодисын солилцооны өөрчлөлтүүд
 3. Шээс бэлгийн замын хямралууд
 4. Дотоод шүүрлийн өөрчлөлтүүд
 5. Сэтгэц- сэтгэл хөдлөлийн хямралууд
141. Цэвэршилтийн үеийн бодисын солилцооны хямарлыг илэрхийлэх шинжүүдэд:
 1. Артерийн даралт $> 130/85$

2. БТ/ГТ – ийн үзүүлэлт $>0,85$
 3. Өлөн үеийн сахарын түвшин цусанд > 110 мг/ дл
 4. Хэвлийн тойрог > 89 см
 5. Прогестероны түвшин > 80 пмоль/л
142. ГнРД-ын адил эмүүдийн үйлчлэлийн онцлог нь:
1. Дотоодын ГнРД –аас харьцангуй удаан, идэвхжил өндөртэй үйлчилнэ.
 2. Эмчилгээний эхэн үед өнчин тархины ажиллагааг идэвхижүүлнэ
 3. ФСД, ЛД, Прогестерон ба тестостероны цусанд тодорхойлогдох түвшинг бууруулна
 4. E_2 –ын түвшинг < 100 пмоль/л болгоно
 5. Умайн салстад явагдах зузаарлын үйл ажиллагааг сэдээж эрчимжүүлнэ
143. Дааврын хамааралтай эмгэгүүдийг ГнРД –ын адил эмүүдээр эмчлэх үеийн “халхавч” эмчилгээнд хамаарагдах нь:
1. Эстрадиол валерат 1 мг, норэтиндрон 0,35 мг –аар 3-4 сар уулга
 2. Премарин 0,3 МПА 5 мг- аар хавсруулан 3-4 сар хэрэглэх
 3. Карбонат кальци хоногт 500 мг –аар
 4. Бага тунгийн жирэмслэхээс хамгаалах хавсарсан дааврын эмүүд
 5. Тиболон 2,5 мг –аар 3-4 сар
144. Мирена –г хэрэглэж болохгүй, эсрэг заалтад:
1. Элэгний хурц үрэвсэл
 2. Голомтот мигрени төст шинжүүд
 3. БЖҮ нь > 30 , тарган эмэгтэйчүүд
 4. Ээнэгшлээ алдсан элэгний хатуурал
 5. Чихрийн шижин өвчтэй
145. 30 настай эмэгтэй. Үргүйдлийн учир шинжилгээ хийлгэсэн. Өндгөвчийн үйл ажиллагаа ба нөхрийн үрийн шингэний шинжилгээнд өөрчлөлтгүй. Гистсеросальфингографийн шинжилгээнд бодис үрийн хоолойгоор нэвтэрч хэвлийд хаягдахгүй.Цаашид хийх шинжилгээ, үзүүлэх тусламжийг сонгоно уу?
1. Үрийн хоолойд нөхөн сэргээх мэс засал хийнэ
 2. хэвлийн дурангийн онош, эмчилгээ хийнэ
 3. Умайн хүзүүнд үр нийлүүлнэ (инсеминаци)
 4. Хэвлийн гадна үр тогтоож, үр хөврөлийг умайд суулгана (IVF)
 5. Умайд үр нийлүүлнэ
146. 40 настай эмэгтэй. БЮ хэмжээтэй, олон хоног үргэлжилдэг. Эмэгтэйчүүдийн үзлэг шинжилгээнд өөрчлөлтгүй. Эдийн шинжилгээнд умайн салстын булчирхайлаг хэт зузаарал илэрсэн. Эмчилгээг сонгоно уу?

1. Кломифен цитратаар эм бэлгийн эсийн гадагшлалтыг сэдээж, БЮМ – ийг тогтмолжуулна
 2. БЮМ –ийн 16-25 дахь хоногт прогестаген 3-6 сар дараалан уулгана
 3. Цэлмэнгийн гонадотропин 10000 нэгжээр БЮМ –ийн 14 дэх хоногт, сар бүр тарина
 4. БЮМ –ийн 5-25 дахь хоногт прогестаген эмчилгээ 3-6 сар дараалан уулгана
 5. БЮМ -ийн 22 дахь хоногт прогестрон 200 мг –аар булчинд тарина
147. 26 настай, үргүйдэлтэй гэр бүл БЮМ нь тогтмол. БЮМ –ийн 22 дахь хоногт прогестрон цусанд 24 МЕ/л, HSG –ийн шинжилгээнд гуурсан хоолойн туулгац хэвийн. Нөхрийн үрийн шингэний шинжилгээний үзүүлэлтээр азоосперми тодорхойлогдсон. Үзүүлэх тусламж нь:
1. Андроген даавраар (тестостерон, местеролон) эмчилнэ
 2. Нөхрийн нөхөн үржихүйн замаас соруулж авсан эр бэлгийн эсийг эм бэлгийн эсд шууд тарьж үр тогтооно (ICSI)
 3. Донор үрийн шингэнээс умайд зориудаар үр нийлүүлнэ
 4. Нөхрийн үрийн шингэнээс умайд зориудаар үр суулгана
 5. Нөхрийг нь хүний цэлмэнгийн гонадотропиноор (1000-1500 ед –ээр долоо хоногт 2-3 удаа тарьж) 2-3 сар эмчилнэ
148. Эмэгтэй Д. 20 настай. БЮ нь 4 сар саатсан. Биеийн өндөр 152 см, АД 110/70 мм. МУБӨ. ФСД 4,1 МЕ/л, ЛД 2,5 МЕ/л, пролактин 182 нг/мл, Цаашид нэмж хийвэл зохих шинжилгээг сонгоно уу?
1. Тархины рентген шинжилгээ, СТ, МРТ
 2. Бамбай булчирхайн хэт авиан шинжилгээ
 3. Цусанд бамбай сэдээх (TSH) тодорхойлох
 4. Бэлгийн дааврууд (E₂, P₄) цусанд тодорхойлох
 5. Хромосомын шинжилгээ
149. Цэвэршилтийн үед хамаарагдах зарим хүчин зүйлс нь:
1. Өндгөвчийн фолликулуудын сөнөрөл
 2. Өндгөвчнөөс ялгарах бэлгийн даавруудын хэмжээ багасах
 3. Өнчин тархи-харааны товгорын эстрогеныг мэдрэх босго мэдрэмж өндөрсөх
 4. Өндгөвчинд нийлэгжих андрогены хэмжээ буурах
 5. Харааны товгороос ялгарах РнГД –ын хэмжээ буурах
150. Өндгөвчинд фолликулийн сөнөрөл хэдийд хамгийн ихээр явагддаг болохыг хэлнэ үү?
1. Нярайн үеэс бэлгийн бойжилт эхлэх хүртэл
 2. Хэвлий дэх үр хөврөл ургийн хөгжлийн 10 долоо хоног хүртэлхи хугацаанд
 3. Ургийн хөгжлийн 10-20 долоо хоногийн хугацаанд

4. Ургийн хөгжлийн 20 долоо хоногтойгоос төрөх хүртэлхи хугацаанд
 5. Бэлгийн бойжилт эхэлснээс цэвэрших хүртэлхи хугацаанд
151. ГнРД –ын адил (агонист) эмүүд хэрэглэн эмчилж болох эмгэгүүд нь:
1. Эндометриоз
 2. Умайн хоргүй хавдар
 3. Умайн салстын хэт зузаарал
 4. Умайн гаралтай биений юмгүйдэл
 5. Өндгөвчийн анхдагч дутагдал
152. Биений юмгүйдлийн үед прогестроны сорил сөрөг байх нь:
1. Гонадотропин даавруудын дутагдлыг илэрхийлнэ
 2. Өндгөвчийн гүнзгий дутагдлыг заана
 3. ГнРД –ын дутагдлыг илэрхийлнэ
 4. Умайн шалтгааныг заана
 5. Өндгөвчийн хөнгөн дутагдлыг заана
153. Прогестроны сорил эерэг байх нь:
1. Гонадотропин даавруудын дутагдлыг илэрхийлнэ
 2. Өндгөвчийн гүнзгий дутагдлыг заана
 3. ГнРД –ын дутагдлыг илэрхийлнэ
 4. Өндгөвчийн хөнгөн дутагдлыг заана
 5. Умайн шалтгааныг заана
154. Эрших хэлбэрийн төрөлхийн адрено-гениталь хам шинж үүсэх шалтгаан нь:
1. 3β – ол дегидрогеназын дутагдлаар
 2. Их биеийн хромосомын рецессив генээр дамжин удамших нөхцөлтэй
 3. 11β – гидроксилазын дутагдлаар
 4. 21- гидроксилазын дутагдлаар
 5. 17 – гидроксилазын дутагдлаар
155. Умайн салстын хэт зузаарлыг аблаци хийж эмчлэх аргын эсрэг заалт:
1. Умайн хөндийн хэлбэр алдагдсан
 2. Умайн хөндий өргөсч томорсон
 3. 2 удаа төрсөн, дахин төрөх төлөвлөгөөтэй байгаа тохиолдолд
 4. Умайн салстын хэвийн биш хэт зузаарал
 5. Умайн салст үрэвссэн
156. Леймиомын зангилаа авах мэс заслын дараа дахилтаас сэргийлэх зорилгоор хэрэглэх эмчилгээг сонгоно уу? .
1. Спиринолактон 25 мг-аар хоногт 1 удаа, 1-2 сар уух
 2. Мифепристоньг хоногт 50 мг – аар, 4 сар уух
 3. Ципротерон ацетат 25 мг-аар БЮМ – ийн 5 -15 дахь хоногт, 3 сар уух
 4. Лейпрорелин 3,75 мг-аар, 28 хоногт 1 удаа, 6 сар

5. Бага тунгийн жирэмслэхээс хамгаалах зориулалтын хавсарсан дааврын эмийг 3 – 4 сар уух
157. Дараах эмгэгүүдээс умайн үйл ажиллагааны цус алдалтанд хүргэж болохыг нь заана уу
1. Тромбоцитопени
 2. Полип эндометрия
 3. Цулцан хураа
 4. ӨОУХШ
 5. Лейкоз
158. Нянгийн гаралтай үтрээний үрэвслийн тохирох шинжийг нэрлэнэ үү
1. рН 5,0
 2. Түлхүүр эс
 3. КОН +
 4. Метронидазолд эмчилгээнд үр дүнтэй
 5. Илэрхий үрэвслийн шинжтэй
159. Дараах тохиолдлоос өндгөн эс гадигшилсныг илтгэх шинжийг нэрлэнэ үү?
1. Жирэмслэх
 2. Суурин халуун нэмэгдэх
 3. Прогестерон дааврын хэмжээ нэмэгдэх
 4. Умайн салстанд шүүрлийн үйл ажиллагаа явагдах
 5. Биений юм ирэх
160. Эндометриоз үүсэх эмгэг жамыг нэрлэнэ үү?
1. Лимфийн тархалтаар
 2. Үр хөврөлийн онолоор
 3. Биений юм гуурсан хоолойгоор буцаж орох
 4. Дархлааны дутмагшил
 5. Умайн салстын хэт зузаарал
161. Умайн салстын өмөн үүсэхэд нөлөөлөх эрсдэлт хүчин зүйлсийг нэрлэнэ үү?
1. АД ихсэлт
 2. Архаг ановуляци
 3. Чихрийн шижин
 4. Удамдаа өндгөвч болон хөхний хавдраар өвөдж байсан өгүүлэмжтэй
 5. Удаан хугацаагаар ДМПА хэрэглэсэн
162. Шиханы хам шинжийн үед шинжилгээнд илрэх үзүүлэлтийг нэрлэнэ үү?
1. ФСД ихэссэн
 2. ТСД буурсан
 3. Хошногоны суурин халуун 2 мөчлөгтэй байна
 4. Эстрадиол буурсан
 5. Кортизол өөрчлөлтгүй

- 163.25 настай эмэгтэй 6 сар биений юм ирээгүй, жирэмсний сорил сөрөг, өндгөвчийн олон уйланхайжих эмэгтэй гэж оношлогдож байсан. Энэ эмгэгт тохирох байдлыг нэрлэнэ үү?
1. Үтрээ умайн хатингарал
 2. Таргалалт
 3. Яс сийрэгжилт
 4. Умайн салстын хэт зузаарал
 5. Гипогликеми
164. Охидын умайн үйл ажиллагааны цус алдалтын эмнэлзүйн шинжид хамаарагдана:
1. Толгой хэсэгчилж өвдөнө
 2. Ядарна
 3. Судасны цохилт цөөрнө
 4. Арьс, салст цайвар өнгөтэй болно
 5. Цусны гемоглобины хэмжээ ихэснэ
165. Биений юм үзээгүй охидод бэлгийн замаас цус гарахад зайлшгүй эмнэлгийн тусламж шаардлагатай тохиолдол
1. Гэмтэл
 2. Эмийн бодисын үйлчлэл
 3. Хүчирхийлэл
 4. Нярай охидод төрсний дараах 3-5 хоногт бэлгийн замаас бага хэмжээний цус гарах
 5. Менархе
166. АГС –ын тодорхойлолтод хамрагдах нь:
1. Охидод хуурамч, эрэгтэй байдлаар бэлгийн бойжилт эрт явагддаг эмгэг
 2. Бэлгийн хромосомоор дамжих рецессив өвчин
 3. Эцэг, эхийн нэг нь гетерозигот тээгч бол АГС-тэй хүүхэд төрөх магадлал 25% байна
 4. Кориотип 46 ХУ
 5. Тохиолдох давтамж нь 1:5000-15000
167. Аденогениталь хамшинжийн эмчилгээнд:
1. Биеийн өсөлтийг хангах, витамин эмчилгээ
 2. Андрогений үйлчлэлийг саатуулах эмүүд хэрэглэнэ
 3. Глюкокортикоид эмчилгээ хийнэ
 4. Андростендиалын эмүүд хэрэглэнэ
 5. Бодисын солилцоог хэвийн байлгах эмчилгээ хийнэ
168. Аденогениталь хамшинжийн үед андрогений үйлчлэлээс хамаарч илрэх шинж нь:
1. Дотор бэлэг эрхтэн хэвийн хөгжинө

2. Хэлүү томорно
 3. Хөхний хөгжил хэвийн байна
 4. Бэлгийн сүв хаагдана
 5. Үсжилт эрэгтэй байдлаар илэрч болно
169. Охидод анх биений юм үзэхэд нөлөөлөх гол хүчин зүйлд:
1. Өндгөвчинд эм бэлгийн эс боловсорч гадагшилснаас
 2. Биеийн ерөнхий хөгжил, жин хангалттай үед
 3. Сэтгэл зүйн таатай нөхцөл бүрэлдсэн тохиолдолд
 4. Бэлгийн бойжилтын насанд хүрсэн бол
 5. Эрхтэн тогтолцооны өвчингүй
170. Өндгөвчийн анхдагч дутагдал Шерешевский-Тернерийн хамшинжийн оношлогоонд хамаарагдах нь:
1. Биеийн жин
 2. Хромосомын шинжилгээ
 3. Цусанд тестостерон тодорхойлох
 4. Бэлгийн хроматин тодорхойлох
 5. ДНХ гинжин урвалын шинжилгээ
171. Өндгөвчийн анхдагч дутагдлын эмчилгээнд хамаарагдах нь:
1. Глюкокортикоид эмчилгээ
 2. Андрогений үйлчлэлийг саатуулах эмчилгээ
 3. Витамин эмчилгээ
 4. Эстроген эмчилгээ
 5. Шинж тэмдгийн эмчилгээ хийж, биеийн ерөнхий өсөлтийг хангана
172. Эмгэг цэвэршилтэнд хамаарагдах нь:
1. 48-50 насанд цэвэрших
 2. 40 хүртэл насанд цэвэрших
 3. 40-45 насанд цэвэрших
 4. <56 насанд цэвэрших
 5. 45-48 насанд цэвэрших
173. Цэвэршилтийн явцад орлуулах журмаар даавар эмчилгээ хийх заалтад хамаарагдах нь:
1. Халуу оргиж хөлрөх
 2. Шээс задгайрах
 3. Ясны сийрэгжилт илэрхий явагдах
 4. Артерийн даралт огцом ихсэх
 5. 40 хүрээгүй үзвэршсэн боловч зовиургүй
174. Эндометриозын үед илрэх шинжийг нэрлэнэ үү?
1. Бага аарцгийн өвдөлт
 2. Үргүйдэл
 3. Умайн араар өвдөлттэй зангилаанууд тэмтрэгдэх

4. Таргалах
 5. Дотор муухай оргих
175. Киари-Фромеллийн хам шинжийн үед илрэх шинжийг нэрлэнэ үү?
1. Үргүйдэл
 2. Биений юмгүйдэл
 3. Ясны сийрэгжилт
 4. Хөхнөөс сүү гарах
 5. Хараа өөрчлөгдөх
176. Умайн хоргүй хавдар үүсэх шалтгаан
1. Стресс
 2. Олон удаа үр хөндүүлэх
 3. Тамхи татах
 4. Эстроген дааврын солилцоо алдагдах
 5. Мансууруулах бодис хэрэглэх
177. Биений юмны өмнөх хам шинжийн үед дараах эмчилгээний аргын алыг нь сонгож хэрэглэх вэ?
1. Давс хязгаарлах
 2. Жирэмснээс хамгаалах хавсарсан дааврын бэлдмэл хэрэглэх
 3. Витамин В6
 4. Индометацин
 5. Тайвшруулах эмчилгээ
178. Тестикулийн феминизаци нь
1. Фенотипийн хувьд эрэгтэй
 2. Фенотипийн хувьд эмэгтэй
 3. Фенотипийн хувьд манин
 4. Генотипийн хувьд 46 ХУ
 5. Генотипийн хувьд 46 ХХ
179. БЮ ирэхэд цус гарах шинж нь юугаас хамааралтай болохыг нэрлэнэ үү
1. Умайн салст ховхорсоноос
 2. Умайд простогландины хэмжээ эрс нэмэгдсэнээс
 3. Эстроген дааврын хэмжээ эрс нэмэгдсэгээс
 4. Умайн артерийн судаснууд агшиснаас
 5. Умайн салст хэт хөвсийж зузаарсанаас
180. БЮ –ны зохицуулганд оролцох дааврыг нэрлэнэ үү
1. Окситоцин
 2. Серотонин
 3. Гиалуринидаза
 4. ГТД
 5. Простогландин
181. Прогестерон дааврын үүрэгийг нэрлэнэ үү

1. Ургийн хэвийн өсөлтийг хангах
 2. Умайн агшилтыгы сулруулах
 3. Умайн салстын шүүрлийг хангах
 4. Умайн салстын хөвсийлтийг саатуулах
 5. Хөхний булчирхайн хөгжлийг дэмжих
182. Үтрээний эсийн шинжилгээнд суурин орчмын болон суурин эс давамгайлсан байх нь юутай холбоотой вэ?
1. Прогестерон дааврын хэт дутагдалтай
 2. Эстроген дааврын дутмагшилтай
 3. Эстроген болон прогестерон дааврын дутагдал
 4. Цэвэршилт
 5. ЛД –ын дутагдал
183. ХГД –ын онцлог шинжийг нэрлэнэ үү?
1. Лангхансын эсээс үүсдэг
 2. Ихсийн трофобластаас үүсдэг
 3. ЛД –н үүргийг гүйцэтгэнэ
 4. Шар биеийн үүргийг гүйцэтгэнэ
 5. ФСГ дааврын үүргийг гүйцэтгэнэ
184. Киари- Фромеллийн хам шинжийн үед хэрэглэх эмийг нэрлэнэ үү?
1. Кломифен
 2. Эстроген
 3. Метилдофа
 4. Бромкриптин
 5. Прогестерон
185. Өндгөвчний олон уйланхайжих хам шинжийн эмгэг жамд хамаарагдахыг нь тэмдэглэнэ үү?
1. Андроген дааврын ихсэлт
 2. ФСД болон ЛД –ын өөрчлөлт
 3. Эстроген дааврын дутмагшил
 4. Эстроген дааврын ихсэлт
 5. Бөөрний дээд булчирхайн эмгэг өөрчлөлт
186. Өндгөвчний олон уйланхайжихын илрэлийг нэрлэнэ үү?
1. БЮ-ны мөчлөггүй цус алдалт
 2. Үргүйдэл
 3. 2 өндгөвч томрох
 4. БЮ-дэл
 5. Таргалалт
187. Өндгөвчний олон уйланхайжих хам шинжийн үед хэрэглэгдэх эмийг нэрлэнэ үү?
1. Метилдопа

2. Мизопростол
 3. Бромкриптин
 4. Кломифен цитрат
 5. Дексаметазон
188. Умайн хүзүүний хүнд хэлбэрийн гаж хувиралтай байхад
1. Суурин болон суурин орчмын эсүүд эвэршиж зузаарна
 2. Эсүүдийн цөм хромоор хэт будагдана
 3. Эсүүдийн эгнээт байдал алдагдана
 4. Гадаргуугийн эсүүдийн эвэрших шинж тод илэрнэ
 5. Олон үет хавтгай хучуурын 1/3 гэмтсэн байна
189. Эндометриоз нь:
1. Удамшлын хамааралтай эмгэг
 2. Дархлалын хамааралтай эмгэг
 3. Дааврын хамааралтай эмгэг
 4. Цус бүлэгнэх тогтолцооны хямралын эмгэг
 5. Бодисын солилцооны хямралын суурин дээр үүсдэг эмгэг
190. Эндометриоз үүсэх нь:
1. Умайн салстын архаг үрэвсэлд суурилна
 2. Умайн салстын эдийн зөөгдөлтөөр нөхцөлдөнө
 3. Өндгөвчийн ажиллагааны хэт сэдээгдэлтээр үүснэ
 4. Мезотелийн эсүүдийн хувирлаар үүснэ.
 5. Дааврын зохицуулга алдагдсанаас шалтгаална
191. Эндометриозын голомтын байршлаас хамаарахгүй нийтлэг илрэх эмнэлзүйн шинж нь:
1. Харин биений юмны дараа хэмжээ нь багасч хэвийн байдалд орно
 2. Эндометриозын голомттой эрхтэн хэмжээгээрээ томорно
 3. Мөчлөггүй цус алдалт байнга ажиглагдана
 4. Ихэнхидээ БЮМ-ийн хямралтай байна
 5. Аль ч насны эмэгтэйчүүдэд тохиолдож болно
192. Эндометриозын эмчилгээнд хэрэглэгдэж байгаа орчин үеийн эмүүд нь:
1. Гестринон 2,5 мг-аар 7 хоногт 2 удаа, 4-6 долоо хоног ууна
 2. Тиболон 2,5 мг-ыг релизинг гонадотропины адил эмүүдтэй хавсруулан хэрэглэх
 3. Даназол хоногт 200мг 2-4 удаа, бүгд 4-6 сар ууна
 4. Лизурид хоногт 0,1-0,2 мг-аар 3 удаа, 6 сар ууна
 5. Кинаголид 0,075-0,15 мг-аар өдөрт 1 удаа 4-6 сар ууна
193. Хөхний өмөнгийн зөв мэдээлэлийг нэрлэнэ үү?
1. Хөхний өмөнгийн 60% нь удамшлын шалтгаантай байна
 2. Ихэвчлэн 40-өөс дээш насны эмэгтэйчүүдэд илүү тохиолдоно

3. Хөхний өмөн үүсэхэд хоол ундны байдал нөлөөлөхгүй
 4. Хөхийг тэмтэрч үзэхэд том, хөдөлгөөнгүй, жигд биш гадаргуутай үүсвэр тодорхойлогдвол өмөнд сэжиглэн шинжилж болно
 5. Мастопати хөхний өмөнд шилжинэ
194. Хөхний өмөн үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлс:
1. Анх биений юм хожуу үзсэн
 2. ВРСА-1, ВРСА-2 ген тээгчид
 3. Эмэгтэйчүүд олон жирэмслэж байсан өгүүлэлтэй үед
 4. Биений юм хожуу насанд зогссон
 5. Хөхнөөс цайвар ялгарал гардаг бол
195. Мастопати нь:
1. Хөхний архаг үрэвслүүдэд суурилна
 2. Дааврын хамааралтай үүсэх хөхний эмгэг
 3. Цэвэршсэний дараах насны эмэгтэйчүүдэд харьцангуй илүү тохиолддог
 4. Хөхний үндсэн бүтэц-эдийн харьцаа эмгэг байдлаар алдагдахад үүсдэг
 5. Эмнэл зүйн тодорхой шинж тэмдэггүй явагдах нь элбэг
196. Жирэмслэхээс хамгаалах дааврын хавсарсан эмүүдийн үйлчлэх механизм нь:
1. Эм бэлгийн эсийн гадагшлалтыг саатуулна
 2. Умайн хүзүүний салиаг өтгөрүүлнэ
 3. Умайн гуурсан хоолойн хөдөлгөөний хэмнэлийг алдагдуулна
 4. Умайн салстад гликоген үүсэх процессыг багасгана
 5. Өндгөвчийн гонадотропинд мэдрэг байх чадвар өөрчлөгдөнө
197. Депо проверагийн үйлчлэх механизм нь:
1. Эм бэлгийн эсийн гадагшлалтыг саатуулна
 2. Умайн салстын зузаарлыг саатуулна
 3. Умайн хүзүүний салиаг өтгөрүүлнэ
 4. Өндгөвчийг гонадотропинд мэдрэг бус болгоно
 5. Фолликул сэдээх дааврыг саатуулна
198. Депо проверагийн эмчилгээний үйлчлэл нь:
1. Төмөр дутлын цус багадалт үүсэхийг багасгана
 2. Бага аарцгийн эрхтний үрэвсэл үүсэх эрсдэлийг бууруулна
 3. Эпилепси өвчтэй эмэгтэйчүүдэд уналтыг цөөрүүлнэ
 4. Эндометриозын илрэлийг багасгана
 5. Үтрээний мөөгөнцрийн давтамжыг багасгана
199. Зэс агуулсан ерөндөгийн үйлчлэх механизм нь:
1. Умайн салстад гадны биеийн урвал үзүүлнэ
 2. Эр бэлгийн эсэд хордуулах нөлөө үзүүлнэ

3. Үр тогтохоос сэргийлнэ
 4. Үр тогтсон өндгөн эс салстад шигдэн суухаас сэргийлнэ
 5. Өндгөвчийн үйл ажиллагаанд нөлөөлнө
200. Биений юм удаан үргэлжилж байгаа үед цус тогтоох зорилгоор хийж болох эмчилгээг заана уу.
1. Алендрониевая кислота хоногт 10 мг-аар уух
 2. Е-Аминокапроновая кислота хоногт 3 г-аар 4 удаа уух
 3. Силест (КОК) өдөрт 1 таб-аар 1 удаа уух
 4. Данол хоногт 200 мг-аар 2 удаа уух
 5. Леупролид ацетат 0,5-аар хоногт 1 удаа тарих
201. Жирэмслэхээс хамгаалах дааврын эмүүдийг хэрэглэж болохгүй эсрэг заалтууд нь:
1. Судаслагийн тогтолцооны өвчнүүд, тромбоэмболи
 2. Чихрийн шижин
 3. Тамхи татдаг эмэгтэйчүүд
 4. Жирэмсэн эмэгтэйчүүд
 5. Зүрхний гажиг
202. Жирэмслэхээс хамгаалах дааврын хавсарсан эмийн эерэг нөлөө нь:
1. Биений юмны үед гарах цусны хэмжээг багасгана
 2. БЮМ-ийг тогтмолжуулна
 3. Умайн салстын өмөнгөөс сэргийлнэ
 4. Прогестагенүүд нь эстрогены рецептор үүсэлтийг сэдээнэ
 5. Умайн хоргүй хавдрыг арилгана
203. Өндгөвчийн хатуурал-уйланхайжлын хам шинжийн үед үед авах арга хэмжээ:
1. Биеийн ил хэсгийн үсийг цайруулах зорилгоор устөрөгчийн хэт ислийг хэрэглэж болно
 2. Эмээр үсний ургалтыг бүр мөсөн зогсоох боломжтой
 3. Үсний хэт ургалтыг багасгахад жирэмслэхээс хамгаалах хавсарсан дааврын эмүүд туслана
 4. Жирэмслэхээс хамгаалах дааврын эмийг БЖИ ≥ 30 үед хэрэглэхэд зохимжтой
 5. Ципротерон ацетат нь эстрогены адил үйлчилгээ үзүүлнэ
204. Верошпирон нь:
1. Альдостероны эсрэг үйлчлэлтэй
 2. Захын андрогены эсрэг үйлчилнэ
 3. Тестостероны нийлэгжилтийг саатуулна
 4. Эмчилгээний үйлчлэл нь 25-50мг-аас эхэлнэ
 5. Өндөр тунгаар уухад ходоод өвдөж, огиулж бөөлжиж болно

205. Удаан хугацаагаар үргэлжилсэн өндгөвчийн хатуурал-уйланхайжлын хам шинжийн үед:
1. Өндөр нягтрал бүхий липопротеинуудын агууламж ихэснэ
 2. Бага нягтрал бүхий липопротеинуудын агууламж ихэснэ
 3. Артерийн даралт буурна
 4. Умайн салстад хэт зузаарлын өөрчлөлт явагдана
 5. Инсулин багасна
206. Өндгөвчийн эрт цуцах (эрт дутагдах) хам шинж үүсэхэд-хүргэх шалтгаан нь:
1. Удамшлын нөхцлөөр өндгөвчинд анхнаасаа цөөн фолликул үүсэх
 2. Нөхөн үржихүйн насанд фолликулын сөнөрөл хэт идэвхитэй явагдах
 3. 6 Гр-ээс их туяаны үйлчлэлээр
 4. Гахайн хавдраар өвдсөнөөс
 5. Циклофосфамид хэрэглэснээс
207. Пролактин ихсэлтийн үеийн эмнэл зүйн шинжэд хамаарагдахгүй нь:
1. Хөхнөөс сүү төст ялгарал гарах
 2. Эстроген ихдэлийн шинж илэрнэ
 3. Биений юмны мөчлөг алдагдана
 4. Гонадотропин ихэснэ
 5. Өнчин тархи хэмжээний хувьд томорч болно
208. Пролактин ихсэлтийн эмчилгээнд хамаарахгүй нь:
1. Бромокриптин 1,25 мг-аар уулгах
 2. Лизурид 0, 1 мг-аар уулгах
 3. Жирэмслэхийг хүсвэл эм бэлгийн эсийн гадагшлалтыг сэдээх
 4. Бусерелин хоногт 200 мкг-аар тарих
 5. Транссфеноидальная аденоэктомиа
209. Биеийн юм 10 хоног саатсан тохиолдолд шалтгаалж болох хүчин зүйлсийг тодруулна уу.
1. Умайн салстын хурц үрэвсэл
 2. Жирэмсэн
 3. Эндометриоз
 4. Өндгөвчинд шар бие удаан хадгалагдсанаас үйл жиллагаа нь хямарсан бол
 5. Умайн салстын доор байрлалтай миома
210. Эндометриозын эмчилгээнд хамаарах нь:
1. Мэс заслын эмчилгээ
 2. Эстроген-гестаген хавсарсан эмээр
 3. Дан гестагены бэлдмэлээр
 4. Релизинг гонадотропины адил үйлчлэлтэй эмээр
 5. Дархлал дэмжих эмүүдээр

211. Эстроген дааврын биологийн үйлчлэл нь:
1. Умайн салстад шүүрлийн өөрчлөлт үүсгэнэ
 2. Умайн салстыг зузааруулна
 3. Умайн салстын тэжээлийг сайжруулна
 4. Умайн булчинг агшаана
 5. Үрийн хөдөлгөөний идэвхийг бууруулна
212. Гестаген дааврын биологийн үйлчлэл нь:
1. Умайн салстыг зузааруулна
 2. Умайн салстад шүүрлийн өөрчлөлт үүсгэнэ
 3. Умайн булчинг агшаана
 4. Умайн салстын тэжээлийг сайжруулна
 5. Үрийн хоолойн хөдөлгөөний идэвхийг ихэсгэнэ
213. Эр бэлгийн даавар (андроген) хаана синтезлэгдэх вэ?
1. Өндгөвчний тулгуур эд, тека эсүүдэд
 2. Бөөрний дээд булчирхайн холтослог давхрын торлог хэсэгт
 3. Уушиг, арьс, өөхөнд
 4. Бөөрний дээд булчирхайн тархилаг давхрагын эсүүдэд
 5. Өндгөвчийн фолликулын мөхлөгт эсүүдэд
214. Бие махбодид андрогены ихдэлтээс хамаарч илрэх эмнэлзүйн шинж нь:
1. Гирсутизм
 2. Хөх жижигрэх
 3. Биений юмгүйдэл
 4. Гипертрихоз
 5. Гиперменоррея
215. Үйл ажиллагааны сорилуудыг ямар зорилгоор ашиглаж болох вэ?
1. Биений юмны мөчлөгийн аль шатлал болохыг тогтооход
 2. Бие махбодийн эстрогены хангамжийн түвшинг тодорхойлоход
 3. Эм бэлгийн эсийн гадагшласан эсэхийг тодорхойлоход
 4. БЮМ-ийн шар биеийн шатлалын хэвийн байдалыг тогтооход
 5. Бие махбодид прогестерон дааврын үйлчлэл байгаа эсэхийг тодорхойлоход
219. Хамгийн найдвартай жирэмслэхээс хамгаалах аргууд нь:
1. Хуанлийн арга
 2. Ууж хэрэглэдэг хавсарсан дааврын бэлдмэлүүд
 3. Үтрээ угаах арга
 4. Депо-провера 3 сарын хугацаатай тарьж хэрэглэх
 5. Спермицид үйлчилгээтэй эмүүд хэрэглэх
220. Заг хүйтний гаралтай аарцгийн гялтангийн үрэвсэлд хамаарагдахгүй шинжүүд нь:
1. Наалдац сорвижилт үүсгэх хандлагатай

2. Голдуу үрэвсэл хязгаарлагдах төлөвтэй
 3. Хэвлийн доод хэсгээр гялтан цочролын шинж илэрч болно
 4. Зөвхөн нэг талын дайврыг хамарч үрэвсүүлнэ
 5. Үүсгэгч бэлгийн замаар халдварлана
221. Бэлгийн замаар дамжих халдварын үүсгэгчид хамаарахгүй нь:
1. *Chlamidia trachomatis*
 2. *Neisseria gonorrhoeae*
 3. *Trichomonas vaginalis*
 4. *Lactobacillus crispatus*
 5. *Candida albicans*
222. Умайн үйл ажиллагааны цус алдалтын шалтгаанд хамаарахгүй нь:
1. Фолликулын эрт сөнөрөл
 2. Салстын дор байрлалтай миомын жижиг зангилаа
 3. Эм бэлгийн эс гадагшлаагүйн учир
 4. Умайн салстын үрэвсэл
 5. Шар биеийн шат удаан үргэлжлэх
223. Умайн салстад шүүрлийн өөрчлөлт явагдах боломжтой, БЮМ нь:
1. Эм бэлгийн эсийн гадагшлалттай биений юмны мөчлөг
 2. Умайн салстад хэт зузаарал үүссэн бол
 3. Шар биеийн даавар хэвийн үйлчилсэн бол
 4. Эм бэлгийн эсийн гадагшлалтгүй биений юмны мөчлөг
 5. БЮМ-ийн 2-р шатны төгсгөлд умайн салстын зузаан 5 мм байвал
224. Умайн цус алдалт меноррагийн хэлбэрээр ажиглагдсан бол байж болох шалтгаан нь:
1. Фолликул өсч томроод удаан хадгалагдсанаас
 2. Өндгөвчинд фолликул эхэлж боловсрох нь оройтож явагдсанаас
 3. Шар бие үүсэх нь удааширснаас
 4. Умайн салстын архаг үрэвсэлтэйн улмаас
 5. Умайд гялтан дор байрлалтай миомын зангилаатай тохиолдолд
225. Судасны бөглөрөл (тромбоз) үүсэх эрсдэлд хамаарагдахгүй нөхцөл байдал:
1. Эстроген агуулсан жирэмслэхээс хамгаалах эмүүд
 2. 45-аас дээш насанд
 3. Антитромбин III, протеин 5, протеин С-гийн төрөлхийн дутагдалтай
 4. Бага молекулын гепарин эмчилгээ хийгдэж байгаа бол
 5. Гипергомоцистеинемия
226. Хэвлийн дурангийн мэс засал хийх явцад гарч болох хүндрэл нь:
1. Гэдэс гэмтэх
 2. Давсаг гэмтэх
 3. Том судсууд гэмтэх
 4. Цус алдах

5. Трокар хэвлийн ханыг бүрэн нэвтрэхгүй байх
227. Мэс заслын оёдлын орчин үеийн сайн чанарын утсанд үл тооцогдох нь:
1. Монокрил
 2. Викрил
 3. Дексон
 4. Кетгут
 5. Панакрил
228. Умай авах мэс заслын заалтуудад хамаарагдах нь:
1. Аденомиоз 3,4 зэрэг
 2. Миомын улмаас гидронефроз үүссэн үед
 3. Саркома
 4. Эмийн эмчилгээ, Мирена систем болон умайн салстыг түлж эмчлэхэд үр дүн өгөөгүй умайн үйл ажиллагааны цус алдалтын үед
 5. Умайн унжилт
229. Үтрээгээр умай авах мэс заслын эсрэг заалтад хамаарахгүй нь:
1. Умайн хөдөлгөөн бага
 2. Дайврын үүсвэртэй
 3. Умайн хүзүүний өмөнтэй
 4. Умай хавдрын хамт 7-8 долоо хоногтой жирэмсний хир томорсон
 5. Умай хавдрын хамт 500 гр-аас их жинтэй
230. Умайн миомын шинж байдалд үл тохирох үзүүлэлт нь:
1. Дааврын хамааралтай
 2. Төрөх насны эмэгтэйчүүдэд 20% хүртэл тохиолдоно
 3. 40-өөс дээш насны эмэгтэйчүүдэд 20-50% тохиолдоно
 4. Саркомд шилжих эрсдэл маш өндөртэй
 5. Миома үүсэхэд удамшлын нөхцөл нөлөөлнө
231. Миома дегенератив өөрчлөлтөнд орсон тохиолдолд:
1. Гиалинжиж, уайланхай байдалтай болно
 2. Үхжил болох хэлбэрээр явж болно
 3. Шохойжиж болно
 4. Хэмжээ нь жижгэрч илааршина
 5. Эмгэг шинжүүд нь арилна
232. Миомын үеийн мэс засал эмчилгээний заалтад хамаарагдахгүй нь:
1. Хэмжээ том, > 14 долоо хоног
 2. Хурдан ургалттай бол
 3. Миомын зангилааны тэжээл дутагдаж хямарсан үед
 4. Миомын өсөлт жигд 1-2 долоо хоногтой жирэмсний хирээр нэмэгдэж байвал
 5. Хөлтэй миомын зангилаа

233. Энгийн миомын үед хийгдэх мэс засал эмчилгээний хэлбэрт хамаарагдахгүй нь:
1. Умай авах
 2. Умайг үтрээний дээгүүр тайрах
 3. Умай дахь миомын зангилааг авах
 4. Умайг дайврууд ба аарцгийн тунгалагийн булчирхайн хамт авах
 5. Умайн ёроолыг тайрах
234. Вагинозын оношлогоонд ач холбогдолтой нь:
1. $\text{PH} > 4,5$
 2. Түлхүүр эс
 3. Үтрээний ялгаралд КОН 10%-ийн уусмал дусааж үзэхэд эвгүй үнэр мэдэгдэнэ
 4. Үтрээний ялгарал наалдамхай, сааралдуу өнгөтэй болсон байна
 5. Наалдацын шинжилгээнд цагаан эсийн тоо олон
235. Мөөгөнцрөөр үүссэн үтрээний үрэвслийн эмчилгээнд хамаарахгүй нь:
1. Триазолууд болон имидазолуудаар эмчилнэ
 2. Заавал нөхөртэй нь хамт эмчилнэ
 3. Жирэмсэн үед натомицин 100 мг-аар 1 удаа ууж хэрэглэж болно
 4. Эмчилгээний дараа заавал хяналтын шинжилгээ авна
 5. Флюконазол 150 мг-аар 1 удаа ууж хэрэглэж болно
236. Умайн хүзүүний эсийн шинжилгээний наац бэлтгэхэд материал авах хамгийн боломжийн талбар нь:
1. Умайн хүзүүний гадна талаас
 2. Умайн хүзүүний салстын шилжих бүслүүр орчмоос
 3. Үтрээний салстаас
 4. 40-өөс дээш насны эмэгтэйчүүдэд умайн хүзүүний сувгаас
 5. Үтрээний ялгадсаас
237. Шерешевский – Тернерийн хам шинжийн үед илрэх шинжүүдийг тэмдэглэнэ үү?
1. Зүрхний төрөлхийн гажиг
 2. Биеийн өсөлт үеийнхнээсээ хоцрогдонгуй
 3. Хүзүү богино
 4. Кариотип 45 X 0
 5. Мэнгэ толбо ихтэй
238. Өсвөр насны охидод дараах жирэмслэхээс хамгаалах асргуудын алийг зөвлөх вэ?
1. Хуанлийн
 2. Дааврын эмүүд
 3. Охидын ерөндөг
 4. Кондом

5. Суулгац

239. Охидын умайн үйл ажиллагааны цус алдалтын үед ялган оношловол зохих эмгэгүүдэд:

1. Өндгөвчийн хатуурал-уйланхайжлын хам шинж
2. Дааврын идэвхижилтэй хавдар
3. Верльгоффын өвчин
4. Ихсийн ургацаг (полип)
5. Үр зулбалт

240. Бэлгийн бойжилт урьтаж явагдаж байгаагийн шинж илэрсэн охидод эмгэгийн шалтгааныг тодруулахаар зайлшгүй хийгдэх шинжилгээ нь:

1. Бага аарцгийн эрхтнүүдийг чанд авиан шинжилгээгээр тодорхойлох
2. Гонадотропины даавруудыг цусанд тодорхойлох
3. Ясны насыг рентген шинжилгээгээр тодорхойлох
4. Эмэгтэйчүүдийн тусгайлсан үзлэг хийх
5. Умайн хүзүүний сувгаас эсийн шинжилгээ хийх

241. Мөөгөнцөрөөр үүссэн үтрээний үрэвслийн эмчилгээнд үр дүнтэй эм

1. Низорал
2. Клотриденк
3. Дюфлюкан
4. Флагил
5. Метронидазол

242. Умайн хүзүүний өмөнг илрүүлэхэд хамгийн мэдээлэл сайтай арга нь

1. Умайнхүзүүнийсувгааснянгийнөсгөвөрхийх
2. Умайнхүзүүнийсувагбагадаргуунааснаацбэлтгэжэсийншинжилгээх
ийх
3. Умайг дурандаж шинжлэх
4. Умайнхүзүүнийсалстадэдийншинжилгээхийх
5. Үтрээг дурандаж шинжлэх

243. Умайн хүзүүний шилжих хувьслыг эмчлэх аргууд

1. Умайн хүзүүг Штрюмфдорфын аргаар хуних
2. Умайн хүзүүг өөлөх
3. Умайн хүзүүний салстад антибиотик тарих
4. Электроконизаци
5. Умайн хүзүүий салстыг төлжүүлэх тосон эмчилгээ хийх

244. Гестагены дааврын жирэмслэхээс хамгаалах аргын үйлчлэх механизм

1. Харааны товгор-өнчин тархи-өндгөвчийн тогтолцоонд нөлөөлнө
2. Умайн хүзүүний салиаг өтгөрүүлнэ
3. Үрийн хүзүүний салиаг өтгөрүүлнэвчийн тогтох
4. Умайн салстын зузаарлыг саатуулна
5. Гонадотропны дааврийн ялгарлыг ихэсгэнэ

245. Эстроген даавар нь:
1. Умайн салстад шүүрэл үүсгэнэ
 2. Умайн булчинг агшаана
 3. Дулааны төвд нөлөөлнө
 4. Умайн салстыг зузааруулна
 5. Умайн хүзүүний салиаг өтгөрүүлнэ
246. Анхдагчаар биений юм өвдөлттэй ирдэг нь:
1. Умайн хөгжил дутагдалтай
 2. Умай хазайж байрласан
 3. Простогландинууд их үүссэнээс
 4. Эм бэлгийн эсийн гадагшлалтаас
 5. Витамин Е дутагдсанаас
247. Хорионэпителиомыг оношлох аргуудыг нэрлэнэ үү
1. Бага аарцгийн эрхтний хэт авиан шинжилгээ
 2. Цусанд ХГД тодорхойлох
 3. Цээж гэрэлд харах
 4. СТ хэвлийн
 5. Пиелография
248. Умайн хоргүй хавдрын үед мэс засал хийх заалтыг нэрлэнэ үү?
1. Цус багадалттай биений юм их ирэх
 2. Хавдар түргэн явцтай томорч байгаа
 3. Хавдарын хэмжээ жирэмсний 12 долоо хоногоос том
 4. 1 жилийн турш үргүйдэлтэй байгаа
 5. Цэвэршилтын насанд умайн хоргүй хавдар илэрсэн
249. Умайн хоргүй хавдарын хортой хавдарт шилжих үед илрэх шинж тэмдгийг нэрлэнэ үү
1. Дааврын эмчилгээнд үр дүнгүй
 2. Цэвэршилтийн дараах үед миома томрох
 3. Миомын хэмжээ багасах
 4. Нөхөн үржихүйн насанд миомын хэмжээ хурдацтай томрох
 5. Биений юм дахилттай , их ирэх
250. Умайн салстын хэт зузаарах шалтгаан:
1. Даавар ялгаруулагч хавдар
 2. Эстроген удаан хугацаагаар хэрэглэх
 3. Архаг анаовуляци
 4. Умайн салстын архаг үрэвсэл
 5. ДХЭ удаан хугацаагаар хэрэглэх
251. Хориокарциномыг эмчлэх үндсэн аргыг заана уу?
1. Мэс заслын
 2. Зайн туяа эмчилгээ

3. Дааврын эмчилгээ
 4. Нэг болон олон эмийн хослолт хими эмчилгээ
 5. Шинж тэмдэгээр эмчлэх
252. Умайн хүзүүний эсийн шинжилгээнд хүнд хэлбэрийн гаж хувирал (CINIII) илрэсэн бол ямар өөрчлөлтүүд аилрэх вэ?
1. Суурин болон суурин орчмын эсүүд эвэршиж зузаарна
 2. Эсүүдийн цөм хромоор хэт будагдана
 3. Эсүүдийн эгнээт байдал алдагдана
 4. Гадаргуугийн эсүүдийн эвэрших шинж тод илэрнэ
 5. Олон үет хавтгай хучуурын 1/3 гэмтсэн байна
253. Өндгөвчийн хучуурын хортой хавдар үүсэхэд нөлөөлөх хүчин зүйлсийг нэрлэнэ үү?
1. Цөөн хүүхэд төрүүлэх
 2. Өндгөн эс архагаар гадагшлахгүй байх
 3. Удамшлын өгүүлэмж
 4. Өндгөвчийн архаг үрэвсэлтэй байсан
 5. Олон бэлгийн хавьтагчтай байх
254. Пралактинеми болсон үед илрэх эмнэл зүйн шинжийг нэрлэнэ үү?
1. Умай жижигрэх
 2. Биений юмгүйдэл
 3. Пролактины хэмжээ нэмэгдэх
 4. Үсжих
 5. Өндгөвч томрох
255. Хоёрдогч биений юмгүйдэлд хамаарахгүйг нэрлэнэ үү?
1. Пролактинома
 2. Дермояд
 3. Өндгөвчийн олон уйланхайжих хам шинж
 4. Мюллерын агенези
 5. Киари-Фроммелийн хам шинж
256. Умайн салстын өмөнгийн урьдал эмгэгд хамаарахыг нэрлэнэүү
1. Умайн салстын хатингиршил
 2. Хэв шинжгүй хэт зузаарал
 3. Булчирхайлаг хэт зузаарал
 4. Булчирхайлаг ургацаг
 5. Умайн салстын архаг үрэвсэл
257. Цэвэршилт үүсэх эмгэг жамд хамаарахыг тэмдэглэнэ үү?
1. ФСГ даавар буурах
 2. Эстрогены хэмжээ багасах
 3. Пролактин нэмэгдэх
 4. ГТД нэмэгдэх

5. Андрогены хэмжээ буурах
258. Биений юм саатах шалтгааныг нэрлэнэ үү?
 1. Умайн салстын хурц үрэвсэл
 2. Жирэмсэн
 3. Эндометриоз
 4. Дааврын үйл ажиллагааны хямрал
 5. Умайн салстын доор байрлалтай миома
259. Үйл ажиллагааны сорилуудын зорилго:
 1. БЮМ-ны мөчлөгийн аль шатлалыг тогтоох
 2. Эстроген дааврын ханамжийн түвшинг тодорхойлох
 3. Эм бэлгийн эсийн гадагшласан эсэхийг тодорхойлох
 4. БЮМ-ийн шар биеийн шаьны байдалыг үнэлэх
 5. Прогестерон дааврын үйлчлэл байгаа эсэхийг тодорхойлох
260. Умайн хүзүүний дисплазийг эмчлэх аргууд
 1. Умайн хүзүүг Штурмдорфын аргаар хуних
 2. Умайн хүзүүг өөлөх
 3. Умайн хүзүүний салстад антибиотик тарих
 4. Электроконизаци
 5. Умайн хүзүүий салстыг төлжүүлэх тосон эмчилгээ хийх
261. Аденомиозын IV-р зэргийн үед хийгдэх эмчилгээг нэрлэнэ үү?
 1. Эстроген- гестагены хавсарсан эмээр
 2. Гестагены эмээр
 3. Андрогены эмээр
 4. Мэс заслын эмчилгээ
 5. Дурангийн мэс заслын арга
262. Цэвэршсэнээс хойш эрт үед өндгөвчийн үйл ажиллагаа ямар байх вэ?
 1. Өндгөвчийн үйл ажиллагаа бүрэн зогсоно
 2. Өндгөвчинд өндгөн эс боловсрох ажиллагаа нь зогсоно
 3. Өндгөвчинд даавар боловсрох ажиллагаа нь зогсоно
 4. Өндгөвчийн ажиллагаа буурах боловч өндгөн эс, даавар боловсруулах ажиллагаа 3-5 жилд багаар явагдана
 5. Дээрх бүгд хамааралтай
263. Биений юм ирэхийн өмнөх хам шинжийн үндсэн эмчилгээ нь:
 1. Даавар эмчилгээ
 2. Мэдрэл- сэтгэцийг тайвшруулах эмэн эмчилгээ
 3. Өндгөвчийг тайрах мэс засал эмчилгээ
 4. Дархлаа дэмжих эмчилгээ
 5. Мэс заслын эмчилгээ
264. Умайн үйл ажиллагааны цус алдалт оношоор эмчлүүлсэн 40 настай эмэгтэйд дахилтаас сэргийлж ямар эмчилгээ сонгох вэ?

1. БЮМ-ийн 5-25 дахь хоногт регивидон 3 сар уулгах
 2. БЮМ-ийн 5-25 дахь хоногт норколут 5 мг-р 3 сар уулгах
 3. Метилтестостэрон 5 мг-р өдөрт нэг удаа хэлэн дор тавьж 2-3 сар хэрэглэнэ.
 4. БЮМ-ийн 16-25 дахь хоногт норколут 5 мг-р 3 сар уулгах
 5. БЮМ-ийн хугацаанд цусны бүлэгнэлт сайжруулах эмчилгээ хийнэ.
265. Цэвэршилтийн хамийн шинжийн аль нь бодит шинж тэмдэгт хамаарагдах вэ?
1. Халуун оргиж хөөрөх
 2. Хөлрөх
 3. А/Д ихдэлт
 4. Ясны сийрэгжил
 5. Нойргүйдэл
266. Шерешевский-Тернерийн хам шинжийн эмнэл зүйн шинжүүд болон шинжилгээний үзүүлэлт нь:
1. Зүрхний төрөлхийн гажиг
 2. Биеийн өсөлт үеийнхнээсээ хоцрогдонгуй
 3. Хүзүү богино
 4. Кариотил 45х0
 5. Мэнгэ толбо ихтэй
267. Өндгөвчийн ажиллагааг үнэлж болох үйл ажиллагааны сорилыг нэрлэнэ үү?.
1. Умайн хүзүүний саластад үнэлгээ өгөх
 2. Прогестероны сорил
 3. Умайн салстын шинжилгээ
 4. ДНХ- тодорхойлох полимераз гинжин урвалын шинжилгээ
 5. Умайн хүзүүг дурандах
268. Умайн үйл ажиллагааны цус алдалтанд хүргэх шалтгаан нь:
1. Умайн саластын архаг үрэвсэл
 2. Эм бэлгийн эсийн гадагшлалтгүй байх
 3. Умайн хүзүүний шархлаа
 4. Өндгөвчийн шар биеийн хөгжил дутуу явагдсанаас
 5. Виллибрандын өвчин
269. Биений юмгүйдлийн үед прогестроны сорил эерэг байх нь
1. Эстроген бага байгааг илэрхийлнэ
 2. Прогестроны дутагдлыг илэрхийлнэ
 3. Гонадотропин даавруудын дутагдлыг илэрхийлнэ
 4. Умайн шалтгааныг илэрхийлнэ
 5. Өндгөвчийн гүнзгий дутагдал байгааг илэрхийлнэ
270. Нянгийн вагинозын оношлогоонд хамаарагдах нь:
1. Толины үзлэгээр үтрээний ялгадас ихэссэн
 2. Түлхүүр эс

3. Үтрээний хана улайсан
 4. КОН-ын сорил эерэг
 5. pH 5.0
271. Гистеросальпингографи шинжилгээнд хэрэглэх тододгогч бодисуудаас аль нь эх барих эмэгтэйчүүдийн практикт эрсдэл багатай вэ?
1. Тосон йодолипол
 2. Усан диодон
 3. Усан верографин
 4. Усан кардиотраст
 5. Тосон липиодол
272. Гистеросальпингографи хийх үед рентген зургийг хэдийд авах вэ?
1. Ажилбарын дараах 30 минутад
 2. Ажилбар дуусмагц
 3. Ажилбарын дараах 15 хоромд
 4. Ажилбарын дараах 5-8 хоромд
 5. Ажилбараас хойш 24 цагийн дараа
273. Марсупиализаци мэс ажилбарын зорилго нь юу вэ?
1. Хурсан шингэн, идээрийг гаргах
 2. Бартолин булчирхайд цорго шинээр үүсгэх
 3. Бартолин булчирхайг авах
 4. Бартолин булчирхайг үлдээх
 5. Бартолин булчирхайг буглааны гэрийн хамт авах
274. Умайг хүзүүний дээгүүр тайрах эсхүл умайг авах мэс заслын үед шээлгүүр (ureter) гэмтэж болох байрлалыг тэмдэглэнэ үү?
1. Умайн хажуу доод хэсгээр
 2. Умайн хүзүүний дотор амсрын түвшинд
 3. Умайн хүзүүний гадна амсрын түвшинд
 4. Өндгөвчийн захаар
 5. Умайн гуурсны захаар
275. Умайг хүзүүний дээгүүр тайрах эсвэл энгийн умай авах мэс заслын үед боож салгах ёстой судасыг тэмдэглэнэ үү?
1. R. ovaricus
 2. Aa. vaginales
 3. Ra. ascendens uterinae
 4. A. ovarici
 5. A. uterine
276. Төрөлтийн үед, умайд В-Lynch тавихад мөрдөх нийтлэг зарчмыг тэмдэглэнэ үү?
1. Оёдлын утас нь 14 хоногоос дотогш хугацаанд хайлах чанартай байх
 2. Ажилбарын дараа хэвлийн хөндийд хяналтын гауурс тавих

3. Антибиотик эмчилгээ хийх
 4. Эрчимт эмчилгээнд 24 цаг хянах
 5. Мэс заслын дараа 2 цагийн зайтай хэт авиан шинжилгээгээр хянах
- 277.Өндгөвчийн уйланхай хөл дээрээ мушгирсан тохиолдолд уйланхайг авахдаа хавчуур тавих хэсгийг тэмдэглэнэ үү?
1. Мушгирсан хөлийн өндгөвч талд тулгаж хавчуур тавьна
 2. Мушгирсан хөлийн умай талд тулгаж хавчуур тавьна
 3. Хөлийн мушгирааг эргүүлж гаргаж тэгшлээд хавчуур тавьна
 4. Хөлийн мушгирааг эргүүлж гаргахаас өмнө хавчуур тавьна
 5. Уйланхайг цоолж соруулсны дараа хавчуур тавьна
- 278.Умайг үтрээний дээгүүр тайрах мэс заслыг хийхдээ умайг хүзүүнээс нь тайрч салгах байршлыг тэмдэглэнэ үү?
1. Умайн хүзүүвчийн түвшинд тайрна
 2. Умайн хүзүүний дотор амсрын түвшинд тайрна
 3. Умайн боосон судасны доогуур тайрна
 4. Умайн боосон судасны дээгүүр тайрна
 5. Умайн хүзүүний гадна амсрын түвшинд тайрна
- 279.Эмэгтэйчүүдийн мэс заслын үед шээлгүүр (ureter) гэмтэхээс сэргийлэх аргыг тэмдэглэнэ үү?
1. Шээлгүүрийн анатомийн байршлыг мэдэж байх
 2. Хавчуураа умайн хавирганд нягт шахаж тавих
 3. Умайг тавих багажны эсрэг талруу, дээш нь татаж барих
 4. Умайг тавих багажны талруу, доош нь дарж өгөх
 5. Хавчуураа умайн хажуу талд зэрэгцүүлж тавих
- 280.Умай дайврын мэс заслын үед шээлгүүр (ureter) гэмтсэн эсэхийг шалгах аргыг тэмдэглэнэ үү?
1. Давсагт тавьсан гуурсаар шээсний хэмжээг хянах
 2. Бага аарцагын гялтангийн доорх шээлгүүрийн гүрвэлзэх хөдөлгөөнөөр
 3. Давсагт тавьсан гуурсаар гарах шээсний өнгийг шалгах
 4. Их аарцгаас доошлон бага аарцагт орж ирсэн шээлгүүрийг гаднаас нь цочроож шалгах
 5. Татагдсан lig. suspensorium ovarii-ийг суллах
- 281.Үтрээн хүрцээр умай авах мэс заслын зөв дараалалыг тэмдэглэнэ үү?
1. Давсаг үтрээний нугалаасаар үтрээг нээнэ.
 2. Lig. supravaginale-ийг салгана
 3. Plica vesicouterina-г ил гаргана
 4. Lig. vesicouterina-г салгана
 5. Spatium vesicocervicale-г нээнэ
- 282.Бага насны охиноо эмчид үзүүлэхээр эх эцэг нь авчирлаа. Охиныг үзэх эмч зөвшөөрөл авах уу, авах бол хэнээс авах вэ?

1. Эх эцэг нь хоёулаа байхад зөвшөөрөл авах шаардлага байхгүй
2. Эх эцэг хоёулангаас нь зөвшөөрөл авна
3. Охин өөрөөс нь зөвшөөрөл авна
4. Хэн нь хүүхэддээ илүү ойр дотно байдагаас нь зөвшөөрөл авч болно
5. Эмч өөрөө шийдээд үзлэгээ хийнэ

283. Хэвлийн мэс заслын явцад давсагны аль тал, хаана гэмтэж болох вэ?

1. Умайг дайвараас салгах үед давсагны хажуу хана гэмтэх
2. Хэвлийн хөндийг нээх үед давсагны урд, хажуу урд хана гэмтэх
3. Умайн хөндийг нээх үед давсагны орой хэсэг гэмтэх
4. Давсаг умайн нугалаас нээх үед давсагны ар хана гэмтэх
5. Давсаг умайн нугалаас нээх үед давсагны ёроол хэсэг гэмтэх

284. Давсаг гэмтэж хөндий нь нээгдсэн үед гэмтлийг оёж битүүлэх арга нь тэр хэсгийн хананы нимгэн, зузаанаас хамаардаг. Тохирох аргыг тэмдэглэнэ үү?

1. Эхний эгнээ оёдлыг булчин – булчинд
2. Эхний эгнээ оёдлыг салст – булчинд
3. Эхний оёдлыг салст – булчин – гялтанд
4. Хоёр дахь эгнээг гялтан – гялтанд
5. Хоёр дахь эгнээг булчин – гялтанд тавина

285. Мэс заслын үед давсагны гэмтлийг оношлох аргыг тэмдэглэнэ үү?

1. Давсагны шархаар шээс гарч харагдах
2. Шээсний сүвээр хийсэн катетер давсагны шархаар гарах
3. Давсагт шахсан метелин хөх давсагны шархаар гарах
4. Эхо-д давсаг шээсгүй байх
5. Шээсний шинжилгээнд цусны улаан эс гарах

286. Умайг үтрээний дээгүүр тайрах мэс заслын үед, давсаг-умайн хүзүүний нугалаасыг нээсний дараа бас нэг холбогч эдийг салгадаг. Ингэсний дараа давсагны ар хормой маш амархан доошоо бууж, мэс заслын талбайгаас холддог. Энэ холбогч эдийн нэрийг тэмдэглэнэ үү?

- A. Lig. vesicocervicalis
- B. Fascia vesicacervicalis
- C. Fascia pubovesicalis
- D. Septum supracervicalis
- E. Fascia pubovesicacervicalis

287. Умайгаас мөчлөггүй цус алдах шалтгааныг нэрлэнэ үү:

1. Ихсийн ургацаг
2. Салстын доорх зангилаа
3. Умайн сарком
4. Гялтангийн доорх зангилаа
5. Ашерманы хам шинж

290. БЮМ –ны мөчлөгийн фолликулийн үе шатанд дараах үйл ажиллагаа явагдана :
1. Умайн үйл ажиллагааны давхарга ховхрох
 2. Умайн үйл ажиллагааны давхарга нөхөн сэргэх
 3. Өндгөвчинд шар бие үүсэх
 4. Цусанд эстроген дааврын хэмжээ нэмэгдэх
 5. Өнчин тархинд ФСГ дарангуйлагдах
291. Өндгөвчний шар биеийн үйл ажиллагааны алдагдлыг оношлох аргыг тэмдэглэнэ үү?
1. Суурин халуун үзэх
 2. Умайн салстын биопсийн шинжилгээгээр
 3. Цусанд агуулагдах прогестерон дааврын түвшингээр
 4. Өндгөвчинд үүсэн доминант фолликулаар
 5. Цусанд БЮМ –ны 4 дэх хоногт цусанд ФСГ тодорхойлох
292. Бэлгийн дааврыг хүлээн авах бай эрхтэнг нэрлэнэ үү:
1. Умай
 2. Өндгөвч
 3. Гуурсан хоолой
 4. Элэг
 5. Яс
293. Үтрээний цэвэршилтийн 2- зэрэгт хамаарахыг нэрлэнэ үү?
1. Наацын шинжилгээнд хучуур эс их
 2. Үтрээний орчин хүчиллэг
 3. Үтрээнд савханцар байх
 4. Харах талбайд цагаан эсийн тоо цөөн байна
 5. Кокк их хэмжээтэй байх
294. Бэлэг эрхтний эндометриозийг оношлох арга:
1. Хэт авиан шинжилгээ
 2. Хэвлийн дурандалт
 3. Үтрээн дурандалт
 4. Үтрээний ялгарлаас бактериолог шинжилгээ авах
 5. Умайн салстын эдийн шинжилгээ
295. Умайн үйл ажиллаганы цус алдалттын хожим үүсч болох эмгэгийг нэрлэнэ үү?
1. Умайн салстын өмөн
 2. Өндгөвчийн хавдар
 3. Хөхний хавдар
 4. Дутуу төрөлт
 5. Төрөх үйл ажиллагааны гажуудал

296. Умайн салстын өмөнгийн тархалтыг тогтоох оношилгооны аргыг нэрлэнэ үү?
1. Умайн салстын эдийн шинжилгээ
 2. Рентгенскопи
 3. Умайн дурандалт
 4. Хэвлийн дурандалт
 5. Колоноскопи
297. Өндгөвч уйланхайжих хам шинжийн эмнэл зүйн шинжийг тэмдэглэнэ үү?
1. БЮМ алдагдах
 2. Гирсутизм
 3. Таргалалт
 4. Үргүйдэл
 5. Батгаших
298. Цэвэршилтийн хам шинжийн явцыг хүндрүүлэх хүчин зүйлийг нэрлэнэ үү?
1. Умайд ерөндөгтэй байх
 2. Стресс
 3. Эстроген хэрэглэхэд
 4. Эрхтэн тогтолцооны эмгэг
 5. Гестаген хэрэглэхэд
299. Цэвэршсний дараа ямар эмгэг илүүтэй тохиолддог болохыг нэрлэнэ үү?
1. Умайн салстын өмөн
 2. Сэтгэл гутрал
 3. Яс сийрэгжих
 4. Бөөрний эмгэг
 5. Амьсгалын замын эмгэг
300. Үтрээний үрэвсэл үүсэхэд нөлөөлөх дотоод хүчин зүйлс
1. Гэдэсний бичил биетийн хэвийн үйл ажиллагаа өөрчлөгдөх
 2. Бэлгийн дааврын хэмжээ өөрчлөгдөх
 3. Дархлаа сулрах
 4. Урьд нь хийгдсэн бактерийн эсрэг эмчилгээ
 5. Дааврын бэлдмэл удаан хэрэглэх
301. Төрөх үед хярзан сэтлэх заалтыг нэрлэнэ үү
1. Хярзан урагдахыг завдах
 2. Өндөр хярзантай байх
 3. Том ураг
 4. Илүү тээлт
 5. Дутуу төрөлт
302. Эмэгтэйчүүдийн ямар эмгэгийн үед физик эмчилгээ хийх нь ашигтай вэ?
1. Өндгөвчийн уйланхай
 2. Цэвэршилтийн хам шинж

3. Адениомиоз
 4. Дайврын архаг үрэвсэл
 5. Умайн салстын хэт зузаарал
303. Гистеросальпингографийн шинжилгээгээр юуг тодорхойлох вэ?
1. Умайн хүзүүний дутмагшил
 2. Умайн салстын доорх хоргүй хавдар
 3. Умайн таславч
 4. Гуурсан хоолойн эмгэг
 5. Эндомиома
304. Ихсээс ялгарах даавруудыг нэрлэнэ үү үү?
1. Эстрон
 2. Кортикотропин
 3. Лактоген
 4. хорионический гонадотропин
 5. бетта эндорфин
305. Өнчин тархины хамааралтай биены юмгүйдэлд хүргэх шалтгаан
1. Симондсын хам шинж
 2. Шиханы хам шинж
 3. Акромегали
 4. Сүүжих хам шинж
 5. Кушингийн хам шинж
306. Хожуу зулбах үндсэн шалтгааныг нэрлэнэ үү:
1. Умайн хүзүүний дутмагшил
 2. Умайн дутуу хөгжил;
 3. Андроген дааврын ихсэл
 4. Хурц халдвар
 5. Үтрээний үрэвсэл
307. Цэвэршилтийн үед дараах үйл явц явагдана:
1. Өндгөвчийн фолликулуудын сөнөрөл
 2. Өндгөвчнөөс ялгарах бэлгийн даавруудын хэмжээ багасах
 3. Өнчин тархи-харааны товгорын эстрогеныг мэдрэх босго мэдрэмж өндөрсөх
 4. Өндгөвчинд нийлэгжих андрогены хэмжээ буурах
 5. Харааны товгороос ялгарах ГТ -ын рилизинг дааврын хэмжээ буурах
308. Ерөндөг тавихад тохиромжгүй нөхцөл:
1. аарцгийн эрхтний архаг үрэвсэл
 2. Олон бэлгийн хавьтагчтай байх
 3. Урьд нь умайн гаднах жирэмсэн болж байсан
 4. Умайн салстын хэвийн бус байдал
 5. Умай арагшаа байрласан байх

309. Амниоскопийн шинжилгээгээр юуг тодорхойлох вэ?

1. Ургийн шингэний хэмжээ
2. Ургийн шингэний өнгө
3. Илүү тээлт
4. Түрүүлсэн хэсэг
5. Амьгүй ураг

310. Цэвэршилтийн үеийн бодисын солилцооны хямралыг илэрхийлэх шинжүүд:

1. Артерийн даралт $> 130/85$
2. Бүсэлхийн болон гуяны тойргийн харьцаа $> 0,85$
3. Өлөн үеийн сахарын түвшин цусанд > 110 мг/дл
4. БЖИ нэмэгдэх
5. Хэвлийн тойрог > 89 см

311. Мирена хэрэглэхэд тохирожмгүй хүмүүс?

1. Элэгний эмгэг
2. Гүнийн венийн тромбоз
3. Умайн хүзүүний дисплази
4. БЖҮ > 30 , тарган эмэгтэйчүүд
5. Чихрийн шижин өвчтөй

312. Ашерманы шинжийг хэрхэн оношлох вэ?

1. ЭХО
2. Гистеросальпингографи
3. Гистероскопи
4. Лапароскопи
5. Кольпоскопи

313. Умайн салстын хэт зузаарлыг аблаци хийж эмчлэх аргын эсрэг заалт:

1. Умайн хөндийн хэлбэр алдагдсан
2. Умайн хөндий өргөсч томорсон
3. 2 удаа төрсөн, дахин төрөх төлөвлөгөөтөй байгаа тохиолдолд
4. Умайн салстын хэвийн биш хэт зузаарал
5. Умайн салст үрэвссэн

314. 24 настай эмэгтэй сүүлийн 2 жил жирэмслээгүй, БЮМ тогтмол биш, хөхнөөс сүү гоожино. Ямар шинжилгээ хийх шаардлагтай вэ?

1. Турк эмээлийн зураг авах
2. Пролактин тодорхойлох
3. Харах талбайг шалгах
4. Хөхнөөс эдийн шинжилгээ авна
5. Хөхний зураг авах

315. Өндгөн эс гадагшилсныг илтгэх шинжийг нэрлэнэ үү?

1. Жирэмслэх
2. Суурин халуун нэмэгдэх

3. Прогестерон дааврын хэмжээ нэмэгдэх
 4. Умайн салстад шүүрлийн үйл ажиллагаа явагдах
 5. Биений юм ирэх
316. Ерөндөг тавих тохиромжтой нөхцөл нь :
1. Жирэмсэнээс хамгаалах урт хугацааны арга хэрэглэхийг хүсч байгаа эмэгтэй
 2. Хоёр ба түүнээс дээш хүүхэдтэй болон хөхүүл эмэгтэй
 3. 35-с дээш насны ба өдөрт 15ш-с цөөнгүй тооны тамхи татдаг эмэгтэй
 4. БЗДХ авах эрсдэл багатай эмэгтэй
 5. Умайн хоргүй хавдартай эмэгтэй
317. Мирена системийн давуу талууд
1. Жирэмслэхээс найдвартай хамгаална
 2. Умайн хүзүүний салстыг өтгөрүүлнэ
 3. Эндометрийг хатингаршуулна
 4. Нөхөн үржихүйн чадвар эргэж сэргэнэ
 5. Эр бэлгийн эсийг устгана
318. Үр дамжуулах хоолойг боох аргын давуу тал
1. өндөр үр дүнтэй жирэмсэнээс хамгаалах байнгын арга
 2. ЖХ хэрэгслийг нөөцлөх эмнэлэгт давтан хандах шаардлагагүй
 3. хөхний сүүний гарцанд нөлөөлөхгүй
 4. бэлгийн хавьталд саад учруулахгүй
 5. гаж нөлөөгүй
319. Жирэмсэнээс хамгаалах ДХЭ-ийн үйлчлэх механизм
1. Эр бэлгийн эсийг үхүүлнэ
 2. Өндгөн эс боловсорч өндгөвчнөөс гарах үйл ажиллагааг дарангуйлна
 3. Умайн хүзүүг тагласанаар үр тогтох процессийг саатуулна
 4. умайн хүзүүний салиаг өтгөрүүлнэ
 5. эр бэлгийн эсийн хөдөлгөөнийг удаашруулна
320. Жирэмсэнээс хамгаалах хаалтын аргуудыг сонгох:
1. Үтрээний шахмал лаа
 2. Үтрээний хаалт
 3. Умайн хүзүүний таглаа
 4. Бэлгэвч
 5. Наалт
321. Үр дамжуулах хоолойг боох аргуудыг сонгох
1. Померойн арга
 2. Химийн арга
 3. Дулааны арга
 4. Мадленера
 5. Механикийн арга

322. Дан прогестерон агуулсан эмийн давуу тал
1. биений юмны мөчлөг хэвийн болно
 2. Эстроген хэлэглэсэнээс үүсэх эрсдлийг нэмэгдүүлэхгүй
 3. Хөхүүл үед хэрэглэхэд гаж нөлөөгүй
 4. Умайн салстын үрэвсэлт өвчнөөс урьдчилан сэргийлэх нөлөөтэй
 5. Даралт бууруулна
323. Суулгац нь хэдэн жил жирэмсэнээс хамгаалах вэ?
- A. 3 сар
 - B. 1сар
 - C. 1 жил
 - D. 5жил
 - E. 6 сар
324. Дааврын хавсарсан эмийг хэнд хэрэглэхэд илүү тохиромжтой вэ?
1. Эндометриозтой эмэгтэй
 2. НҮ-н насны бүх эмэгтэй
 3. Түр хугацааны аргыг хэрэглэхийг хүсч буй эмэгтэй
 4. Хөхүүл эмэгтэй
 5. Зүрхний шигдээстэй эмэгтэй
330. Тестикулийн феминизацитай холбоотой зөв мэдээлэлийг нэрлэнэ үү
1. Цусны сийвэнд эстроген даавар тодорхойлогдохгүй
 2. Кариотид 47XXY
 3. Генотип нь эмэгтэй байдалтай
 4. Тестостероны авуурын эмгэг өөрчлөлт
 5. Суганы үсний хөгжил хэвийн
331. 5 альфа редуктаза ферментийн дутагдалтай аль нь хамааралтай болохыг нэрлэнэ үү
1. Тестостероны авууртай холбоотой эмгэг
 2. Кариотип ХХҮ
 3. Хөгхний хөгжил хэвийн эмэгтэй хүнийх шиг
 4. Дигидротестостерон ялгаралгүй
 5. ГБЭ хэвийн хөгжилтэй
332. Дараахаас аль нь туяаны цохилт өгдөг шинжилгээ вэ?
1. X ray
 2. СТ
 3. Барий уулгаж шинжлэх
 4. Гистеросальфингографи
 5. Лазер
333. Гистеросальфингографтай холбоотой зөв мэдээлэлийг нэрлэнэ үү
1. БЮМ -ийн шар биеийн үе шатанд хийнэ
 2. Ажилбарын өмнө жирэмсэн эсэхийг шалгана

3. ЭХО шинжилгээний хяналтанд хийнэ
 4. Анхдагч болон 2 догч үргүйдэлд хийнэ
 5. Өмнө нь хламидийн халдвар авч байсан бол эсрэг заалттай
334. Дараахаас аль нь бөөрнөөс ялгардаг вэ?
1. Тромбопозетин
 2. 1,25 дигидрохолекальциферол
 3. Эритропозетин
 4. Ренин
 5. Простогландин
336. Пролактинеми болох шалтгааныг нэрлэнэ үү
1. Метилдофа хэрэглэх
 2. Өнчин тархины аденома
 3. Өндгөвч уйланхайжих хам шинж
 4. Гипотиреоз
 5. Акромегали
337. Мюллерийн гажиг оношийг тавих үндэслэл нь:
1. Эстроген прогестроны хавсарсан сорил сөрөг
 2. Зүрхний төрөлхийн гажиг илэрсэн
 3. Цусанд ФСД-ын түвшин хэвийн
 4. Умайн хэмжээ хэвийн
 5. Бэлгийн хоёрдогч шинж хэвийн
338. Өндгөвчийн уйланхайжих хам шинжийн оношилгоонд хамаарах үзүүлэлт:
1. Инсулин дөжрөл тодорхойлогдсон
 2. Биеийн жингийн үзүүлэлт $>30 \text{ мг}^2$
 3. Өндгөвчийн эзэлхүүн $>11 \text{ см}^3$
 4. Өндгөвчинд 11-12 тооны преантраль фолликулууд байна
 5. АнтиМюллерын дааврын түвшин буурна
339. Эмэгтэй 47 настай, БЮМ алдагдаж үе үе нүүр халуун оргино, хөлөрнө гэсэн зовуурьтай. Дараах эмчилгээнүүдээс алийг хэрэглэж болох вэ?
1. Эстрадиол валерат 2 мг/норгестрел 0,5 мг
 2. Фемостон 2/10
 3. Премарин 0,625 мг + дидрогестрон 10 мг
 4. Овестин (эстриол) 2 мг .
 5. Джес
340. “Умайн хэвийн бус цус алдалт-Р” гэсэн урьдчилсан оноштой эмэгтэйд эхний ээлжинд сонгож хийх шинжилгээ нь:
- A. Бага аарцгийн эрхтэний СТ
 - B. Бага аарцгийн эрхтэний MRI- тодосгогчтой
 - C. Бага аарцгийн эрхтэний MRI- тодосгогчгүй
 - D. Гидросонографи

Е. Гистеросальфингографи

341. Эмэгтэй 30 настай, умайн хэвийн бус цус алдалт оноштой, хэт авиан шинжилгээгээр: хоёр өндгөвчинд 07 см хүртэл хэмжээтэй жижиг фолликулуудтай, умайн салстын зузаан 0,5 см байв. Дараах эмчилгээнүүдээс сонгож зөвлөнө үү.
1. Транексамын хүчил
 2. Нэг шатлалтай, хавсарсан дааврын эм
 3. Цус багадлын эсрэг эмчилгээ
 4. Дан прогестаген
 5. Гонадотропин агонист
342. Гестаген даавар өндгөвчийн аль эд эсд нийлэгжих вэ?
1. Өндгөн эс гадагшилсны дараах фолликулийн мөхлөгт эсүүдэд
 2. Ур маягийн эсүүдэд
 3. Шар биеийн эсүүдэд
 4. Өндгөвчийн фолликулд
 5. Өндгөвчийн судаслагийн багц орчмын эдэд
343. Пролактинеми үүсэх шалтгаан:
1. Стресс
 2. Өнчин тархины хавдар
 3. Бамбайн дутагдал
 4. Дофамины нийлэгжлийг саатуулах эмүүд
 5. Биеийн хүчний хүнд ачаалал
344. Эндометриозын эмийн эмчилгээнд хэрэглэхгүй бэлдмэл нь:
1. Гонадотропин ялгаруулагч дааврын агонист эмүүд
 2. Жирэмслэхээс сэргийлэх хавсарсан дааврын эмүүд
 3. Диеногест
 4. Этинил эстрадиол
 5. Даназол
345. Өнчин тархины шалтгаант биений юмгүйдэлийн шалгуур:
1. Цусанд тодорхойлогдох пролактины түвшин 11.5 нг/мл
 2. Гонадотропны сорил **эерэг**
 3. Биеийн харьцаа хэвийн,
 4. Цусанд тодорхойлогдох ФСД-ын түвшин 2.1 мМЕ/мл
 5. Умай ба өндгөвчийн хэмжээ хэвийн
346. Өндгөвчийн нөөцийг тодорхойлох үзүүлэлтүүд
1. Антимюллерийн дааврын үзүүлэлт
 2. Антраль фолликулийн тоо
 3. ФСД-ын түвшин (суурь)
 4. Эстрадиолын түвшин
 5. Доминант фолликулын хэмжээ